



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ**

**Цэцэн**  
**Магвандоржийн ЛХАГВАСҮРЭН**

**АРИЛЖААНЫ НЭР ТҮҮНИЙ**  
**ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ**  
**/харьцуулсан судалгаа/**



**Мэргэжлийн индекс**  
**042101**

**Эрх зүйн бакалаврын зэрэг**  
**Горилсон дипломын төсөл**

**Удирдсан**  
**М.Түвшинжаргал /Ph.D/**

**Улаанбаатар. 2024**



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ**

**Цэцэн**

**Магвандоржийн ЛХАГВАСҮРЭН**

**АРИЛЖААНЫ НЭР ТҮҮНИЙ**  
**ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ**  
**/харьцуулсан судалгаа/**

**В** Мэргэжлийн индекс  
042101

**Эрх зүйн бакалаврын зэрэг**  
**Горилсон дипломын төсөл**

Удирдагч: ..... М.Түвшинжаргал /Ph.D/

Шүүмжлэгч: ..... Д.Наранцогт /LL.M/

Улаанбаатар. 2024

## ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭЛ .....	i
ТАЛАРХАЛ .....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ .....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	v
ОРШИЛ .....	1
Сэдэв сонгосон үндэслэл .....	1
Судалгааны ажлын зорилт .....	2
Судалгааны ажлын зорилго .....	2
Сэдвийн шинэлэг тал .....	3
Сэдвийн судлагдсан байдал .....	3
Сэдвийг судалгааны арга зүй .....	4
I БҮЛЭГ.    Онолын хэсэг .....	6
1.1. Арилжааны эрх зүй салбар эрх зүй болох нь .....	6
1.2. Арилжааны эрх зүйн хамрах хүрээ, зохицуулах харилцаа .....	9
1.3. Арилжааны нэр болон барааны тэмдгийн ойлголт .....	11
1.4. Арилжааны нэрийн хуулийн хамгаалалтын онолын үндэс .....	15
II БҮЛЭГ.    Монгол улсад арилжааны нэр түүний эрх зүйн хамгаалалтыг хэрхэн зохицуулсан талаар .....	23
2.1. Монгол улсын хуулийн этгээдийн нэрийн зохицуулалт .....	23
2.1.1    Оноосон нэр сонгох түүнд тавигдах хязгаарлалтууд .....	23
2.1.2    Оноосон нэр нь бусдыг төөрөгдүүлэхгүй байх талаарх зохицуулалтууд .....	27
2.1.3    Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах үеийн зохицуулалтууд .....	28
2.1.4    Хуулийн этгээдийн нэрийг бусдад шилжүүлэх зохицуулалтууд .....	30
2.2. Монгол улсын хуулийн этгээдийн нэрийн эрх зүйн хамгаалалт болон зөрчлийн хариуцлага .....	31
2.2.1    Хуулийн этгээдийн нэрийг ашиглахтай холбоотой зохицуулалт .....	31
2.2.2    Хуулийн этгээдийн нэрд халдсан үеийн зохицуулалтууд .....	34

2.3. Монгол улсад Арилжааны нэртэй холбоотой маргааныг шүүхээр шийдвэрлэсэн байдал: .....	36
2.3.1 Анхан шатны шүүхийн шийдвэр: .....	36
2.3.2 Давж заалдах шатны шүүх: .....	38
2.3.3 Хяналтын шатны шүүх: .....	40
III БҮЛЭГ. Бусад улсуудад арилжааны нэр түүний эрх зүйн хамгаалалтыг хэрхэн зохицуулсан талаар .....	43
3.1 БНСУ-ын арилжааны нэрийн зохицуулалт болон эрх зүйн хамгаалалт .....	43
3.1.1 БНСУ-ын эрх зүйн систем ба арилжааны хууль .....	43
3.1.2 БНСУ-ын хууль тогтоомжид арилжааны нэрийг тодорхойлсон байдал ....	44
3.1.3 БНСУ-ын хууль дахь арилжааны нэрийг хамгаалах зохицуулалтууд .....	49
3.2 АНУ-ын арилжааны нэрийн зохицуулалт ба эрх зүйн хамгаалалт .....	57
3.2.1 АНУ-ын эрх зүйн систем ба барааны тэмдгийн хууль .....	57
3.2.2 АНУ-ын хуульд Арилжааны нэр болон барааны тэмдгийг тодорхойлсон байдал	59
3.2.3 АНУ-ын эрх зүйн Арилжааны нэрийг хамгаалах зохицуулалтууд .....	62
Бүлгийн дүгнэлт .....	72
ДҮГНЭЛТ .....	74
НОМ ЗҮЙ .....	77

## МЭДЭГДЭЛ

Энэхүү диплом нь миний өөрийн бүтээл бөгөөд СЭЗИС-ийн оюуны өмч болгон, дипломын төслийг сургуулийн номын сангаар дамжуулан нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Нэр: М. Лхагвасүрэн

Гарын үсэг:

Огноо: 2024.06.07

## ТАЛАРХАЛ

Энэхүү бакалаврын төслийг бичихэд гүнээ туслалцаа үзүүлсэн удирдагч багш М. Түвшинжаргал, шүүмжлэгч багш Д. Наранцогт нарт болон СЭЗИС Эрх зүйн тэмхимийн эрхлэгч Д.Оюун багш болон бусад хүндэт багш нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

## ТОВЧ ХУРААНГУЙ

Арилжааны нэр болон барааны тэмдэгт гэсэн хоёр ойлголт нь чиг үүргийн хувьд давхцах байдал түгээмэл байдаг. Жишээлбэл хоёул адилхан өөрийнхийг бусдаас ялгах, зар сурталчилгааны хэрэгсэл болох, олон нийт болон арилжааны хамтрагчтай харилцах болон бизнесийн итгэлийг илтгэх хадгалах зэрэг нийтлэг талууд байдаг. Тус хоёр ойлголт нь хоёул Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах Парисын конвенцын дагуу аж үйлдвэрийн өмчид тооцогдож эрх зүйн хамгаалалтад байхаар зохицуулагдсан байдаг. Гэсэн хэдий ч улс бүрийн хуулийн хамгаалалтын хэм хэмжээ нь харилцан адилгүй өөрөөр зохицуулагдсан байдаг.

Энэхүү ялгаатай байдлыг тоймлон судалбаас АНУ-д арилжааны нэр болон барааны тэдийг авч ашигласнаар эзэмшил үүсч хуулийн хамгаалалтад ордог бол БНСУ-д арилжааны нэр болоод барааны тэмдгийг бүртгүүлснээр эзэмших эрх үүсэх хэдий ч авч ашигласнаар бусдын саадгүйгээр ашиглах эрх үүсдэг байна. Мөн түүнчлэн АНУ-ын хувьд арилжааны нэр нь барааны тэмдгийн нэгэн адил хуулийн хамгаалалтад байх буюу улсын хэмжээнд зохицуулагдаж байх атал БНСУ-ын хувьд арилжааны нэр нь арилжааны үйл ажиллагааны нэр төдийхнөөр хязгаарлагдаж хуулийн хамгаалалтын хувьд харьцангуй сул, бүс нутгийн хэмжээнд хязгаарлагдаж байна.

Парисын конвенцоор Арилжааны нэрийг аж үйлдвэрийн өмч гэж үзэн, бүртгэл хийлгэсэн эсэхээс үл хамааран хуулиар хамгаалагдах ёстой гэж тунхагласан хэдий ч энэ нь өнөөгийн дэлхийн улсуудын эрх зүйн системд барааны тэмдэгтэй харьцуулахад давамгайл буюу онцгой эрхтэйгээр хамгаалахаар зохицуулалт хийгдээгүй байна. Зөвхөн шударга бус өрсөлдөөний зохицуулалтаар буюу бусад этгээд зориудаар, тухайн арилжаа эрхлэгчийн нэрд халдах, нэр хүндийг гутаах үед арилжааны нэрийг хамгаалахаар зохицуулагдсан байна. Манай улсын хувьд өнөөгийн эрх зүйн орчинд Арилжааны нэрийн эрх зүйн хамгаалалтыг бататгах цорын ганц арга зам нь барааны тэмдгээр бүртгүүлэх явдал байна.

**Түлхүүр үгс:** *Арилжааны нэр, Барааны тэмдэг, Арилжааны хууль, Аж үйлдвэрийн өмч, БНСУ, АНУ-ын харьцуулсан судалгаа*

**ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Сэдвийн судлагдсан байдал.....	3
Хүснэгт 2. Судалгааны арга зүй.....	4
Хүснэгт 2.1. Анхан шатны шүүхийн шийдвэр.....	36
Хүснэгт 2.2. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр.....	38
Хүснэгт 2.3. Хяналтын шатны шүүхийн шийдвэр.....	40
Хүснэгт 3.1. Арилжааны нэр ба барааны тэмдгийн тодорхойлолтын ялгаа.....	48
Хүснэгт 3.2. Арилжааны нэр ба барааны тэмдгийн эрхийн ялгаа .....	49
Хүснэгт 3.3. Арилжааны нэр ба барааны тэмдгийн хамгаалалтын ялгаатай байдал .....	50
Хүснэгт 3.4. Арилжааны нэр ба барааны тэмдгийг шилжүүлэх, ашиглах эрх дуусгавар болох, шударга өрсөлдөөний хууль дахь ялгаатай байдал .....	54
Хүснэгт 3.5. БНСУ-ын шүүхийн шийдвэрийн хураангуй.....	55
Хүснэгт 3.6. АНУ-ын Холбооны хуулийн ерөнхий бүтэц .....	62
Хүснэгт 3.7. Бүртгэлд суурилсан зарчим болон ашиглалтад суурилсан зарчмын давуу болон сул талууд .....	64
Хүснэгт 3.8. АНУ-ын шүүхийн маргааны хураангуй.....	70



**ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1.1. Монгол улсын эрх зүйн тогтолцоо .....	7
--	---

## ОРШИЛ

### Сэдэв сонгосон үндэслэл

Монгол улс ардчилсан засаглал, эрх чөлөөт нийгэм, зах зээлийн эдийн засагт шилжээд эдүгээ гучаад жилийн нүүрийг үзэж байна. Өнгөрсөн хугацаанд нийгэм, эдийн засгийн шилжилт хөгжлөө дагаад эрх зүйн орчин мөн өөрчлөгдөж, шинэчлэгдэж ирсэн бөгөөд эдийн засаг хөгжиж тэлэхийн хамтаар худалдаа, арилжааны эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үсч байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг ерөнхийлөн зохицуулдаг иргэний хууль нь арилжааны харилцааг зохицуулахад дутагдалтай тал их байгаагаас эдийн засаг тэлэх, худалдаа арилжаа хөгжихөд саад тотгор болж байгааг анхаарч арилжааны төрөлжсөн хуулийн төсөл боловсруулж байна.

Арилжааны эрх зүйн хөгжлийн эхэн үе нь дундад зууны Италийн хот улсуудаас эхтэй боловч өнөөгийнх шиг төрөлжсөн арилжааны хууль болон хэлбэржсэн нь 1807 оны Францын Арилжааны хууль (Code de Commerce) бөгөөд түүнээс хойш Герман (1861) болон Япон улсууд (1899) арилжааны хуулийг баталж хэрэгжүүлж эхэлжээ. Өнгөрсөн зуунд манай улстай хөгжлийн зам мөр ижилхэн байсан Социалист Вьетнам улс 2005 онд арилжааны төрөлжсөн хуулийг баталж хэрэгжүүлээд эдүгээ эдийн засгийн хувьд эрчимтэй хөгжиж байна. Харин сүүлийн гучин жилд манай улстай эдийн засаг, нийгэм, хүн харилцаа зэрэг олон талын хамтын ажиллагаа бүхий хамгийн ойрын гуравдагч хөрш болох БНСУ-ын хувьд Японы нөлөөгөөр арилжааны эрх зүйн орчин бүрэлдэн бий болсон бөгөөд сүүлд 1945 онд тусгаар улс болсноос хойш буюу 1962 онд арилжааны төрөлжсөн хуулийг баталж хэрэгжүүлж иржээ.

Иргэний хууль нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч бүхий л этгээд хоорондын харилцааг зохицуулахад чиглэдэг бол Арилжааны хууль нь тэдгээр этгээдүүдийн нэг хэсэг болох арилжаа эрхлэгчид хоорондын харилцааг зохицуулдаг. Энэ утгаараа арилжааны эрх зүйн зохицуулах харилцаа иргэний эрх зүйгээс илүү онцлог шинжтэй байдаг. Арилжаа эрхлэгчдийн хувьд ашгийн төлөө байх, түргэн шуурхай байх, нийтэд ил тод нээлттэй байх, уян хатан байх, өндөр хариуцлагатай байхыг шаарддаг бөгөөд үүний үр дүнд арилжааны үйл ажиллагаа амжилттай байж, улс орны эдийн засаг хөгжинө. Тиймээс энэхүү арилжаа эрхлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төрөлжсөн арилжааны хуулийг эдийн засаг өндөр хөгжсөн улс орнуудад хоёр зуун жилийн тэртээ баталж хэрэгжүүлж иржээ.

Төрөлжсөн арилжааны хуулиар ихэвчлэн арилжааны үйл ажиллагаа болон арилжаа эрхлэгчийг тодорхойлох, арилжаа эрхлэгчийн бүртгэл, арилжааны нэрийн зохицуулалт, арилжааны төлөөлөл, арилжааны тайлан тооцооны хяналт, арилжааны санхүүжилт, арилжааны үйл ажиллагааг өөрчлөн байгуулах, дампуурлын үйл ажиллагаа зэргийг зохицуулдаг. Оюутан миний бие эдүгээ Монгол улс арилжааны төрөлжсөн хуулийг батлахаар бэлтгэж буй чухал цаг мөчид “Арилжааны нэр ба түүний эрх зүйн хамгаалалт” сэдвийг сонгон харьцуулсан судалгаа хийхээр зорьж байна. Харьцуулсан судалгааг хийхдээ дэлхийн эрх зүйн тогтолцоонд гол байр суурийг эзэлдэг нийтлэг эрх зүйн бүлийн улс болон иргэнлэг эрх зүйн бүлийн улсаас сонгон авч судалгааг хийхийг зорьж байна. Нийтлэг эрх зүйн бүлийн улсуудаас дэлхийд эдийн засгаар сүүлийн зуун жилд тэргүүлж ирсэн АНУ-ын эрх зүйн тогтолцоонд арилжааны нэрийг хэрхэн тодорхойлж, хэрхэн хамгаалж буй талаар судлахыг зорьж буй бол иргэнлэг эрх зүйн бүлээс бидний хамгийн ойр бөгөөд эдийн засгийн идэвхтэй хамтын ажиллагаатай БНСУ-ын эрх зүйн тогтолцоонд арилжааны нэрийг хэрхэн тодорхойлсон, түүнийг хэрхэн хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн талаар судлахыг зорьж байна.

### **Судалгааны ажлын зорилго**

- Арилжааны эрх зүйн онол, нэр томъёо, онцлог шинжийг тодорхойлох
- Монгол улсын өнөөгийн эрх зүйн орчинд арилжааны нэрийг хэрхэн тодорхойлж, хуулиар хамгаалж байгаа болон шүүхийн практикийг судлах
- Дэлхийн бусад улсуудад (АНУ болон БНСУ) арилжааны нэрийг хэрхэн тодорхойлж, хэрхэн хамгаалж буй зохицуулалтыг судлах
- Өмнөх судалгаануудад үндэслэн Монгол улсын өнөөгийн хуулийн зохицуулалтад дүгнэлт хийхийг зорьж байна

### **Судалгааны ажлын зорилт**

Үүний тулд судалгааны Оршил хэсэгт сэдэв сонгосон үндэслэл, судлагдсан байдал, судалгааны арга зүйг бичээд, 1-р бүлэгт арилжааны эрх зүйн ерөнхий онолын мэдлэг мэдээллийг сийрүүлэх зорилгоор арилжааны эрх зүйн салбар эрх зүй болох талаар болон хамрах хүрээ, арилжааны нэр болон барааны тэмдгийн тодорхойлолт, арилжааны нэрийг хамгаалах онолын үндэслэл зэргийг тодорхойлохыг зорьж байна. Энэхүү ерөнхий үндэслэл болон мэдлэгт суурилж 2-р бүлэгт Монгол улсын өнөөгийн эрх зүйн орчны хүрээнд арилжааны нэр болон түүний эрх зүйн хамгаалалт, арилжааны нэртэй холбоотой маргааныг шүүхээр шийдвэрлэсэн байдал зэргийг судлахыг зорьж байна. Харин 3-р бүлэгт иргэнлэг эрх зүйн бүлд хамаарах бидний хамгийн ойрын эдийн засгийн хамтын ажиллагаа бүхийн түнш улс БНСУ-ын эрх зүйн орчинд арилжааны нэр түүний эрх зүйн хамгаалалтыг хэрхэн зохицуулсан талаар болон Нийтлэг эрх зүйн бүлийн гол төлөөлөл

болсон дэлхийд эдийн засгаар тэргүүлэгч улс АНУ-ын эрх зүйн орчинд арилжааны нэр, түүний эрх зүйн хамгаалалтыг хэрхэн зохицуулж буй талаар судлахыг зорьж байна. Үүний тулд дараах дөрвөн зорилтыг дэвшүүлж, тус зорилтуудын хүрээнд судалгааны ажлаа гүйцэтгэхээр төлөвлөж байна.

### Сэдвийн шинэлэг тал

Өнгөрсөн хугацаанд Монгол улсад хийгдсэн нэг сэдэвт харьцуулсан судалгаа, шинжилгээний бүтээлүүдийг тоймлон үзвээс ихэвчлэн эрх зүйн бүлийн хувьд нэг бүлд хамаарах Франц, Герман, Япон улсууд болон ОХУ, БНХАУ-ын эрх зүйн зохицуулалтуудыг судалсан бүтээлүүд ихээхэн байна.

Харин Нийтлэг эрх зүйн бүлийн төлөөлөл болсон АНУ-ын тогтолцоо болон Иргэнлэг эрх зүйн бүлд хамаарах БНСУ-ын эрх зүйн зохицуулалтыг Монгол улсын эрх зүйн орчинтой харьцуулалт хийх байдлаар судалсан судалгааны бүтээл ховор байх бөгөөд тэр дундаа Монгол улсад шинээр судлагдаж эхэлж буй арилжааны эрх зүй, арилжааны нэр түүний эрх зүйн хамгаалалтын талаарх судалгаа хийгдээгүй байх тул энэ талаар шинэлэг байж, эрх зүй судлалд бага болов хувь нэмэр болох болов уу гэж үзэж байна.

### Сэдвийн судлагдсан байдал

Хүснэгт 1. Сэдвийн судлагдсан байдал

Судалгааны сэдэв	Судалсан агуулга	Судлаачийн нэр	Судалгааны ажил, хэвлэгдсэн он
Арилжааны хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах	Арилжааны эрх зүйн иргэний эрх зүйгээс ялгагдах онцлог шинж, зарчмыг тодорхойлж, Монгол улсад арилжааны эрх зүй хэрхэн хангагдаж байгааг тандан судалсан судалгаа юм.	Б.Амарсанаа Д.Наранчимэг Л.Бямбаа С.Батбаяр Н.Норовсамбуу Р.Пүрэвбаатар	Ханнс Зайдэлийн Сан, Судалгааны тайлан, 2019 он
Аж ахуйн үйл ажиллагааны улсын бүртгэлийн дагнасан тогтолцоо бий болгох асуудал	Монгол улсад арилжааны дагнасан бүртгэлийн тогтолцоог бий болгох тэр дундаа хувиараа аж ахуй эрхлэгчдийг бүртгэх асуудлыг хөндсөн.	С.Энхбаяр (Ph.D)	Шүүх эрх мэдэл, 2020 он, №3

Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой маргаан шийдвэрлэж буй шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдал	Хуулийн этгээдийн бүртгэлээс үүдэх маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийсэн судалгаа.	Б.Амарсанаа (LL.D) С.Батбаяр (LL.M)	Шүүхийн шийдвэрийн судалгаа цуврал 6, 2022 он
Арилжааны эрх зүй	Арилжааны эрх зүйн ойлголт, онцлог, арилжааны эрх зүйн эх сурвалж, арилжаа эрхлэгч, хувиараа аж ахуй эрхлэгч, нөхөрлөл, компани, арилжааны нэр, арилжааны бүртгэл, арилжааны төлөөлөл, арилжааны тайлан тооцооны хяналт, арилжааны санхүүжилт зэрэг арилжааны эрх зүйтэй холбоотой сэдвийн хүрээнд эрхэлсэн гаргасан сурах бичиг.	МУИС, ХЗС,	Сурах бичиг, МУИС ХЗС, Соёмбо принтинг, 2022 он

*Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэснээр*

## Сэдвийг судалгааны арга зүй

### Хүснэгт 2. Судалгааны арга зүй

Судалгааны арга	Агуулга
Анализын арга /задлан шинжлэх/	Анализын арга нь нэгдмэл бүхэл зүйлийг тодорхой хэсэг болгон задлан шинжлэх зорилготой. Ингэснээр бүхэл зүйлийг хэсэг болгон дэлгэрүүлэн үзэх, өөр хоорондын харилцан хамаарлыг гаргах ач холбогдолтой. Судалгааны объектын бүтцийг илрүүлэх, түүний бүрэлдэхүүн, хоорондын уялдаа холбоо, шинж байдлыг тогтооход хэрэглэнэ. Цуглуулсан мэдээ баримтад тулгуурлан судалгааны объектыг задалж дотоод бүтэц, зохион байгуулалт, зүй тогтол, онцлог байдал зэргийг нарийвчлан тогтоодог.
Синтезийн арга /нэгтгэн дүгнэх/	Анализын аргын үр дүнгээр тогтоосон үзэгдэл, үйл явцын тухай болон судалж байгаа зүйлийн шинж чанарыг нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгч байгаа арга юм. Үүгээрээ судалж байгаа зүйлийнхээ талаар бүрэн дүүрэн ойлголт авах ач холбогдолтой. Синтезийн аргыг тодорхой хэсгийг нэгдмэл бүхэл болгон холбох явцад хэрэглэдэг. Ямар нэг тодорхой хэсгүүд бүхэл зүйлийг нийлж бий болгодог

	шинжүүд, түүний бүрэлдэхүүнд байх онцлог, юугаараа нэгдмэл, юугаараа тусгаар байх шинжийг олж гаргаснаар уг зүйлийн мөн чанар, зүй тогтлыг илрүүлдэг.
Харьцуулалтын арга	Харьцуулах объект зүйлийг тодорхойлж, тэдгээрийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хөгжил, хувьсал, өөрчлөлт, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлс, үр дүн, цаашдын хандлага, төлөв зэргийг харьцуулна. Тэгэхдээ судалгааны ажлын зорилго, зорилттой холбож дээр дурдсан үзүүлэлтийн нэг хэсгийг сонгох буюу ганц үзүүлэлтээр хязгаарлах тохиолдол нийтлэг байдаг. Эрх зүйн юмс үзэгдлийг нэгийг нь нөгөөтэй нь зэрэгцүүлсэн жишиж, адил төстэй ба ялгагдах шинжийг нь илрүүлж үр ашигтайгаар судлах арга юм. Ингэхдээ дахин давтагдахгүй онцлог шинж хийгээд, нийтлэг шинж яаж илэрч байгааг жишиж нягтлах замаар танин мэдэхэд оршдог.

*Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэсэнээр*

## **I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ**

### **1.1. Арилжааны эрх зүй салбар эрх зүй болох нь**

Эрх зүйн шинжлэх ухааны судлах зүйл, судалгааны арга, зарчмаар нь хэд хэдэн салбар эрх зүйд хувааж, тэдгээрийг дотор нь дэд салбар болон тодорхой институтэд хуваагддаг.

Эрдэмтэн багш Ч.Нямсүрэн Салбар эрх зүй гэж зохицуулах зүйл, зохицуулалтын аргын онцлогоор эрх зүйн нэгдмэл системд харьцангуй бие даасан байр суурь эзэлдэг, нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний нийлбэрийн цогц юм гэж тодорхойлжээ. Эрх зүйг бие даасан салбар эрх зүй болгодог нэг чухал шинж болбоос тодорхой онцлог шинж бүхий эрх зүйн зохицуулалтын зүйл болон зохицуулалтын аргатай байх явдал юм. Салбар эрх зүй нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулдаг бол институт нь уг харилцааны нэг хэсгийг зохицуулдаг. Харин дэд салбар эрх зүй гэдэг нь эрх зүйн салбарын бүрэлдэхүүнд эрх зүйн хэд хэдэн институтээс бүтэх боловч эрх зүйн системд бие дааж байр суурь эзэлдэггүй хэсэг бүлэг хэм хэмжээг ойлгоно. (Ч.Нямсүрэн, 2021, 262-264р тал)

Нэрт эрдэмтэн С.Нарангэрэл салбар эрх зүй (Branch of law) гэдэг нь тухайн эрх зүйн тогтолцоонд онцгойрон ялгарсан тодорхой төрлийн нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээний нийлбэр мөн гэж тодорхойлжээ. Нийгмийн харилцааны алив нэг хүрээний нэг төрөл нь байвал зохих салбар эрх зүйг (иргэний эрх зүй, эрүүгийн эрх зүй, захиргааны эрх зүй зэрэг) амьдралд буй болгоно. Бүх салбар эрх зүй нь учир холбогдлоороо харилцан адилгүй боловч харилцан нэгдмэл уялдаатай юм гэжээ. (С.Нарангэрэл, 2001, 75-р тал)

Манай улс эрх зүйн тогтолцооны хувьд бусад иргэнлэг эрх зүйн (civil law system) бүлд хамаарах улсуудын адилаар нийтийн болон хувийн эрх зүйд ангилж, нийтийн эрх зүйд үндсэн хуулийн эрх зүй, захиргааны эрх зүй, санхүүгийн эрх зүй, эрүүгийн эрх зүй зэргийн салбаруудыг хамруулдаг бол хувийн эрх зүйд иргэний эрх зүй, гэр бүлийн эрх зүй, компанийн эрх зүй, худалдааны буюу арилжааны эрх зүй гэх мэт салбар эрх зүйг хамруулах хандлагатай байдаг. (Б.Буянхишиг, 2021, 22-р тал)

Зураг 1.1. Монгол улсын эрх зүйн тогтолцоо



Эх сурвалж: Б.Буянхишиг, 2021, 18-р тал

Өнөөгийн манай улсын эрх зүйн шинжлэх ухааны эрдэмтэд дунд арилжааны эрх зүй гэдэгт чухам юуг хамааруулах, юуг ойлгох талаар төсөөтэй ойлголтууд бий болж байгаа хэдий ч арилжааны эрх зүйг тодорхойлох нэгдсэн тодорхойлолт хараахан бий болоогүй байна. Монгол улсад 1990 оноос хойш зах зээлийн эдийн засагт шилжсэнээр арилжааны эрх зүй үсч хөгжсөн гэж ойлгож болох бөгөөд өнгөрсөн хугацаанд аж ахуйн эрх зүй, бизнесийн эрх зүй, худалдааны эрх зүй, арилжааны эрх зүй гэсэн нэршлээр эрдэмтэд судалгааны бүтээлүүддээ дурдаж, нэршил бүрээр харилцан адилгүй өөрөөр тодорхойлж иржээ.

Судлаачийн зүгээс харваас бизнесийн эрх зүй гэсэн нэршлээр тодорхойлсон эрдэмтдээс нэг хэсэг нь тус эрх зүйг бие даасан салбар эрх зүй бус хэд хэдэн салбар эрх зүйн институтийг багтаасан цогцолмол эрх зүй гэж тодорхойлох, нөгөө хэсэг нь бие даасан салбар эрх зүй бус иргэний эрх зүйн дэд салбар эрх зүй гэж үзэх хандлагатай байна.

Нэрт эрдэмтэн Б.Чимид агсан “Бизнесийн эрх зүй бол хуульд заасан үндэслэлийн дагуу ашгийн төлөө барааны үйлдвэрлэл-борлуулалт, ажил үйлчилгээг тогтвортой эрхлэх, зохион байгуулах, засаг төрөөс оролцон зохицуулах явцад бизнес эрхлэгчдийн хооронд түүнчлэн бизнес эрхлэгч ба бусад этгээдийн хооронд үүссэн харилцааг зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц” хэмээн тодорхойлсон байна.



Бизнесийн эрх зүйн нэрт судлаач Д.Дүгэржав 1998 онд хэвлүүлсэн “бизнесийн эрх зүй” номдоо “бизнесийн үйл ажиллагаанд оролцогчдын олон талт харилцааг зохицуулж байгаа нэлээд хэдэн салбар институтийн ойлголт, зохицуулалтыг бизнесийн практиктай уялдуулан судлах ухааныг бизнесийн эрх зүй гэж ойлгож болно” гээд бизнесийн эрх зүй бол янз бүрийн салбар эрх зүй, түүний институтийг багтаасан цогцолмол эрх зүй мөн гэж үзжээ. (Д.Дүгэржав, 1998)

Хууль зүйн ухааны доктор, профессор Т.Мөнхжаргал “Бизнесийн эрх зүй” номдоо “бизнесийн эрх зүй нь бие даасан болон цогцолбор эрх зүй биш иргэний эрх зүйн нэгэн дэд салбар юм. Иргэний эрх зүй нь зохицуулах нийгмийн харилцааны цар хүрээ, сэдвийн төрөл, чиглэлээс хамаарч, өмчийн, үүргийн, өв залгамжлалын, бизнесийн гэх мэт дэд салбаруудад хуваагддаг. Бизнесийн эрх зүйн харилцаа нь иргэний эрх зүйн зохицуулах зүйл болох эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус болон зохион байгуулалтын харилцааны нэг хэсэг болно. Өөрөөр хэлбэл бизнесийн эрх зүй нь бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын арга хэлбэрийг гүнзгийрүүлэн авч судална” гэжээ. (Т.Мөнхжаргал, 2000, 4-р тал)

Харин судлаач Н.Баярмаа нь аж ахуйн эрх зүй болон худалдааны эрх зүй нь зохицуулах зүйлийн хувьд ялгаагүй тул ижил нэршил гэж тодорхойлоод, манай улсын хувьд түүхэн хөгжлийн явцад эдийн засгийн харилцааг зохицуулах цогц эрх зүйгээ бид аж ахуйн эрх зүй хэмээн нэрлэж заншсан тул аж ахуйн эрх зүй гэж нэрлэх нь зүйтэй гэж үзжээ. Тодруулбал аж ахуйн эрх зүй хэмээх өөрийн гэсэн бүтэц, онцлог бүхий эрх зүйн хэм хэмжээний бие даасан тогтолцоо нь салбар эрх зүй, тэр дундаа хувийн ба нийтийн эрх зүйн холимог салбар эрх зүй мөн хэмээн тодорхойлжээ. (Н.Баярмаа, 2000, 2-р тал)

Тэгвэл нэрт доктор, профессор Б.Амарсанаа нь арилжааны эрх зүй гэсэн нэршлээр нэрлэх нь зөв хэмээн үзээд, арилжааны эрх зүй нь хувийн эрх зүй төдийгүй нийтийн эрх зүйтэй нягт уялдаа холбоо бүхий салбар эрх зүй юм. Тэр дундаа нийтийн эрх зүйн салбар эрх зүй болох захиргааны эрх зүй, өрсөлдөөний эрх зүй, хувийн эрх зүйн салбар болох иргэний эрх зүй, хөдөлмөрийн эрх зүйтэй нягт уялдаа холбоотой гэж тодотгожээ. (Б.Амарсанаа, 2022, 20-р тал)

Үүнээс гадна нийтлэг тодорхойлолтоор арилжааны буюу худалдааны эрх зүй гэдэг нь хувийн эрх зүйн тусгай салбар буюу өөрөөр хэлбэл иргэн бүрийн оролцдог суурь харилцаа биш, харин тодорхой мэргэжил, салбарын бизнес эрхлэгчид өөр хоорондоо харилцах тэрхүү харилцааг зохицуулдаг салбар эрх зүй юм гэж тодорхойлжээ. (Ц.Давхарбаяр, Д.Янжинхорлоо)

Судлаачийн зүгээс арилжааны эрх зүйг бие даасан салбар эрх зүй гэдэг өнцгөөс харж, арилжааны нэр түүний эрх зүйн хамгаалалтыг судлахыг зорьж байна. Чухам арилжааны эрх зүйг бие даасан салбар эрх зүй гэдгийг хүлээн зөвшөөрснөөр цаашилж, арилжааны үйл ажиллагаа гэдэг ухагдахууныг тодорхойлох хэрэгцээ шаардлага үүсэж байна.

## **1.2. Арилжааны эрх зүйн хамрах хүрээ, зохицуулах харилцаа**

Хүн төрөлхтөн эхэн үедээ өөрсдийн суурь хэрэгцээ болох орон гэр, хоол хүнс, өмсөх хувцасны хэрэгцээгээ хангахыг гол зорилгоо болгодог байсан бол нийгэм хөгжихийн хэрээр өөрийн хэрэгцээг хангахын тулд бусадтай солилцоо хийж эхэлсэн байдаг. Ийнхүү солилцооны хэрэгсэл болох мөнгөн тэмдэгтийг хэрэглээнд нэвтрүүлснээр солилцоо, худалдаа нь улам өргөжиж зарим хүмүүс түүнийг хуримтлуулж эхэлсэн байдаг. Улмаар нийгэмд шинээр давхарга гарч ирсэн нь худалдаачид бөгөөд тэдгээр нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг арилжаа эрхлэгчид гэж тооцогдож байсан. 19-р зууныг хүртэл хүртэл ашиг орлого ологч гол этгээд нь худалдаачид байсан бол аж үйлдвэр хөгжиж эхэлснээр бараа бүтэгдэхүүнийг их хэмжээгээр бүтээгчид болох үйлдвэрлэл эрхлэгчид нь өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах замаар их хэмжээний ашиг олох бололцоотой болсон юм. (Б.Амарсанаа, 2022, 10-р тал)

Дээр дурдсан бүхий л үйл ажиллагаа нь арилжааны үйл ажиллагаанд хамрагдах бөгөөд түүнээс гадна орчин үед хувийн хэрэгцээнээс гадуурх ашгийн төлөөх ойн аж ахуй, мал аж ахуй, газар тариалан эрхлэгчийг нийтэд нь арилжааны үйл ажиллагаанд хамруулж ойлгож байна. Тиймээс арилжааны үйл ажиллагаа гэдгийг товчхондоо “ашгийн төлөөх үйл ажиллагаа” гэж эрх зүйн хувьд томъёолдог. Ийм этгээдийн мөн чанар нь өөрийн хэрэгцээнээсээ давсан хэмжээтэй орлого олох сонирхолтой байх, тэрхүү үйл ажиллагаагаа байнгын тогтвортойгоор эрхлэх, тухайн арилжааны үйл ажиллагааны чиглэлдээ мэргэшсэн байх гэдэг мөн чанарыг агуулдаг. (Б.Амарсанаа, 2022, 11-р тал)

Тэгвэл бие даасан салбар эрх зүйн хувьд арилжааны эрх зүйн хамрах хүрээг яаж тодорхойлох вэ гэдэг асуудал гарч ирнэ. Онолын хувьд арилжааны эрх зүй нь өргөн болон явцуу утгаар илэрч болно. Өргөн утгаараа иргэний хуулийн ерөнхий зохицуулалтаас тусдаа боловч түүний тусгай зохицуулалтыг агуулахаас гадна бие даан системчлэгдэх боломжтой арилжаа эрхлэгч, эсвэл арилжааны үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогцыг илэрхийлнэ. Харин явцуу утгаараа арилжааны эрх зүйн нь төрөлжсөн арилжааны хуулийг илэрхийлэх нь түгээмэл байдаг. Гэвч төрөлжсөн арилжааны хууль нь арилжааны эрх зүйг дангаар төлөөлөхгүй бөгөөд иргэний

хууль болон бусад хуулиудтай цогц байдлаар тодорхойлогдох учиртай юм. (Б.Амарсанаа, 2022, 14-р тал)

Тэгвэл иргэний эрх зүй ба арилжааны эрх зүйн хамрах хүрээ, холбоо хамаарлыг яаж тодорхойлох вэ гэсэн асуудлыг хөндөх шаардлага үсч байна.

Зохицуулах зүйлийн хувьд иргэний эрх зүйн нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч аливаа этгээд хоорондын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн байдаг бол арилжааны эрх зүй нь тэдгээрийн нэг хэсэг буюу арилжаа эрхлэгчдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байдаг. Иргэний эрх зүй нь нийтлэг зохицуулалттай бол арилжааны эрх зүй нь тусгайлсан зохицуулалттайгаас гадна арилжааны эрх зүй нь иргэний эрх зүйн зарчмаас гадна тусгайлсан өөрийн гэсэн зарчимтай байдаг. Тодруулбаас, иргэний хуульд эрх тэгш байх, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх гэх мэт гол зарчмууд үйлчлэх бол арилжааны эрх зүй нь дээрх зарчмуудаас гадна талуудын ашгийн төлөө зорилгыг хамгаалах, хэлцэл хийхэд хялбар, зардал багатай байх, түргэн шуурхай байх, уян хатан байх, хэлцлийн найдвартай байдал болон итгэлийг хамгаалах, хариуцлагатай байх гэсэн гол зарчмуудтай байдаг. (Г.Давааням, 2022, 20-21р тал)

Эцэст нь арилжааны хуулийн зохицуулах харилцааг хэрхэн тодорхойлох вэ гэсэн асуулт гарч ирнэ. Ерөнхийдөө хууль тогтоомжийг батлахдаа хэнд хандаж, ямар харилцааг зохицуулах хэм хэмжээг бүтээх үү гэдэг нь чухал бөгөөд тухайн тохиолдолд хууль тогтоох бүтцийн үндсийг нэгдүгээрт, субъектийн шалгуураар (тухайн хуулиар зохицуулагдах субъектэд зориулж бүтээх), хоёрдугаарт, объектын шалгуураар (тухайн хуулийн зохицуулах харилцааг голчилж бүтээх), гуравдугаарт, холимог шалгуураар (тухайн хуулиар зохицуулагдах субъект болон харилцааг аль алиныг нь харгалзаж батлах) батлах гэсэн үндсэн гурван аргачлал бий. (Б.Амарсанаа, 2022)

Иргэнлэг эрх зүйн тогтолцоо бүхий улсуудад 19-р зууны үеэс арилжааны хуулийг батлахдаа өөр өөрийн нийгмийн байдалд нийцүүлж тодорхой аргачлал, шалгуурыг хэрэглэсэн байдаг. Тухайлбал франц улс нь францын хувьсгалын үзэл санаанд нийцүүлэн худалдаачин гэх нийгмийн давхаргын оронд арилжааны хэлцэл гэх ойлголтоор буюу объектын аргачлалд суурилж арилжааны хуулиа баталсан байдаг. Харин 1897 онд Герман улсаас баталсан арилжааны хууль нь субъектийн аргачлалаар буюу худалдаачныг зохицуулах хууль болж бүтсэн бөгөөд, тодруулбал субъект нь

хуулийн гол зохицуулах харилцаа болж хэлцэл нь түүнийг дагалдах шинжтэйгээр хуульчлагдсан байдаг. Гуравдах хэлбэр болох холимог аргачлалын хувьд, 1899 онд Япон улсаас баталсан арилжааны хууль нь томоохон төлөөлөл юм. (Б.Амарсанаа, 2022, 15-18р тал)

Судлаачийн зүгээс манай улс арилжааны хуулийн зохицуулах харилцааг тодорхойлохдоо холимог байдлаар буюу хуулиар зохицуулагдах субъект болон объектыг аль алиныг нь харгалзаж бүтээх нь зүйтэй болов уу гэсэн бодол тээж байна.

### **1.3. Арилжааны нэр болон барааны тэмдгийн ойлголт**

Дэлхий дахинд арилжааны нэр болон барааны тэмдэгт гэдэг ойлголт тухайлсан хуулиуд батлагдсанаар нэлээдгүй тодорхой болж эхэлсэн байдаг. Анхны барааны тэмдэгтэй холбоотой хууль 1266 онд Англи улсын Гуравдугаар Хэнри хааны зарлигаар талхны чанар буюу жинг хадгалах зорилгоор талх үйлдвэрлэгчдийг өөр өөр тэмдэгт ашиглахыг шаардсанаар үүссэн байдаг. (*A History of Trademarks: From the Ancient World to the 19th Century*, n.d.)

Түүнээс хойш дэлхийн улсууд дор бүрнээ барааны тэмдгийн эрх зүйн зохицуулалтыг хуульчилж ирсэн хэдий ч анхны орчин үеийн барааны тэмдгийн хууль болох “Үйлдвэрлэл болон барааны тэмдгийн хууль” (Manufacture and Good Mark Act)-ийг 1857 онд Францад баталсан бол түүнээс хойш Их британид “Мерчандайзын тэмдгийн хууль” (Merchandise Marks Act)-ийг 1862 онд, “Барааны тэмдгийн бүртгэлийн хууль” (Trade Marks Registration Act)-ийг 1875 онд тус тус баталж байжээ. Харин Америкийн нэгдсэн улсад 1870 оноос эхлэн холбооны хэмжээнд үйлчлэх барааны тэмдгийн хуулийг батлахыг эрмэлзсэн бөгөөд өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй “Холбооны барааны тэмдгийн хууль”-ийг (U.S. Trademark Law or Lanham Act) батлан хэрэгжүүлж эхэлсэн нь 1946 он болно. (*A History of Trademarks: From the Ancient World to the 19th Century*, n.d.)

Тэгвэл өнөөгийнх шиг төрөлжсөн Арилжааны эрх зүйн үүсэл нь дундад зуунд европ тивд тэр дундаа Италийн хот улсуудын худалдаачдын холбоодын хооронд үйлчилдэг өөртөө засах хэм хэмжээ болон Арилжааны заншлаас үүдэн тогтож эхэлсэн байдаг. Улмаар төрөлжсөн Арилжааны хууль үсч хөгжсөн нь 1807 онд баталсан Францын Арилжааны хууль (Code de Commerce), 1861 онд баталсан Германы Арилжааны хууль, 1899 онд баталсан Японы Арилжааны хуулиудаас эхтэй болно.

Арилжааны нэр гэх ойлголт дэлхийн улсуудад арилжааны төрөлжсөн хууль баталж хэрэглэх тэр мөчөөс тодорхой болж эхэлсэн байдаг. Гэсэн хэдий ч арилжааны нэр (trade name) гэсэн ойлголтыг барааны тэмдэг (trademark) гэсэн ойлголттой хольж хутгах

асуудал нийтлэг үзэгддэг. Гиймээс судлаачийн зүгээс энэ хэсэгт Дэлхий оюуны өмчийн байгууллагаас арилжааны нэр болон барааны тэмдгийг хэрхэн тодорхойлж байгаа болон эдгээр нь оюуны өмч мөн эсэх, хэрэв мөн бол оюуны өмчийн ямар төрөлд хамаарах эсэх талаар сийрүүлэхийг зорьж байна.

Юуны өмнө оюуны өмч гэж чухам юу болох оюуны өмч гэдэгт юуг хамааруулах талаар авч үзье. Оюуны өмч (intellectual property) гэдэг нь эд хөрөнгө, өмчлөлийн нэг төрөл бөгөөд хүний оюун ухаанаар бий болсон биет бус өмч юм. Тухайн ойлголт нь голдуу зохиогчийн эрх, патент, барааны тэмдэг, газар зүйн заалт гэх зэрэг ухагдахууныг багтааж ойлгодог бол сүүлийн үед бусад төрлийн эрх болох ашигтай загвар, бүтэгдэхүүний загвар, арилжааны нууц, шударга өрсөлдөөний эрх зэргийг хамруулах үзэгдэл дэлхийд түгээмэл болж байна.

Харин Монгол улсын Оюуны өмчийн тухай хуульд: "оюуны өмч" гэж оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объект болон аж үйлдвэрийн өмчийг хамааруулна гэж заажээ. (legalinfo.mn, 2020) Зохиогчийн эрхийн хамгаалалтад байх бүтээл гэдэгт утга зохиол, урлагийн, шинжлэх ухааны бүтээлүүдийг хамааруулах бол аж үйлдвэрийн өмч буюу патентын эрхийн хамгаалалтад байх зүйл гэдэгт патент, барааны тэмдэг, ашигтай загвар, бүтэгдэхүүний загвар зэргийг хамруулж үзнэ. (legalinfo.mn, 2021)

Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас (World Intellectual Property Organization) оюуны өмчийг зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр (copyright (authors right) and related rights) хамгаалагдах оюуны өмчийн бүтээл, патентын эрхээр хамгаалагдах аж үйлдвэрийн өмчийн (industrial property) бүтээл гэж ангилдаг. (denphumi, n.d.) Урлаг соёл, шинжлэх ухааны бүтээл бүтээх, ашиглах харилцааг зохиогчийн эрх зүйгээр хамгаалдаг бол аж үйлдвэрийн өмч бүтээх, түүнтэй холбоотой бүхий л харилцааг патентын эрх зүйгээр зохицуулдаг. Олон улсад тэртээ 200 жилийн өмнө буюу 1883 онд аж үйлдвэрийн өмчийг хамгаалах "Парисын конвенц" (Paris Convention for the Protection of Industrial Property)-г баталж байсан бол 1886 онд зохиогчийн эрхээр хамгаалагдах утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах "Бернийн конвенц" (Berne Convention for the Protection of Literary and Artistic Works)-г тус тус баталж байжээ.

Олон улсад аж үйлдвэрийн өмчийн хамгаалалтыг "Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай парисын конвенц (Paris Convention for the Protection of Industrial Property)" болон "Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (TRIPS-

Trade related Aspects of Intellectual Property Rights)” буюу Трипсийн хүрээнд хамгаалагдаж байна.

Үүнээс 1883 онд баталсан Парисын конвенцын 1-р зүйл буюу Холбоо байгуулах, аж үйлдвэрийн өмчийн хүрээ гэдэг зүйлийн (2)-т Аж үйлдвэрийн эрхийн хамгаалалтын объектод патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг, арилжааны нэр, эх үүсвэр буюу нэрийн гарлын заалт, шударга бус өрсөлдөөнийг таслан зогсоох үйлдэл багтана гэж заажээ. (Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах парисын конвенц, n.d.)

Тэгвэл 1994 онд баталсан Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улсууд дагаж мөрдөхөөр хэлэлцсэн Трипс хэлэлцээрийн оюуны өмчийн эрхийн байдал, хамрах хүрээ, ашиглалтад холбогдох хэм хэмжээ хэсэгт зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх, барааны тэмдэг, газар зүйн заалт, бүтээгдэхүүний загвар, патент, топограф, хаалттай мэдээллийг хамгаалах, гэрээт лицензийн өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааг хянах ажиллагааг хамруулж үзжээ. (Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр, n.d.)

Дээрхээс үзэхэд Трипс хэлэлцээрийн хамгаалалтын объектод барааны тэмдэг орох хэдий ч арилжааны нэр хамаарахгүй байх бөгөөд Парисын конвенцын хамгаалалтын объектод харин барааны тэмдэг болон арилжааны нэр аль аль нь хамаарч байна. Тэгвэл олон улсын гэрээ, конвенцын хүрээнд аж үйлдвэрийн өмчийн хамгаалалтад байдаг Арилжааны нэр болон Барааны тэмдэг гэдэг нь чухам ямар ойлголт болохыг Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас тодорхойлсныг авч үзье.

Барааны тэмдэг гэдэг нь нэг компани өөрийн бараа, үйлчилгээг бусдынхаас ялгах зорилгоор ашиглаж буй тэмдэг эсвэл тэмдгүүдийн бүрдлийг хэлнэ. Барааны тэмдэг нь үг, үсэг, тоо, зураг, хэлбэр дүрс, өнгө болон өнгөний иж бүрдлээс бүтэж болно. Сүүлийн үед дэлхийн олон улсууд нэмэлтээр гурван хэмжээст тэмдэг (жишээлбэл кока колагийн шил эсвэл тоблерон шоколадны хэлбэр), сонсогдох тэмдэг (audible signs:жишээлбэл MGM студийн кино эхлэхэд гардаг арслангийн архирах чимээ гэх мэт), үнэртэх тэмдэг (olfactory signs:жишээлбэл тодорхой төрлийн моторын тосны үнэр эсвэл гэх мэт) зэргийг бүртгүүлэхийг зөвшөөрөх хандлага үсч байгаа. Гэсэн хэдий ч нийтлэгдээ ихэнх улсууд уламжлалт байдлаар буюу барааны тэмдгийг зөвхөн харагдах байдлаар нь таних боломжтой тэмдгийг л бүртгүүлэхийг зөвшөөрч, бусад шинэ хэлбэрийн тэмдгийн бүртгэлийг хязгаарласан хэвээр байна. (Wipo 2016, Understanding industrial property, 17-р тал)

Барааны тэмдэгтэй төсөөтэй өөр гурван ойлголт байдаг нь үйлчилгээний тэмдэг (service mark), хамтын тэмдэг (collective mark), гэрчлэх тэмдэг (certification mark) болно. Үйлчилгээний тэмдэг гэдэг нь бараа бүтээгдэхүүн бус үйлчилгээнд ашиглаж буй тэмдгийг хэлэх бөгөөд зочид буудал, зоогийн газар, ресторан, нислэгийн компани, жуулчны агент, машин түрээс, цэвэрлэгээ, угаалгын газрууд гэх мэт үйлчилгээнд ашиглах боломжтой юм. Энэ нь ойлголтын хувьд бараанд бус үйлчилгээнд л ашиглаж буй гэдгээрээ ялгагдах бөгөөд ухагдахууны хувьд барааны тэмдэгтэй ижил юм. Хамтын тэмдэг гэдэг нь сайн дурын үндсэн дээр нэгдсэн инженер, санхүүчид гэх зэрэг мэргэжлийн үйл ажиллагааны холбооны эзэмших тэмдэг бөгөөд тухайн холбооны гишүүд тэмдгийг ашигласнаар холбооноос тогтоосон чанарын шаардлага болон бусад шаардлагуудыг хангасанд тооцох тэмдэг юм. Харин Гэрчлэх тэмдэг (жишээлбэл ноосны чанарын тэмдэг) гэдэг нь тодорхой байгууллагаас тогтоосон чанар, стандартад нийцээнийг гэрчилж бусдад ашиглуулах тэмдэг бөгөөд өмнөх хамтын тэмдгээс ялгаатай нь гишүүнчлэл шаарддаггүй юм. (Wipo 2016, Understanding industrial property, 18-р тал)

Тэгвэл Арилжааны нэр (trade name) гэдэг нь бас нэг төрлийн аж үйлдвэрийн өмч бөгөөд арилжаанд ашиглах нэр (name) болон нэршлээс (designation) бүрдэх арилжаа эрхлэгчийг бусдаас ялгах, таних зорилгоор ашиглаж буй нэр юм. Ихэнх улсуудад арилжааны нэрийг захиргааны байгууллагад бүртгүүлэхээр зохицуулдаг боловч, аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцын 8-р зүйлд холбооны гишүүн бүх оронд арилжааны нэрийг барааны тэмдгийн бүрдэлд орсон эсэхээс үл хамааран түүнийг мэдүүлэг гаргах эсхүл бүртгүүлэхийг шаардахгүйгээр хамгаална гэж заасан байдаг. Арилжааны нэрийг хамгаална гэдэг нь өргөн утгаараа аливаа компанийн арилжааны нэрийг бусад этгээд арилжааны нэр эсхүл барааны тэмдэг болон үйлчилгээний тэмдгээр ашиглах боломжгүй байх төдийгүй тухайн барааны тэмдэг болон арилжааны нэр нь олон нийтийг төөрөгдүүлэхээр ижил төсөөтэй байх аваас мөн ашиглах боломжгүй гэснээр ойлгоно. (Wipo 2016, Understanding industrial property, 20-р тал)

Дээрхээс үзэхэд Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцоор Арилжааны нэр болон Барааны тэмдгийг аж үйлдвэрийн өмчид хамруулснаар, Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас Арилжааны нэрийг тухайн улсад заавал бүртгүүлэхийг шаардахгүйгээр хамгаалахаар зохицуулсан бөгөөд Монгол улсын хувьд 1970 онд Парисын конвенцод нэгдэн орсон учраас олон улсын хэлэлцээрийн дагуу Арилжааны нэрийг заавал хамгаалах үүрэг хүлээж байна.

Парисын конвенцын 2-р зүйлийн 1-д “Холбооны аливаа гишүүн орны харьяат аж үйлдвэрийн өмчийн эрхийн хувьд энэхүү конвенцоор тусгайлан олгосон эрхийг хөндөхгүйгээр холбооны бусад бүх орны хуулиар өөрийн харьяатад олгодог, эсхүл цаашид олгох давуу эрхийг эдэлнэ. Иймд тэд тухайн орнууд өөрийн харьяатад тавих албан ёсны шаардлага, нөхцөлийг мөрдөж байвал тэдгээрийн адил эрхийн хамгаалалт болон эрхийг зөрчих тохиолдолд тэдний аливаа эрх зүйн адил хамгаалалттай байна” гэж заан үндэсний харьцааны (national treatment) зарчмыг тусгаж өгсөн байдаг. Мөн тус конвенцын 3-р зүйлд “Холбооны гишүүн орны харьяат биш боловч холбооны орнуудын аль нэгэнд байнга оршин суудаг, эсхүл тэр оронд үйлдвэрийн буюу худалдааны газар эзэмшдэг этгээдийг холбооны орны харьяаттай адилтган авч үзнэ” гэж заасны дагуу конвенцод нэгдэж ороогүй орны харьяатыг ч мөн уг зүйлийн урьдчилсан нөхцөлийг хангаж буй тохиолдолд гишүүн орнууд өөрийн улсын харьяатын адилаар хамгаалах үүрэг хүлээнэ.

Мөн тус конвенцын 8-р зүйлд “Холбооны гишүүн бүх оронд аж ахуйн нэгжийн нэрийг барааны тэмдгийн бүрдэлд орсон эсэхээс үл хамааран түүнийг мэдүүлэг гаргахыг шаардахгүйгээр эсхүл бүртгэлгүйгээр хамгаална” гэж заасан хэдий ч яг ямар байдлаар хамгаалах нь тодорхойгүй байдаг бөгөөд энэ нь гишүүн улсууд арилжааны нэрийн талаар хууль тогтоомждоо ямар хамгаалалт хийснээс хамаарна гэсэн үг юм.

#### **1.4. Арилжааны нэрийн хуулийн хамгаалалтын онолын үндэс**

Эрдэмтэн багш Б.Амарсанаа нарын бүтээлд үндэслэвэл, арилжааны нэрийг урт хугацааны туршид ашигласнаар уг нэр нь хэрэглэгч, үйлчлүүлэгчийг татах чиг үүргийг гүйцэтгэх бөгөөд олон нийт арилжааны нэрийн ард байх арилжаа эрхлэгчээс илүүтэй арилжааны нэрд итгэх нь илүү болж ирдэг. Энэ нь арилжааны нэртэй холбоотой эдийн засгийн ашиг сонирхол үүсэж буйг харуулж буй юм. Иймээс арилжааны нэрийг хөрөнгө гэж үзэн түүнийг өвлүүлэх, шилжүүлэх, ашиглуулах, бусад этгээд хууль бусаар ашиглахаас хамгаалах зэрэг эрх зүйн хамгаалалт шаардлагатай болдог. Мөн арилжааны нэрийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд Арилжаа эрхлэгч, Олон нийт, Өрсөлдөгч этгээдийн эрх ашгийг тэнцвэртэйгээр хамгаалахыг зорьдог гэжээ. (Б.Амарсанаа, 2022, 97-р тал)

Арилжааны нэр нь эдийн засгийн харилцаанд оролцогчдын итгэлийг хадгалах арга хэрэгсэл учраас арилжаа эрхлэгчид эдийн засгийн үр өгөөжөө нэмэгдүүлэхэд дэм болдог. Арилжааны нэр нь олон нийтийн зүгээс арилжааны нэрд төөрөгдөхгүй байх, бараа болон үйлчилгээний гарал үүслийг таних, мэдээллийг дамжуулах, түүнээс үүдэн



ямар нэг хохирол учрахгүй байх буюу хариуцлагатай байх үүргийг гүйцэтгэдэг. Харин бизнесийн хамтрагчийн зүгээс хэлцлийн найдвартай байдал болон итгэлийг хамгаалах зарчмыг хэрэгжүүлэх, шударга өрсөлдөөний зарчмаар эрх ашгаа хамгаалуулахыг зорилгоо болгодог. Арилжааны нэр нь эдийн засгийн үр өгөөж бий болгодог утгаараа эд хөрөнгийн эрхэд тооцогдож түүнийг өвлүүлэх, бэлэглэх, шилжүүлэх, бусад этгээдийн эрх зөрчих үйлдлээс хамгаалах зэрэг эрх зүйн хамгаалалт шаардлагатай болдог. (Ханнс Зайделийн Сан, 2019, 42-43р тал)

Дээрхээс үзэхэд Арилжааны нэр гэдэг ойлголт нь эдийн засгийн үр өгөөжийг бий болгодог гэдэг утгаараа Парисын хэлэлцээрийн хүрээнд аж үйлдвэрийн өмч гэж хүлээн зөвшөөрөгдсөн байх бөгөөд, дэлхийн оюуны өмчийн эрх зүйн эрдэмтэд Арилжааны нэрийг оюуны өмч гэж үзэх асуудал нь маргаантай байдаг хэдий ч Аж үйлдвэрийн өмч гэдэг утгаараа хуулиар хамгаалагдах өмч гэж үзэх онолын судалгаанууд нэлээдгүй бүтээгдсэн байдаг.

Өмчлөх эрхийн сэтгэлгээ нь тэртээ эртний Грек, Ромын сэтгэгчдийн философиос үндэстэй хэдий ч өмчлөх эрхийн талаарх хамгийн их түгэн дэлгэрсэн онолын урсгал бол Жон Локкийн (1632-1704) өмчийн тухай хөдөлмөрийн онол юм. Тэрээр жам ёсны эрхийн үүднээс өмчлөх эрх гэдэг бол хүний эрх, эрх чөлөөний салшгүй нэг хэсэг гэдэг утгаар нь тайлбарласан эрх зүйн онолч юм. Тэрээр хязгаарлаж болдог зарим эрхүүдээс өмчлөх эрхийг тусгаарлаж, өмчлөх эрх нь амьд явах эрхтэй нэгэн адил үндсэн эрх болж бичигдэх ёстой гэж үзжээ. (Г.Агар-эрдэнэ, 2013, 8-р тал)

Тэрээр “Засаглалын тухай хоёр шастир” бүтээлдээ “Бурхан дэлхий ертөнцийг нийт хүн төрөлхтөнд өгсөн төдийгүй тэдэнд дэлхийг өөрсдийн хамгийн сайн сайхнаар амьдрахад зориулан ашиглах шалтгаан нөхцөлүүдийг нь ч бүрдүүлж өгсөн юм. Байгаль дээр байгаа жимс, ургамал, мал амьтан бүгд л байгалиасаа бий болсон зүйл бөгөөд хүн төрөлхтөнд хамаарах тул хэн ч тусгайлсан давамгайл эрх эдлэхгүй. Эдгээр баялаг нь хүн бүрийн тусын тулд оршдог. Харин хүн бүхний тусын тулд оршиж буй байгалийн баялгийг хувийн өмчөө болгохын тулд хүн бие махбодоороо хөдөлмөр хийж, гараараа бүтээж байж өмчлөх эрх үүснэ. Жишээлбэл байгальд ургаж буй алимьг өөрийн болгохын тулд модноос авч, хазах хэрэгтэй болно, тэгсэн цагт тэр алим хувийн өмч болно. Өөрөөр хэлбэл ямар нэгэн объектод хөдөлмөрөө шингээж, түүндээ өөрийн хөдөлмөрийн үр дүнг нэгтгэсэн тохиолдолд тэр зүйл тухайн хүний хувийн өмч болно гэж үзжээ. (Г.Агар-эрдэнэ, 2013, 9-р тал)

Түүнчлэн Жон Локк хөдөлмөрийн үндсэн дээр өмчлөх эрх бий болно гэдгийг хүн анх төрсөн цагаасаа өөрийн бие махбод, оюун санаагаа өөрөө өмчлөх бөгөөд өөрийгөө өмчилсөн байгаа учраас өөрийн хөдөлмөрийг эзэмших, үр шимийг хүртэх, улмаар хувийн өмчтэй болох явдалтай учир зүйн холбоотой гэж үзжээ. Ийнхүү эд баялгийг өөрийн хөдөлмөрөөр хувийн өмч болгож өмчлөх явдал нь цаашдаа бурхнаас бүгдэд нь тэгш эрхтэйгээр олгосон хүн төрөлхтний нийтлэг ашиг сонирхолд хохирол учруулах магадлалтай байж болно. Учир нь байгалийн баялгийн хязгаарлагдмал байдал, түүний нөхөн сэргээгдэх цаг хугацаа зэрэгтэй холбоотой гэжээ. (Naser & Amin Naser', 2007, 5-р тал)

Тэрээр нийтийн эзэмшилд байсан зүйлийг хувийн өмч болгосноор олон нийт хохирох магадлалтай бөгөөд үүнийг шийдвэрлэхийн тулд тодорхой хязгаарлалт буюу хохирол учруулахгүй байх зарчмыг (no harm principle) баримтлах ёстой гэжээ. Энэхүү зарчим нь хоёр нөхцөлийг шаардах бөгөөд тэдгээр нь хангалттай хэдий ч ёс зүйтэйгээр (enough and as good) ашиглах болон үрэлгэн бус байх (non-waste condition) нөхцөл юм гэжээ.

Тодруулбал эхнийх нь, байгаль дээр бусад этгээд аль хэдийн өмчилсөн зүйлд халдахгүйгээр хувь хүн өөрийн хөдөлмөрийн үр шимээр өмчилж болох баялаг хангалттай хэмжээнд байх хэдий ч хэн нэгний өмчлөлд ороогүй зүйлийг өөрийн өмч болгох явдал нь бусдын нөхцөл байдлыг дордуулахаар бол хязгаарлах ёстой гэжээ. Өөрөөр хэлбэл бусдад гарз учруулахгүй хувийн өмчийг хүлээн зөвшөөрдөг. Хоёрдох нь, хэн ч бай өөрийн амьжиргааны хэрэгцээнээс давсан зүйлийг хувьчлах эрхгүй бөгөөд, учир нь хэрэгцээнээс давсан эд зүйл нь муудаж, хэрэггүй болдог. Тэрээр тайлбарлахдаа бурхан ямар ч зүйлийг устгах эсвэл муутгах зориулалтаар бүтээгээгүй бөгөөд хүн амьдралдаа муутгалгүйгээр ашиглаж өмчлөх баялаг нь хүний хөдөлмөрлөх чадварын хэмжээгээр тогтоогдоно гэжээ. (Naser & Amin Naser', 2007, 7-р тал)

Дээрх онол нь биет бус оюуны өмч, аж үйлдвэрийн өмчийн эрх зүйн онолын суурь гэхээс илүүтэйгээр биет хөрөнгө буюу физик чанарын хувьд бодит эд хөрөнгийн өмчлөлийн онолын суурийг илүү тайлбарладаг гэдэг шүүмжлэлд өртдөг хэдий ч эдүгээ оюуны өмч, аж үйлдвэрийн өмчийн эрх зүйн гол үндэслэл болсон онол болно.

Биет болон биет бус эд хөрөнгийн өмчийн ялгааны хувьд, эхнийх нь хуулиас тусдаа бие даан оршиж буй материаллаг эд зүйлийн талаарх эрхийг хуулиар олгодог бол хоёрдох нь хуульд тусгайлан биет бус, хийсвэр эд зүйлийг хийсвэрлэн тодорхойлж, түүндээ эрхийн ойлголтыг нэмж өгдөг байна. Нэмж тодруулбал, материаллаг эд

хөрөнгийн хувьд бусдад ашиглуулсан тохиолдолд эзнээс нь тухайн эрхийг салгаж ашиглах боломжгүй болгож байгаа бол, биет бус эд хөрөнгийн хувьд бусдад ашиглуулах тохиолдолд эзэмшигчийн ашиглах эрх хязгаарлагдахгүй байдаг явдал юм. (Naser & Amin Naser', 2007, 9-р тал)

Жон Локкийн хөдөлмөрийн онолоор Арилжааны нэрийг эзэмших, өмчлөх асуудлыг тайлбарлаваас, арилжааны нэрийг бүтээхэд шаардагдах үгсийн сан, үг хэллэг нь хүн төрөлхтөнд бүгдэд нь тэгш эрхтэйгээр бурхнаас өгсөн бэлэг байх бөгөөд, түүнийг ашиглан өөрийн оюун ухаан, бие махбодоо ашиглан хөдөлмөрөө шингээж өөрийн гэсэн Арилжааны нэрийг бүтээвээс түүний талаарх өмчлөл үүснэ гэсэн онол юм. Ийнхүү Арилжааны нэрийг авч ашиглахад суурь баялаг буюу үгсийн сан нь хангалттай байх хэдий ч ийнхүү авч ашиглах нь бусдын нөхцөл байдлыг дордуулахгүй байх, мөн үрэлгэн бус байх буюу үр ашигтайгаар ашиглах ёстой гэж тайлбарлагдах боломжтой юм.

Оюуны өмч, тэр дундаа барааны тэмдэгт болон арилжааны нэрийн өмчлөлийг хамгаалах ёстой гэсэн үзлийг зөвтгөдөг бас нэг онолын урсгал нь бол эдийн засгийн ютилитар онол юм. Ютилитари үзэл нь онолын хувьд аз жаргалыг гол үнэт зүйлээ болгодог. Энэ онолыг үндэслэгч нь Жэрэми Бентам бөгөөд тэрээр бүх хүн аливаа нэг үйлийн үр дүнд аль болох адил тэгш аз жаргалыг эдлэх эрхтэй гэж үздэг. Ютилитарианизмын онолыг нийгмийн халамжийн хэрэгжилтэд мөн ашигладаг. Эдийн засгийн ютилитарийг баримтлагчид сайн сайхан аж байдлын гол илэрхийлэл нь сэтгэл ханамж (utility) гэж үздэг тул тэдний философийн гол үндэслэл нь нийт эсвэл дундаж ханамжийг хамгийн их байлгах асуудал болдог. (А.Батпүрэв, n.d.)

Тэднээс оюуны өмчийн эрх зүйн нэрт эрдэмтэн Петер Менел (Peter Menell UC Berkley School of Law) хэлэхдээ, барааны тэмдгийн хамгаалалтыг ютилитар онолоор зөвтгөх боломжтой бөгөөд барааны тэмдгийн хууль нь зах зээл дээр хэрэглэгчдийг төөрөгдүүлэхгүй байх зорилгыг агуулдаг учраас эдийн засгийн анализаар тайлбарлах боломжтой гэж тайлбарлажээ. Харин Кэйт Аоки хэлэхдээ АНУ-ын үндсэн хуульд эхлээд барааны тэмдгийг өмч гэж хүлээн зөвшөөрдөггүй байсан ч сүүлд өөрчлөлт орсноор барааны тэмдгийг өмчтэй адилтган үзэх (as property equivalent) болсон буюу барааны тэмдэг эзэмшигчийг түүний зохиогч (quasi-authors) хэмээн адилтган үзэх болсон гэжээ. (Keith Aoki, 1993, 235-р тал)

Ютилитар онолоор барааны тэмдэг эсвэл арилжааны нэрийг хамгаалснаар өмч хөрөнгийг хамгийн их хэмжээнд өсгөх боломж бүрддэг учраас эдгээр нь хамгаалагдах ёстой гэж үздэг. Тодруулбал барааны тэмдэг эзэмшигчид давамгайл эрх (trademark

monopoly) олгох нь эд хөрөнгийг өсгөх буюу оптимал хэмжээнд хүргэдэг бөгөөд барааны тэмдгийн хамгаалалтыг хуулиар баталгаажуулах нь чухал гэж үздэг. Ютилитар онолчид оюуны өмч болоод барааны тэмдгийг хамгаалахын ашигтай болон давуу талуудыг дараах байдлаар авч үздэг. (Naser & Amin Naser', 2007, 25-р тал)

Барааны тэмдэг буюу брэндийн нэр (арилжааны нэр) нь хэрэглэгчдийн мэдээлэл хайх зардлыг (search cost) багасгадаг гэсэн санаа юм. Өөрөөр хэлбэл барааны тэмдэг нь хэрэглэгч өөрийн худалдаж авахыг хүсэж буй бараагаа сонгож авах, шийдвэр гаргалтыг түргэтгэж, идэвхжүүлдэг буюу хэрэглэгч зах зээл дээр байгаа ижил төрлийн бүтээгдэхүүн дундаас өөрийн худалдан авах барааг барааны тэмдгээр ялган таних боломжийг олгодог. Ингэснээр хойшдын худалдан авалтад төвөггүйгээр өөрийн хэрэгцээ, шаардлагыг хангасан бараагаа хайж цаг болон хүч зарцуулахгүйгээр барааны тэмдгээр ялгаж худалдан авалт хийдэг болдог гэсэн үг юм. Мөн үйлдвэрлэгчийн зүгээс барааны тэмдгийг бусдын бараа, үйлчилгээнээс өөрийнхийг ялгаж, хэрэглэгчдэд таниулах зорилгоор ашигладаг учраас таних, тогтооход амархан байдлаар ямар нэгэн нэр гэхээс илүүтэйгээр богино үг ашигладаг байна. (Naser & Amin Naser', 2007, 26-27р тал)

Жишээлбэл, нескафе брэндийн бүтээгдэхүүнийг хэрэглэж сурсан хэрэглэгч нь супермаркетэд байгаа ижил төрлийн кофенууд дундаас барааны шошгыг хараад төвөггүйгээр сонголтоо хийх боломжтой байдаг байхад хэрэв барааны тэмдэг ашигладаггүй байсан бол гаднаас нь хараад тэр бараа нескафегийх мөн эсэхийг шалгах ямар ч боломжгүй юм.

Ютилитар онолын хамгийн гол санаа нь барааны тэмдгийг хамгаалах систем бий болсноор хэрэглэгчдийн мэдээлэл хайх зардал багасахаас гадна үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцэхүйц чанар бүхий барааг үйлдвэрлэх сэдлийг төрүүлдэг байна. Учир нь гэвэл барааны тэмдгийн хамгаалалтын систем тогтоогүй байх үед үйлдвэрлэгчид илүү зардал гаргаж сайн чанарын бараа үйлдвэрлэх шаардлагагүй гэж үзэх бөгөөд өрсөлдөгчдийн зүгээс ямар ч зардалгүйгээр дуурайлгаж хийх боломжтой юм. Энэ байдал нь компанийн зүгээс барааны тэмдгийн нэр хүндээ хадгалахад хөрөнгө оруулалт хийхэд хойрго хандахад хүргэж, хэрэглэгчдийн мэдээлэл хайх зардал өсөхөд хүргэнэ гэжээ. (William M. Landes and Richard A. Posner, n.d.)

Тодруулбал аливаа бараа, үйлчилгээ нь бодит үнээр (full price) хэрэглэгчдэд хүрдэг бөгөөд, энэ нь бараа, үйлчилгээний үндсэн үнэ дээр нэмээд мэдээлэл хайлтын зардал (search cost) буюу тухайн бараа, үйлчилгээний онцлог шинж чанарын мэдээллийг хайж олоход зарцуулдаг зардал ордог байна. Тэдний тодорхойлсноор барааны тэмдэг

хэрэглэгчдэд танигдаж, мэдээллийг дамжуулснаар хэрэглэгчдийн мэдээлэл хайх зардлыг (search cost) багасгах бөгөөд, үйлдвэрлэгчийн зүгээс төдий хэмжээгээр бодит үнээс (full price) хэтрэхгүй хэмжээнд илүү их ашиг олох боломжтой гэж үзжээ. Өөрөөр хэлбэл компани брэндийн нэрийг таниулах, хөгжүүлэхэд хэр их хөрөнгө оруулалт хийснээр брэндийн нэрийн үнэ цэн улам өсөх бөгөөд ингэснээр хэрэглэгчдийн мэдээлэл хайх зардал багасаж, компани илүү өндөр үнээр бараа, үйлчилгээгээ нийлүүлэх боломжтой юм. (William M. Landes and Richard A. Posner, n.d.)

Ейл их сургуулийн хуулийн сургуулийн Профессор Стэфэн Картер (Stephen L. Carter)-ийн тодорхойлсноор барааны тэмдэг нь түүний бүрдэлд орсон тэмдэг эсвэл үсгээс илүүтэйгээр түүний агуулж буй мэдээлэл чухал гэдгийг чухалчлаад өөрийн бүтээлдээ гурван зүйлийг чухалчилжээ. Нэгдүгээрт, барааны тэмдэг нь үйлдвэрлэгчийг өөрийн олж авсан сайн нэр хүндээ хадгалах байдлаар шударга өрсөлдөөнийг дэмжиж, бараа бүтэгдэхүүний чанарыг хадгалах үүргийг гүйцэтгэдэг. Нэр хүндтэй барааны тэмдэг нь тухайн барааны тэмдэг хэрэглэгчдэд дамжуулж буй мэдээллийг үнэ цэнтэй болдог. Бизнесийн итгэл (business's goodwill) гэдэг нь хэрэглэгч тухайн барааны тэмдгийг хараад шууд мэдэх боломжтой мэдээлэл буюу, чанарын баталгаатай байдал, нэр хүнд болон бусад эерэг мэдээллүүдийг багцалсныг ойлгоно. Тиймээс бизнесийн итгэл гэдэг нь ихэвчлэн эх ундаргыг тодорхойлоход хэцүү хийсвэр ойлголт хэдий ч өрсөлдөгч брэндүүд дундаас хэрэглэгчид сонголт хийхэд хамгийн их чухал нөлөөтэй учраас фирмийн хувьд хамгийн чухал үнэ цэнтэй өмч юм. Өөрөөр хэлбэл барааны тэмдэг гэдэг нь төлөөлж буй фирмийн бизнесийн итгэлгүйгээр ямар ч утгагүй, хий хоосон бэлэг тэмдэг болно гэжээ. (Carter, 1990, 761-р тал)

Хоёрдугаарт, тэрээр эдийн засгийн онолын үүднээс барааны тэмдгийг хамгаалах нь хэрэглэгчдийн мэдээлэл хайх зардлыг (search cost) багасгадаг гэдгийг дурдаад, хэрэв бараа бүтээгдэхүүн тэмдэггүй байсан бол потенциал хэрлэгчид аливаа брэндийн нэр (арилжааны нэр) эсвэл ялгагдах баглаа, боодолд үндэслэн үйлдвэрлэгчийг ялгах боломжгүйгээс заавал бүтэгдэхүүнийг хэрэглэж үзэх буюу тест хийх шаардлага үүснэ. Түүнчлэн хэдий хэр үнэ цэнтэй барааны тэмдэг байна компанийн зүгээс төдий хэмжээгээр барааны чанарыг хадгалахыг хичээж, энэ нь илүү үнэ цэнийг бүтээж, хэрэглэгчдийн мэдээлэл хайх зардлыг бууруулдаг гэжээ. (Carter, 1990, 762)

Эцэст нь тэрээр бидний өдөр тутамд хэрэглэдэг хэлнээс тусдаа зах зээлийн хэл (market language) гэж байх бөгөөд энэ нь бараа, үйлчилгээний талаарх мэдээллийг хэрэглэгчдэд хүргэхэд шаардлагатай бүхий л үг, хэллэгийг багтаасан, фирмийн зүгээс

хэрэглэгчидтэй харилцахад ашигладаг хэл юм. Барааны тэмдэг нь тус хэлний нэгээхэн хэсэг юм. Аливаа нэг фирм барааны тэмдгийг бүртгүүлж ашигласнаар хуулиар хамгаалагдах үед дараагийн фирмийн ашиглах үг хэллэг тэр хэмжээгээр багасаж байдаг. Гэсэн хэдий ч хэрэглэгчдийн зүгээс тухайн барааны тэмдгийг мэдээлэл багцлах хэрэгсэл (information-economizing device) болгон ашиглаж эхлэх үед тухайн үг хэллэгийг хассанаас үүдэх сөрөг үр дагавраас илүү өгөөж нь их болдог гэжээ. (Carter, 1990, 763-р тал)

Өмнөх тайлбарын адилаар барааны тэмдэг нь хэлний хөгжилд хувь нэмэр оруулдаг гэжээ. Барааны тэмдгийг хуулиар хамгаалах нь фирмийн зүгээс бараа бүтээгдэхүүний чанараа хадгалахаас гадна шинэ үг бүтээхэд хөрөнгө оруулалт хийх шаардлагыг үүсгэдэг гэжээ. Өөрөөр хэлбэл нэгт, бараа бүтээгдэхүүнийг нэрлэх үгсийн санг нэмдэг, хоёрт, шинээр үгийг үүсгэж нийтэд түгээмэл болгодог (generic words), гуравт, тэд шинээр үг эсвэл хэллэг бүтээж, олон нийт түүнийг ашиглаж, эерэг утга болон мэдээлэлтэй холбож эхэлснээр хэлийг баяжуулдаг гэжээ. (Doellinger, n.d., 834-р тал)

Товчхондоо тайлбарлавал, эдийн засгийн онолын өнцгөөс барааны тэмдэг болоод арилжааны нэр нь өмнөх худалдан авалтын туршлагадаа үндэслэн бусад барааны тэмдэг болон арилжааны нэрээс ялгах боломжтой тэмдэг бөгөөд хоёр чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үзэж байна. Эхнийх нь, барааны тэмдэг нь барааны чанарыг хадгалах буюу сайжруулах чиг үүрэг гүйцэтгэдэг бол, хоёрдох нь, олон нийтийн зүгээс худалдан авалт хийх шийдвэр гаргах зардлыг бууруулдаг гэсэн тайлбар юм.

Барааны чанарыг хадгалах, сайжруулах үүрэг гэдэг нь барааны тэмдэг болон арилжааны нэр нь тухайн бараа үйлдвэрлэгчийн зүгээс өөрийн барааны талаарх хариуцлагыг нэмэгдүүлдэг гэх бөгөөд тиймээс барааны тэмдгийн хуулиар тухайн барааны чанарыг сайжруулахад гаргасан хөрөнгө оруулалтыг хамгаалахыг зорилгоо болгодог гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл барааны тэмдгийг ашигласнаар барааны чанарыг тодорхой түвшинд хадгалах шаардлага үүсдэг гэсэн үг юм. Олон нийтийн худалдан авалтын зардлыг бууруулах гэдэг нь хэрэглэгчдийн зүгээс бараа, үйлчилгээг сонгоход шаардлагатай мэдээлэл, цаг хугацаа, хүчин чармайлтыг хөнгөвчилдөг гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл ямарваа нэгэн шинэ бараа, үйлчилгээ зах зээлд гарч ирэх үед тухайн бараа, үйлчилгээг хэрэглэж үзэх шаардлагагүйгээр тухайн барааны тэмдгийг харж сонголт хийх боломжийг олгож байна гэсэн үг юм. Энэ нь өнөөгийн цаг завгүй иргэдийн амьдралд илүү чухал үүргийг гүйцэтгэдэг гэж ойлгож болохоор байдаг байна.

Ерөнхийдөө эдийн засгийн болон маркетингийн онол, эрх зүйн онолын хувьд барааны тэмдэг нь барааны гарал үүслийг илтгэх, чанарын баталгааг хангах, зар сурталчилгааны гол хэрэглэгдэхүүн болох, удаан хэрэглэсний үр дүнд биет бус хөрөнгө болох гэсэн чиг үүргийг гүйцэтгэдэг гэдэгт нэгдмэл байр суурьтай байх хандлагатай байдаг.

## **II БҮЛЭГ. МОНГОЛ УЛСАД АРИЛЖААНЫ НЭР ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ ХЭРХЭН ЗОХИЦУУЛСАН ТАЛААР**

### **2.1. Монгол улсын хуулийн этгээдийн нэрийн зохицуулалт**

Монгол улсын эрх зүйн тогтолцоонд төрөлжсөн арилжааны хууль байхгүй учраас арилжааны нэр гэх ойлголт хараахан төлөвшөөгүй хэдий ч энэ нь арилжааны нэрийн зохицуулалт огт байхгүй гэсэн үг биш юм. Өнөөгийн Монгол улсын эрх зүйн тогтолцоо дахь хуулийн этгээдийн оноосон нэр буюу тэр дундаа ашгийн төлөөх хуулийн этгээд болох компани, нөхөрлөлийн оноосон нэр нь арилжааны нэрийн чиг үүргийг гүйцэтгэж байна. Тодруулбал Монгол улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д "хуулийн этгээдийн нэр" гэж Иргэний хуулийн 27 дугаар зүйлд заасан, хуулийн этгээдийг бусад хуулийн этгээдээс ялгах зорилгоор хэрэглэх нэрийг гэж заасан байх бөгөөд, Иргэний хуулийн 27-р зүйлд Хуулийн этгээдийн нэрийн зохицуулалтыг дараах байдлаар тусгажээ.

27.1.Хуулийн этгээд өөрийн нэртэй байна. Хуулийн этгээдийн нэр нь түүний зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан байна.

27.2.Хуульд заасан бол хуулийн этгээдийн төрлийг заасан нэртэй байна.

27.3.Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй.

27.4.Хуулийн этгээдийн нэрийг бусад этгээд хууль бусаар ашиглахыг хориглоно. Энэ заалтыг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг энэ хуулийн 497 дугаар зүйлд заасан журмын дагуу арилгана.

27.5.Хуулийн этгээд нэрээ хуульд заасан журмын дагуу бүртгүүлнэ.

27.6.Хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалахад энэ хуулийн 21 дүгээр зүйлийн заалт нэгэн адил хамаарна.

#### **2.1.1 Оноосон нэр сонгох түүнд тавигдах хязгаарлалтууд**

Дээрхээс үзэхэд Монгол улсын Иргэний хуульд хуулийн этгээдийн нэрийн зохицуулалт ерөнхийлсөн байдлаар тусгагджээ. Ялангуяа хуулийн этгээдийн нэрд тавигдах шаардлагууд болох, өөрийн оноосон нэртэй байх, түүний зохион байгуулалт болон хэлбэр, төрлийг тусгасан байх, өөр этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил төсөөтэй байж болохгүй зэрэг зохицуулалтуудыг тусгасан байна. Мөн түүнчлэн хуулийн этгээдийн нэрийн хамгаалалтын зохицуулалт болох хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулж бүртгүүлснээр хуулиар хамгаалагдах, хууль бусаар ашиглахыг хориглох, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах гэсэн заалтууд туссан байна.



Тэгвэл арилжаа эрхлэгч гэдэг нь хувь хүн болон хуулийн этгээдийн аль ч байж болно гэдэг утгаараа, ашгийн төлөө хуулийн этгээд болох компани, нөхөрлөл болон хувиараа арилжаа эрхлэгчийн нэрийг тухайлсан хуулиудад хэрхэн зохицуулсныг авч үзье.

Юуны өмнө компанийн тухай хуулийн 10-р зүйлд Компанийн оноосон нэрийн зохицуулалтыг тусгасан байх бөгөөд тодруулбал, компани нь оноосон нэртэй байх, хэлбэрийг тодорхойлсон тэмдэглэгээг хэрэглэх, өөр хуулийн этгээдийн нэртэй давхардахгүй байх, бүртгүүлснээр хэрэглэх онцгой эрх үүсэх зэргийг заажээ.

10.1.Компани оноосон нэртэй байх бөгөөд түүнийг хэрэглэх тохиолдол бүрд уг нэрийн ард компанийн хэлбэрийг тодорхойлсон хувьцаат компани буюу "ХК", хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу "ХХК" гэсэн ялгах тэмдэглэгээ заасан байна.

10.2.Компанийн оноосон нэр нь бусад компани, өөр хуулийн этгээдийн оноосон нэртэй давхардаагүй байх бөгөөд компани оноосон нэрээ бүртгэх байгууллагад бүртгүүлснээр түүнийг хэрэглэх онцгой эрхтэй болно.

Харин нөхөрлөлийн тухай хуулийн 8-р зүйлд нөхөрлөлийн нэрийн зохицуулалтыг тусгасан байх бөгөөд мөн адил бусад нөхөрлөлийн нэртэй давхардаагүй байх, нөхөрлөлийн хэлбэрийг тусгасан тэмдэглэгээг заавал ашиглах гэсэн шаардлагуудыг заасан байна.

1.Нөхөрлөл оноосон нэртэй байна. Оноосон нэр товч бөгөөд төрийн албан бичгээр илэрхийлэгдсэн, бусад нөхөрлөлийн оноосон нэртэй давхардаагүй байна.

2.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа аж ахуйн нэгжүүдийг энэ хуульд зааснаас өөрөөр нэрлэхийг хориглоно.

Манай улсад Арилжааны нэр гэсэн ойлголтыг хэрэглэхгүй, хуулийн зохицуулалт байхгүйгээс нийгэмд арилжааны нэрийг дээрхийн адил компани, нөхөрлөлийн нэр төдийгөөр л ойлгож байна. Мөн түүнчлэн зарим хувиараа арилжаа эрхлэгчид бизнесээ илтгэх нэрийг ашигладаг ч түүнийгээ арилжааны нэр гэж ойлгохгүй буюу ашигтай чанарыг нь гаргахгүй байна. Гэтэл хувиараа худалдаа, үйлчилгээний газар ажиллуулж буй арилжаа эрхлэгчдийн нэрийг бүртгэх тогтолцоо байхгүйгээс ихэнх хувиараа аж ахуй эрхлэгчид иргэнийхээ бүртгэлээр бүхий л аж ахуйгаа тайлагнаж явж байна. Жишээлбэл, хувиараа “Туяа салон” гэдэг үсчин, гоо сайхны газар ажиллуулдаг иргэн Туяа арилжааны үйл ажиллагаа явуулдаг ажлын байртай хэдий ч компани байгуулахгүй л бол арилжааны үйл ажиллагааны нэр болох “Туяа Салон” ямар нэг бүртгэлд бүртгэгдэхгүй Иргэн Туяагаар л татвар, санхүүгийн бүртгэл хийгдэж, тайлагнагдаж байна.

Өмнө хэлсэнчлэн тусгайлсан бүртгэлийн тогтолцоо байхгүй учраас хувиараа аж ахуй эрхлэгчийн хувьд Иргэний хуулийн ерөнхий заалтуудаар зохицуулагдах бөгөөд, Иргэний хуулийн 20-р зүйлд Иргэний нэрийн зохицуулалтыг тусгасан байна. Тодруулбал иргэн нь өөрийн нэртэй байх бөгөөд, эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, зохиомол нэр ашиглаж болох, нэрээ өөрчлөх зэрэг гол гол зохицуулалтуудыг тусгажээ.

20.1.Иргэн өөрийн нэртэй байна.

20.2.Иргэний нэрийг бүртгэх, өөрчлөх журмыг хуулиар тогтооно.

20.3.Иргэний нэрийг эрх бүхий байгууллагад бүртгүүлнэ. Иргэний эрх, үүргийг иргэн өөрийн нэрээр олж авч хэрэгжүүлнэ. Гагцхүү хуульд заасан нөхцөл, журмын дагуу зохиомол нэр хэрэглэж болно.

20.4.Иргэн нэрээ өөрчилсөн нь түүний өмнөх нэрээр олж авсан эрх, хүлээсэн үүргийг өөрчлөх буюу дуусгавар болгох үндэслэл болохгүй.

Дээр үзүүлсэнчлэн иргэний нэр нь арилжааны үйл ажиллагааны нэр бус учраас хувь хүнд чиглэсэн зохицуулалтуудыг хамарсан байна. Мөн түүнчлэн Иргэний бүртгэлийн тухай хуулийн 12.4 хэсэгт “Иргэн өөрийн нэрийг нэг удаа өөрчилж болно” гэж заасан байгаа нь иргэний нэрээр арилжааны үйл ажиллагаа явуулах, иргэний бүртгэл болон арилжааны бүртгэл зэрэг нь зохицуулах харилцааны хувьд тэс ондоо гэдгийг харуулж байна. Тиймээс энэхүү судалгаанд хойшид зөвхөн ашгийн төлөөх хуулийн этгээдийн нэрийн зохицуулалтыг голчлон авч үзлээ.

Дээр дурдсанчлан хуулийн этгээдийн нэрийн зохицуулалтыг Монгол улсын иргэний хууль болон тусгайлсан хуулиудад тодорхой хэмжээнд зохицуулалтыг тусгажээ. Тэгвэл Монгол улсад өнөөгийн байдлаар хуулийн этгээдийн нэрийг сонгох болон баталгаажуулах, бүртгүүлэх тогтолцоо хэрхэн зохицуулагдаж байгаа талаар авч үзье.

Дэлхийн улсуудад арилжааны нэрийг сонгоход, арилжааны нэр үнэн зөв байх зарчим, арилжааны нэр чөлөөтэй байх зарчим, арилжааны нэр холимог байх зарчмаар ангилж үздэг. Арилжааны нэр үнэн зөв байх зарчим нь арилжааны нэр тухайн арилжаа эрхлэгчийн нэр, арилжааны үйл ажиллагаа, үйл ажиллагаа явуулж буй газар нутаг зэрэгтэй тохирсон байх ёстой бөгөөд арилжааны нэрийг шилжүүлэх, өв залгамжлуулах зэргийг зөвшөөрдөггүй. Эсрэгээрээ арилжааны нэр чөлөөтэй байх зарчим нь арилжааны нэрд ямар нэгэн хязгаарлалт тавихгүй бөгөөд шилжүүлэх, захиран зарцуулах нь чөлөөтэй байдаг. Харин Холимог байх зарчмын хувьд арилжаа эрхлэгчийн нэр нь үйл ажиллагааны төрөлтэй зохицсон байхыг шаардах боловч үйл ажиллагаагаа шилжүүлэх, бэлэглэх, өв залгамжлуулах, арилжаа эрхлэгчийн овог нэр өөчлөгдөх, үйл ажиллагааны

төрлөө өөрчлөх зэрэгт өмнөх арилжааны нэрээ үргэлжлүүлэн ашиглахыг зөвшөөрдөг онцлогтой. (Н.Норовсамбуу, 2022, 107-р тал)

Судлаач багш Н.Норовсамбуугийн үзсэнээр Манай улс хуулийн этгээдийн нэрийг сонгоход холимог зарчим үйлчилж байна гэж үзэж байна. Учир нь хуулийн этгээдийн нэрийг сонгоход тодорхой төрлийн хязгаарлалтуудыг тогтоосон байх бөгөөд, Иргэний хуулийн 27.2-д заасны дагуу “Хуульд заасан бол хуулийн этгээдийн төрлийг заасан нэртэй байна” гэсэн байх бөгөөд энэ нь тусгайлан хуульд заасан бол үйл ажиллагааныхаа төрөлд нийцсэн нэртэй байхыг шаардаж буй зохицуулалт юм. Тухайлбал, 2018 оны Засгийн Газрын 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам”-ын 3.8, 3.9 хэсэгт дараах байдлаар хязгаарласан байна.

3.8.Хуульд заасан тохиолдолд хуулийн этгээдийн нэрийн хойно үйл ажиллагааны чиглэлийг илэрхийлсэн үг, эсхүл товчилсон үгийг хэрэглэнэ. Жишээлбэл: “Өмгөөллийн мэргэн ХХН”, “Алтан төгрөг ББСБ” гэх мэт.

3.9.Боловсрол, соёл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн нэр холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн байна. Жишээлбэл: Нийслэлийн ерөнхий боловсролын 5 дугаар сургууль, Нийслэлийн 128 дугаар цэцэрлэг, Ерөнхий боловсролын Хүрээ тулга сургууль, “Алтан чагнуур өрхийн эрүүл мэндийн төв” гэх мэт. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 245 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

Дээрх журмын 3.8-д заасан тусгайлан хуулиар үйл ажиллагааны чиглэлийг заавал заахаар зохицуулсан хуулийн этгээдийг судалж үзвээс, өнөөгийн байдлаар Банкны тухай хуулийн 26.1 дэх хэсэгт “Банкны нэр нь түүний оноосон нэр болон "банк" гэсэн үгнээс бүрдэнэ”, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 11.1 дэх хэсэгт “Банк бус санхүүгийн байгууллагын нэр нь түүний оноосон нэр болон "Банк бус санхүүгийн байгууллага" гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл "ББСБ" гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ”, Даатгалын тухай хуулийн 60.1 дэх хэсэгт “Даатгагч нь оноосон нэртэй байх бөгөөд уг нэрийн ард "даатгал" гэсэн үгийг заавал хэрэглэнэ”, Аудитын тухай хуулийн 20.3 дахь хэсэгт “20.3.Тусгай зөвшөөрөл авсан аудитын хуулийн этгээд нь "Аудит" гэсэн үгийг оноосон нэрийн ард хэрэглэнэ” гэж тус тус заажээ.

Харин өмгөөллийн тухай хуульд өмгөөллийн фирм нь үйл ажиллагааны чиглэлийг заавал тусгах тухай заалт байхгүй байна. Тус журмын 3.9-д заасан Боловсрол, соёл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах байгууллагын хувьд тусгайлан хуульд заагаагүй ч гэсэн хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журмын дагуу заавал

үйл ажиллагааны чиглэлийг эмнэлэг, сургууль, цэцэрлэг гэх мэтээр заахаар зохицуулсан байна.

### **2.1.2 Оноосон нэр нь бусдыг төөрөгдүүлэхгүй байх талаарх зохицуулалтууд**

Хуулийн этгээдийн оноосон нэрийг сонгоход хэлбэрийн болон үйл ажиллагааны чиглэлийг заавал тусгах талаарх зохицуулалтуудыг өмнөх хэсэгт тодорхойлсон бол энэ хэсэгт хуулийн этгээдийн оноосон нэр сонгоход бусдыг төөрөгдүүлэхгүй байх хязгаарлалтууд авч үзье. Энэ талаарх зохицуулалт мөн адил Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журамд тусгагдсан байх бөгөөд тус журмын гуравдугаар хэсэг буюу “Хуулийн этгээдийн нэрд тавигдах шаардлага” хэсгээс ашгийн төлөөх хуулийн этгээдийн нэрд хамаарах зохицуулалтууд нь дараах байдлаар илэрч байна.

Хуулийн этгээдийн нэр Иргэний хуулийн 27.3-т зааснаар өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй бөгөөд дараах тохиолдолд бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй гэж үзэж баталгаажуулахгүй:

3.10.1.хуулийн этгээдийн нэрийн санд бүртгэгдсэн хуулийн этгээдийн нэрийн өмнө болон хойно зохион байгуулалтын хэлбэрийг тусгасан бол. Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Төмөр” гэсэн нэр бүртгэгдсэн байвал “Төмөр групп”, “Төмөр концерциум”, “Төмөр холдинг”, “Төмөр корпораци” гэсэн нэрийг;

3.10.2.төрийн өмчит хуулийн этгээдээс бусад хуулийн этгээдийн нэрийн өмнө болон хойно Монгол, МН, Эм Жи Эл, МЖЛ, Мон, МНЖ зэргээр “Монгол” гэсэн утга санаагаар ялгаж бичсэн бол. Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Төмөр” гэсэн нэр бүртгэгдсэн байвал “Төмөр МН”, “Төмөр Монгол”, “Мон төмөр” гэсэн нэрийг;

3.10.3.хуулийн этгээдийн нэрийн санд бүртгэгдсэн нэрийн хойно тоо бичсэн бол. Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Номин” гэсэн нэр бүртгэгдсэн бол “Номин нэг”, “Номин хоёр” гэсэн нэрийг;

3.10.4.баталгаажуулах нэр нь бичвэр, хэлбэр, авианы дуудлагын хувьд хуулийн этгээдийн нэрийн санд бүртгэгдсэн нэрийн үгийн үндэс, үеэр төсөөтэй бол. Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Баян гео”, “Эко систем” гэсэн нэр бүртгэгдсэн байвал “Баян геологи”, “Экологи систем” гэсэн нэрийг;

3.10.8.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс бусад хуулийн этгээдийн нэрийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэрээр ялган бичсэн бол.

Жишээлбэл: хуулийн этгээдийн нэрийн санд “Дорнын саран” гэсэн нэр бүртгэгдсэн байвал “Завхан дорнын саран” гэсэн нэрийг;

3.10.9.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс бусад хуулийн этгээдийн нэрд төрийн байгууллагын чиг үүрэг, нэрийг оролцуулан бичсэн бол. Жишээлбэл: “Дагнасан оюуны өмчийн газар” ТББ, “Мэргэшсэн оюуны өмчийн газар” ХХК гэсэн нэрийг;

3.10.10.хуулийн этгээдийн нэрд хуулийн дагуу сонгогддог болон томилогддог албан тушаалын нэрийг оролцуулан бичсэн бол. Жишээлбэл: “Ард түмний ерөнхийлөгч”, “Улсын Их Хурлын шилдэг гишүүн” гэсэн нэрийг;

3.10.12.чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэхээс бусад хуулийн этгээдийн нэрд “... чөлөөт бүс” гэж бичсэн бол.

Дээрхээс үзэхэд зохион байгуулалтын хэлбэр, газарзүйн байршил, үндэстнийг илэрхийлсэн тэмдэг, тоон дараалал зэргийг нэмэх болон үгийн үндэс нэг байхыг бусдыг төөрөгдүүлэхээр ижил төсөөтэй гэж үзэж байна. Харин эрх олгогдоогүй чиг үүргийг оролцуулж нэр авах нь мөн бусдыг төөрөгдүүлэх онцлогтой гэдэг утгаар, төрийн байгууллага болон ард түмнээс сонгогддог албан тушаалыг ашиглах, тусгайлан зохицуулагддаг чөлөөт бүс гэх нэршлийг ашиглахыг тус тус хориглож байна. Мөн хуулийн этгээдийн оноосон нэртэй холбоотой бас нэг онцлог зохицуулалт нь тус журмын 4.9 дэх хэсгийн “Хуулийн этгээд нэг жилд 2-оос илүүгүй удаа нэрээ өөрчлөхөөр баталгаажуулж болно” гэсэн байх бөгөөд энэ нь мөн адил олон нийт хуулийн этгээдийн нэрд төөрөгдөхгүй байхаас сэргийлсэн зохицуулалт болно.

### **2.1.3 Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах үеийн зохицуулалтууд**

Өмнө үзсэнчлэн хуулийн этгээдийн нэрийг сонгон авч ашиглахад тодорхой төрлийн хязгаарлалтууд үйлчилж байна. Тэгвэл сонгон авсан хуулийн этгээдийн нэрийг хэрхэн бүртгүүлж, баталгаажуулах талын зохицуулалтыг авч үзье. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулийн 7-р зүйлд заасны дагуу хуулийн этгээд болон түүний салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлийн байгууллагад заавал бүртгүүлж үйл ажиллагаа явуулах бөгөөд үүнээс арилжааны үйл ажиллагаа буюу ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд нь компани, нөхөрлөл болно.

Компани, нөхөрлөл нь тус хуулийн 13-р зүйлийн 1-д заасны дагуу дараах тохиолдолд хуулийн этгээдийн нэр авах хүсэлт гаргаж, тухай нэрийн баталгаажуулалтыг хийлгэх бөгөөд бас нэг онцлог зохицуулалт нь хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн

газарт нэр олгохгүй бөгөөд тухайн хуулийн этгээдийн нэрийг ашиглахаар зохицуулсан байдаг. Дараах тохиолдолд хуулийн этгээдийн нэрийн баталгаажилтыг хийлгэнэ.

- 1.Хуулийн этгээдийг шинээр байгуулах;
- 2.Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах;
- 3.Хуулийн этгээдийн нэрийг өөрчлөх.

Хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, нэр өөрчлөх зорилго бүхий компани, нөхөрлөлийн дараах эрх бүхий албан тушаалтан нэр авах, баталгаажуулах хүсэлтийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр улсын бүртгэлийн байгууллагад биечлэн эсвэл цахимаар гаргана. Эрх бүхий албан тушаалтан гэдэгт дараах этгээдийг ойлгоно.

- 1.Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч;
- 2.Хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага;
- 3.Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд.

2024 оны байдлаар цахим хэлбэрээр хуулийн этгээдийн нэр авах хүсэлтийг өмнө нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын сайтаар дамжуулж авдаг байсан бол цахим үндэстэн болох зорилт бүхий e-mongolia төрийн үйлчилгээний цахим платформыг хөгжүүлснээр тус платформын хуулийн этгээдийн хандалтын сайт болох <https://e-business.mn/> системээр дамжуулан хийж байна. Ийнхүү нэвтрэхдээ тоон гарын үсэг эсвэл банкны эрх, гар утасны дугаараар нэвтэрч орон оноосон нэрийн хайлт хийж, нэг өдөрт дээд тал нь гурван оноосон нэр авах хүсэлт илгээх боломж бүрдсэн байна.

Цахим системээр гаргасан оноосон нэр авах хүсэлтийг Улсын бүртгэлийн газраас оноосон нэр сонгоход тавигдах шаардлагуудыг хангасан эсэх, бусад хуулийн этгээдийн нэртэй төөрөгдөхүйц ижил төсөөтэй эсэхийг нягталж үзээд дөчин найман цагийн хугацаанд зөвшөөрөх эсвэл татгалзах хариуг цахимаар өгнө. Хэрэв нэр баталгаажсан тохиолдолд тус оноосон нэрийг авч ашиглахын тулд дараах материалыг бүрдүүлж улсын бүртгэлийн байгууллагад хүсэлт гаргаснаар тухайн нэрийг авч ашиглах нөхцөл бүрдэж байна.

- 1.Иргэний үнэмлэх, эсхүл үндэсний гадаад паспортын хуулбар;
- 2.Эрх бүхий этгээдийн шийдвэр; (ХХК бол хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, ХК бол ТУЗ-ийн шийдвэр)
- 3.Итгэмжлэлээр эрх олгогдсон этгээдийн тухайд итгэмжлэл;

#### 4. Үйлчилгээний хөлс төлсөн баримт.

##### 2.1.4 Хуулийн этгээдийн нэрийг бусдад шилжүүлэх зохицуулалтууд

Компани, нөхөрлөлийн нэрийг бусдад шилжүүлэх талаар тусгайлан зохицуулсан хууль, журам одоогоор байхгүй байна. Компанийн тухай хуулиар компанийн нэрийг дангаар нь бусдад шилжүүлэх боломжгүй бөгөөд үйл ажиллагааны хамтаар шилжүүлэх боломжтой юм. Тус хуулийн 18-р зүйлд заасны дагуу компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар бусдад шилжүүлэх болон компанийг худалдах замаар бусдад шилжүүлэх боломжтой юм. Эдгээрээс компанийг нэгтгэх болон нийлүүлэх үед нэгдэж буй хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах бөгөөд энэ тохиолдолд хуулийн этгээдийн нэрийг ашиглах боломжгүй юм. Харин компанийг хуваах, тусгаарлах үед хуулийн этгээдийн нэрийг шинээр үүсгэн байгуулах компанид авч ашиглах боломжтой юм. Эцэст нь компанийг өөрчлөх буюу Хувьцаат компанийг Хязгаарлагдмал хувьцаат компани болгох, Хязгаарлагдмал хувьцаат компанийг Хувьцаат компани болгох тохиолдолд тухайн оноосон нэрийг хэвээр ашиглах боломжтой бөгөөд зөвхөн компанийн зохион байгуулалтын хэлбэрийг илэрхийлсэн ХК болон ХХК гэсэн тэмдэглэлийг өөрчлөх шаардлага үүсэх юм.

Тэгвэл татан буугдсан, нэрээ өөрчилсөн компанийн оноосон нэрийг дахин ашиглах боломжтой эсэхийг судалж үзвээс Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журмын 2.4-д татан буугдсан, нэрээ өөрчилсөн хуулийн этгээдийн нэрийг авах хүсэлтийг тухайн хуулийн этгээдийн татан буугдсаныг, эсхүл нэр өөрчилснийг улсын бүртгэлд бүртгэснээс хойш гуч хоногийн дараа гаргаж болох байна. Харин тус журмын 4.8-д заасны дагуу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу санхүүгийн тайлангаа найм болон түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй үндэслэлээр хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассанаас хойш нэг жилийн хугацаанд тухайн хуулийн этгээдийн нэрийг мөн хуулийн 26.3-т заасны дагуу олгохгүй байхаар зохицуулагдсан байна.

Дээрх зохицуулалтаас үзэхэд хуулийн этгээдийн оноосон нэр гэдгийг аж үйлдвэрийн өмч гэж үзэн, өмч хөрөнгийг чөлөөтэй шилжүүлэх, бусдад ашиглуулах, худалдах зохицуулалт өнөөгийн хуулийн хүрээнд зохицуулагдаагүй байна. Харин зөвхөн хуулийн этгээдийн нэр буюу компани, нөхөрлөл өөрийн оноосон нэрийг Оюуны өмчийн газарт барааны тэмдгээр бүртгүүлсэн тохиолдолд л барааны тэмдгийн хүрээнд олгогдох эрхийг эдлэхээр байна.

## **2.2. Монгол улсын хуулийн этгээдийн нэрийн эрх зүйн хамгаалалт болон зөрчлийн хариуцлага**

### **2.2.1 Хуулийн этгээдийн нэрийг ашиглахтай холбоотой зохицуулалт**

Арилжааны нэр буюу компанийн нэрийг дэлхийн улсуудад ашигласнаар ашиглах эрх үүсэх зохицуулалт болон бүртгүүлснээр ашиглах эрх үүсэх зохицуулалтууд нийтлэгдээ үйлчилдэг. Харин хамгаалалтын хувьд бол бүртгүүлсэн байх тохиолдолд хуулийн хамгаалалт нь илүү тодорхой болж, үүнээс үүдэх эрхүүд нь нээлттэй болдог. Жишээлбэл, тухайн арилжааны нэрийг дангаар ашиглах эрх олж авах, өрсөлдөгч этгээдийн зүгээс тухайн арилжааны нэрийг ашиглахыг хориглох, цуцлах, хохирол үүссэн бол түүнийг нэхэмжилж хохирлоо барагдуулах зэрэг эрхүүдийг хуулиар олгодог байна.

Ихэвчлэн арилжааны бүртгэлийг ямар субъект хийж байгаагаас хамаарч шүүхийн харьяалал нь өөр өөр байдаг. Тухайлбал хуулийн этгээдийн буюу компанийн бүртгэлийг хувийн эрх зүйн маргааны хүрээнд иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэх үү, эсвэл бүртгэл хийсэн төрийн байгууллагын чиг үүргийн хүрээнд үүссэн захиргааны акттай холбоотой захиргааны эрх зүйн маргаан хэмээн үзэж, захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэх үү гэсэн асуудал хөндөгддөг. Эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудын хувьд хуулийн этгээд буюу компанийн бүртгэлийг хариуцан гүйцэтгэх хоёр төрлийн хандлага түгээмэл байдаг. Үүнд: 1.Япон улсын загвар болох төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага буюу бүртгэлийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага бүртгэлийг хариуцах загвар. 2.ХБНГУ-ын загвар болох шүүхийн байгууллага бүртгэлийг хариуцах юм. (Б.Амарсанаа, 2022, 116-р тал)

Япон улсын загварын хувьд бүртгэлийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага хийдэг учраас баримт бичгийн бүрдэл бүрэн эсэх, хэлбэрийн шаардлага хангасан эсэх, гарын үсэг тамга тэмдгээр баталгаажсан эсэх зэргээр хэлбэрийн хяналтыг (formal examination) хийх буюу тухайн агуулгын хүчинтэй эсэхэд л хяналт хийдэг байна. Харин ХБНГУ-ын загварын хувьд бүртгэлийг шүүхийн байгууллага гүйцэтгэдэг учраас агуулгын хяналт (substantive examination) хийх буюу баримт бичгийн бүхий л агуулгад хяналт хийж, тухайн хэлцэл үнэн бодит эсэхийг нягталж, бүртгэлээс үүдэн гарах маргаанаас урьдчилан сэргийлэх боломжтой байдаг. (Б.Амарсанаа, 2022, 116-р тал)

Манай улсын хувьд хуулийн этгээдийн бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газар буюу гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага хариуцдаг тогтолцоотой учраас шууд утгаараа улсын бүртгэгч агуулгын хяналт хийх эрхгүй бөгөөд хэлбэрийн буюу процессын хяналт хийх эрхтэй байдаг. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага бүртгэлийг



хариуцаж байгаагаас тухайн байгууллагын бүртгэл хөглөх үндсэн чиг үүргийг хуульчилсан нийтийн эрх зүйн шинжтэй хуулийн зохицуулалттай байх бөгөөд хуулийн этгээдийн оноосон нэрийн бүртгэл, өөрчлөлт, хамгаалалтын асуудал нь нийтийн эрх зүйн хууль тогтоомжоор зохицуулагдаж, захиргааны хэргийн шүүхийн харьяалалд нэхэмжлэл гарган шийдвэрлэгдэж байна.

Улсын бүртгэлийн газраас бүртгэлийн хэлбэрийн хяналт хийж байгаа гэдгийг тодруулбал, УБЕХ-ийн 19-р зүйлд улсын бүртгэгчийн бүрэн эрхийг дараах байдлаар заасан байна:

19.4.1.улсын бүртгэлд бүртгүүлэх эрхийн үнэн зөвийг холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтнаас нотлох баримт, тайлбар, лавлагааг гаргуулан авч тогтоох;

19.4.2.энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн төрлийн хүрээнд иргэн, хуулийн этгээдээс улсын бүртгэл хийлгэх тухай хүсэлт, нотлох баримтыг хүлээн авч хянан улсын бүртгэлд бүртгэх эсэх тухай шийдвэр гаргах;

19.4.3.энэ хуулийн 19.4.2-т заасан нотлох баримт нь зөрчилтэй, бүрэн бус, холбогдох хуулийн заалтыг зөрчсөн бол улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах;

Дээрхээс үзэхэд, улсын бүртгэгч нь нотлох баримтад тулгуурлан, бүртгэлийг хийх эрхтэй бөгөөд, хуулийн этгээдийн бүртгэлийг тусгайлан зохицуулсан хууль болох Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн 22-р зүйлд мөн адил бүртгэл хийхэд шаардлагатай баримт бичгийн бүрдлийг нэг бүрчлэн заасан байгаа нь бүртгэлийг хийхэд заавал нотлох баримтад тулгуурлаж хийх бөгөөд, шаардлагатай нотлох баримтыг гаргуулж авах зэргээр шаардах эрхтэй байна. Өөрөөр хэлбэл тухайн баримт бичгийн бүрдэлд хэлбэрийн шаардлагыг заавал хангуулж байж хүчинтэй эсэхэд хяналт хийж байгаа бөгөөд, бодит байдал дээр улсын бүртгэгч нарын ажлын ачаалал зэргээс шалтгаалан агуулгын буюу тухайн баримт бичгийн бүхий л агуулгыг хянаж, үнэн зөв, бодит эсэхэд хяналт тавих боломжгүй юм.

Мөн түүнчлэн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлд улсын бүртгэгчийн зүгээс бүртгэхээс татгалзах тохиолдлуудыг заасан байх бөгөөд, тодруулбал баримт бичгийн бүрдэл дутуу буюу баримт бичгийг хуурамчаар үйлдсэн гэдэг нь цэвэр хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд хяналт тавих чиг үүрэг бөгөөд, харин тухайн баримт бичиг хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан эсэх гэдэг нь зарим талаар агуулгын шаардлагад хяналт тавих чиг үүргийг илтгэж байж болох ч эдгээр ихэвчлэн компанийн тухай хуулийн хүрээнд нягталж үзээд шаардлага хангасан бол хэлбэрийн шаардлага хангасанд тооцож бүртгэхээс татгалзах эрхгүй байна.

18.1.1.улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу;

18.1.2.үүсгэн байгуулах баримт бичиг энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй;

18.1.3.өргөдөл гаргагч хууль тогтоомжид заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн

Харин шүүхээс бүртгэлийг хариуцах тохиолдолд бүртгэл хийх болон маргаан шийдвэрлэх субъект нь ижил учраас бүртгэлтэй холбоотой маргаанаас урьдчилсан сэргийлэх давуу талтай байдаг. Манай улсын хувьд хуулийн этгээдийн оноосон нэрийг олгох, баталгаажуулах бүртгэлийг хийж буй байгууллагаас агуулгын хяналт хийх тогтолцоо бүрдээгүй буюу хэлбэрийн хяналтыг хийж бүртгэж буйгаас хуулийн этгээдийн оноосон нэрийг давхардуулж олгосноос үүдэн цөөнгүй шүүхийн маргаан гарч байсан болно. Харин 2020 онд хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулснаар хуулийн этгээдийн оноосон нэр олгохдоо зарим талаар агуулгын хяналт хийх чиг үүргийг хэрэгжүүлж байна. Жишээлбэл, оноосон нэрийн хувьд зуун хувь давхцаагүй ч бусдыг төөрөгдүүлэхээр ижил төсөөтэй байх тохиолдолд баталгаажуулахгүй байхаар зохицуулсан.

Харин хууль зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын хувьд хуулийн этгээдийн оноосон нэрийн талаар тусгайлан зохицуулсан зохицуулалт байхгүй болно. Тиймээс Захиргааны шүүхээс Компанийн тухай хуулиар хязгаарлахгүй Иргэний хуулийг хэрэглэн маргаан шийдвэрлэх нь нийтлэг байна. Ялангуяа хуулийн этгээдийн оноосон нэрийн маргааны шийдвэрлэхэд Захиргааны хэргийн шүүхээс иргэний хуулийг хэрэглэж хэрэг маргаан шийдвэрлэж байна. Учир нь болбоос нийтийн эрх зүйд хамаарах хууль тогтоомжид хувийн эрх зүйн шинжтэй хуулийн материаллаг хэм хэмжээг хэрэглэж болохоор шууд эшлэн заасан бол тухайн хэм хэмжээг захиргааны шүүх эш татан хэрэглэх боломжтой юм.

Тодруулбал, Иргэний хуулийн 27.3-д Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй гэж заасны дагуу Хуулийн этгээдийн нэр нь бусад хуулийн этгээдийн нэртэй үг үсгийн хувьд давхцахгүй байх төдийгүй бусдыг төөрөгдүүлэхээр ижил төсөөтэй байж болохгүй гэсэн заалтыг ашиглан хэрэг маргааны шийдвэрлэсэн хэд хэдэн шүүхийн шийдвэр байна.

Мөн өнөөгийн нөхцөлд хуулийн этгээдийн оноосон нэрийн хуулийн хамгаалалт нь Иргэний эрх зүй буюу иргэний хуульд тусгалаа олсон байгаа хэдий ч бүртгэлийн

байгууллага оноосон нэрийг бүртгэж, баталгаажуулж байгаа учраас харьяаллын дагуу захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэж байна. Тиймээс нэхэмжлэлийн шаардлага нь захиргааны актыг хүчингүй болгох буюу ижил төсөөтэй оноосон нэрийн бүртгэлийг цуцлах, дахин олгохгүй байх хэмжээнд л хязгаарлагдаж байна. Харин Иргэний хэргийн шүүхэд хэргийг хянан шийдвэрлэх тогтолцоотой байсан бол, талууд өөрсдөө нотлох баримтаа бүрдүүлж, ямар хор уршиг учирсан, ямар байдлаар бусдыг төөрөгдүүлсэн зэргийг нотолж чадах тохиолдолд оноосон нэр ашиглахыг хориглохоос гадна учирсан эдийн засгийн хохирлоо ч нөхөн төлүүлэх боломж бүрдэх юм.

## **2.2.2 Хуулийн этгээдийн нэрд халдсан үеийн зохицуулалтууд**

Тэгвэл өнөөгийн хуулийн орчинд хуулийн этгээдийн нэрийг дур мэдэн ашиглахыг хориглох, хуулийн хариуцлагыг хэрхэн хүлээлгэхээр зохицуулалт хийсийг дараагийн хэсэгт авч үзье. Юуны түрүүнд энд хуулийн этгээдийн төрөл дундаас ашгийн төлөө хуулийн этгээд буюу компани, нөхөрлөлийн нэрийн зохицуулалтыг судалж буй учраас, ашгийн төлөөх үйл ажиллагааны шударга өрсөлдөөнийг зохицуулсан өрсөлдөөний хуулийн 12.1.1-д өрсөлдөгчийн нэр хүндийг гутаах талаар, 12.1.4- бусад аж ахуй эрхлэгчийн нэрийг дур мэдэн ашиглах, хуулбарлах зэрэг нь өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагаа хэмээн үзэж хуулиар хориглосон байна.

12.1.Аж ахуй эрхлэгч өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

12.1.1.өрсөлдөгчийн болон түүний бараа бүтээгдэхүүний нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах;

12.1.4.бусдын барааны тэмдэг, шошго, аж ахуй эрхлэгчийн нэр, барааны чанарын баталгааг дур мэдэн хэрэглэх, барааны оноосон нэр, баглаа боодлыг хуулбарлах;

Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар хяналт тавих бөгөөд хууль тогтоомжийг зөрчсөн эсэхэд улсын байцаагч хяналт шалгалтыг явуулж, зөрчил илэрвээс тухайн зөрчил нь гэмт хэргийн шинжгүй буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй болбоос зөрчлийн хэргийн дагуу шийдвэрлэх буюу захиргааны шийтгэл ногдуулах, торгох арга хэмжээ авах зохицуулалт үйлчилж байна.

Харин зөрчлийн тухай хуулийн 10-р зүйл буюу зар сурталчилгааны тухай хууль зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага хэсгийн 2.3-д нийтэд танил, нэр хүнд бүхий хуулийн

этгээдийн нэр, бэлгэдэл, бүтээгдэхүүн, барааны тэмдэг, нэрийн товчлолыг зар сурталчилгаанд ашиглахад тухайн хуулийн этгээдийн зөвшөөрлийг урьдчилан аваагүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан байх бөгөөд энэ нь ч бас хуулийн этгээдийн оноосон нэрийг хамгаалах чухал зохицуулалтын нэг гэж үзэхээр байна.

Тэгвэл эрүүгийн хуулийн тусгай ангийн 18-р зүйл буюу эдийн засгийн гэмт хэрэг гэсэн хэсгийн 18.16 барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих гэмт хэргийн зохицуулалтуудыг тусгасан байна. Тодруулбаас бусдын барааны тэмдэг, эсхүл газар зүйн заалтыг ашиглан хэрэглэгчийг төөрөгдөлд оруулан хуурамч бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, худалдсан, улсын хилээр нэвтрүүлсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заажээ.

Нэгтгэн дүгнэвээс өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд арилжааны нэр буюу хуулийн этгээдийн оноосон нэрийн хамгаалалт нь ижил төсөөтэй ойлголт болох барааны тэмдэгтэй харьцуулахад харьцангуй сул хамгаалалттай байна. Жишээлбэл, хуулийн этгээдийн нэрийг бүртгүүлж ашигласан хэдий ч тухайн нэртэй ижил төсөөтэй нэр давхардуулж олгох асуудал гарсаар байна. Харин барааны тэмдгийн хувьд бол нэгэнт бүртгүүлсэн барааны тэмдгийг бусад этгээд ашиглах боломжгүйн дээр тухайн тэмдгийг давамгайл эрхээр ашиглах, бусдад ашиглуулах, худалдан борлуулах, шилжүүлэх, өвлүүлэх эрх нь нээлттэй байгаа юм. Нөгөө талаар хуулийн этгээдэд нэр төрд халдсан үйлдэлд хүлээлгэх хариуцлага нь харьцангуй хөнгөн буюу захиргааны шийтгэл ногдуулах, зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр хязгаарлагдаж байгаа бол барааны тэмдгийн хувьд эрүүгийн хуулиар эдийн засгийн гэмт хэрэг гэж үзэж торгох, зорчих эрх хязгаарлах, хорих ялыг сонгох байдлаар шийтгэл ногдуулахаар зохицуулсан байна.

Тиймээс дотоодын хуулийн зохицуулалтаар арилжааны нэрийг оюуны өмч, тэр дундаа аж үйлдвэрийн өмч гэдэг утгаар барааны тэмдгийн нэгэн адил эрхийг олгож, хамгаалалтыг хуулиар зохицуулах аваас, арилжаа эрхлэгчид арилжааны нэрийнхээ

эдийн засгийн ашигтай чанарыг гаргаж давамгайл эрхтэйгээр ашиглах, өвлүүлэх, бэлэглэх, шилжүүлэх, бусдад ашиглуулах боломжийг бүрдүүлэх боломжтой гэж үзэж байна.

### **2.3. Монгол улсад Арилжааны нэртэй холбоотой маргааныг шүүхээр шийдвэрлэсэн байдал:**

Нэхэмжлэгч “Аэрмаркет” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Эйрмаркет Говь” ХХК-ийн хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийн хүчингүй болгуулах, дахин энэ нэрээр өөр хуулийн этгээд бүртгэхгүй байхын Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын ХЭБГ-т даалгуулах нэхэмжлэлтэй захиргааны хэргийн маргаан:

Хэргийн үйл баримтыг авч үзвэл “Аэрмаркет” ХХК нь 2000 онд үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн, олон улсын болон орон нутгийн тийз борлуулалт, аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг компани бөгөөд, 2015 онд тус компанитай адил үйлчилгээ эрхэлдэг “Эйрмаркет Говь” ХХК гэх ижил нэртэй хуулийн этгээдийг бүртгэж, улсын бүртгэлийн байгууллага Иргэний хуулийн 27-р зүйлийн 27.3, Өрсөлдөөний тухай хуулийн 12.1.4 дэх хэсгүүдийн тус тус зөрчиж нэр олгосон гэсэн үндэслэлээр хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийг хүчингүй болгуулан, дахин энэ нэрээр өөр хуулийн этгээд бүртгэхгүй байхыг даалгуулах нэхэмжлэх гаргасан болно.

#### **2.3.1 Анхан шатны шүүхийн шийдвэр:**

Хүснэгт 2.1. Анхан шатны шүүхийн шийдвэр

No	Бүтэц	Агуулга
1	Танилцуулах хэсэг	Шүүх:Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх Шүүгч:Даваанямын Оюумаа Хэргийн индекс:128/2016/0355/3 Дугаар:471 Огноо:2016-06-24 Маргааны төрөл:Бусад,
2	Үйл явдлын агуулга	“Аэрмаркет” ХХК нь 2000 оноос хойш орон нутгийн болон олон улсын нислэгийн тийз борлуулалт, аялал жуулчлалын чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулж тухайн салбартаа харилцагчдад танигдсан компани бөгөөд тухайн “Аэрмаркет” гэх нэр нь компанийн үнэт зүйл юм. Гэтэл “Эйрмаркет Говь ХХК” гэх нэр бүхийн хуулийн этгээд Өмнөговь аймаг болон Улаанбаатар хотод ижил салбарт үйл ажиллагаа явуулж байсныг олж мэдсэн бөгөөд энэ харилцагчдын зүгээс тухай компанийг “Аэрмаркет” компанийн говь дахь салбар мэтээр

		<p>төөрөгдөхөд хүргэж, бусдыг төөрөгдүүлэн ашиг орлого олж байна.</p> <p>Тиймээс “Аэрмаркет” ХХК-аас Улсын бүртгэл статистикийн ерөнхий газрыг хариуцагчаар татан “Эйрмаркет говь ХХК” гэх хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хүчингүй болгож, дахин энэ нэрээр өөр хуулийн этгээд бүртгэхгүй байх нэхэмжлэл бүхий хэрэг,</p> <p>Нэхэмжлэгчийн зүгээс хариуцагчийн хууль зөрчсөн гэж буй үндэслэл зүйл заалт:</p> <p>Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3,</p> <p>Өрсөлдөөний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэг,</p> <p>Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журмын 3.1. “хуулийн этгээдийн нэр бусдыг төөрөгдүүлэхээр төсөөтэй байхыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчиж хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулсан байнаб Бусдыг төөрөгдүүлэх гэдэг нь нэрийн хувьд ижил биш ч дуудлагын хувьд төсөөтэй буюу мөн үйл ажиллагаа явуулдаг салбар адил байгаа нь бусдыг төөрөгдүүлэх нөхцөл гэж үзсэн.</p>
3	Шийдвэрлэсэн байдал	<p>1.2003 оны Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8, Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “А*****” ХХК-ийн “Э*****” ХХК-ийн хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлагыг хангасугай.</p> <p>Үндэслэлээ тайлбарлахдаа гадаад үгийг монгол хэлээр зөрүүтэй буулгасан буюу “Аэрмаркет” “Эйрмаркет” гэдэг нь угтаа нэг гадаад үгийг хоёр янзаар буулгасан байх учраас ижил үг гэж үзнэ гэжээ.</p> <p>2. 2015 оны Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-д заасныг тус тус баримтлан “А*****” ХХК-ийн “дахин энэ нэрээр өөр хуулийн этгээд бүртгэхгүй байхыг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт даалгуулах” нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай.</p> <p>Үндэслэлдээ, Аэрмаркет гэдэг нэр нь тухайн компанийн өмч биш бөгөөд учраас үйл ажиллагааны өөр салбарт, бусдыг төөрөгдүүлэхгүйгээр, хуулийн шаардлага хангасан тохиолдолд олгож болно гэжээ.</p>
4	Дүн шинжилгээ	<p>Дээрх шүүхийн шийдвэр нь хуулийн этгээдийн оноосон нэрийн ижил төсөөтэй байдлыг үндэслэлтэйгээр тайлбарлаж шийдсэн шийдвэр байх хэдий ч тус нэрийг ашиглаж буй компани нь тухайн нэрийг өмчлөх эрхгүй гэж үзэж үйл</p>

		ажиллагааны салбар давхцаагүй тохиолдолд бусад хуулийн этгээдийн зүгээс саадгүйгээр ашиглаж болно гэж шийдвэрлэсэн хэрэг юм.
5	Эх сурвалж	<a href="http://shuukh.mn">Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)</a>

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

### 2.3.2 Давж заалдах шатны шүүх:

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн (2003) 16-р зүйлийн 16.8, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн (2015) 14-р зүйлийн зүйлийн 14.2.1, Иргэний хуулийн 27-р зүйлийн 27.3-т заасныг баримтлан, нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Өөрөөр хэлбэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн (2003) 16-р зүйлийн 16.8-д “Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан эсэхийг холбогдох бүртгэх байгууллага цахим хэлбэрээр шалгаж баталгаажуулна” гэсний дагуу Хуулийн этгээдийн бүртгэлийн газар цахим сангаас “Эйрмаркет Говь” нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхцаж байгаа эсэхийг шалган баталгаажуулсан боловч ижил төсөөтэй нэр гарч ирээгүй гэсэн үндэслэл заажээ.

#### Хүснэгт 2.2. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр

No	Бүтэц	Агуулга
1	Танилцуулах хэсэг	Шүүх:Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх Шүүгч:Бямбаагийн Тунгалагсайхан Хэргийн индекс:128/2016/0355/3 Дугаар:221/МА2016/0585 Огноо:2016-09-07 Маргааны төрөл:Хуулийн этгээдийн улсын бүртгэл,
2	Үйл явдлын агуулга	Аэрмаркет ХХК-ийн зүгээс анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч, давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан хэрэг,  Гуравдагч этгээд болох Эйрмаркет Говь ХХК-ийн зүгээс тус компани нь хууль журмын дагуу, улсын бүртгэлийн газраас баталгаажуулж авсан нэр учраас ижил төсөөтэй гэж үзэхгүй буюу Говь гэсэн нэр орсон учраас өөр байх бөгөөд, анх шатны шүүхээс хэт нэг талыг барьж шийдвэр гаргасан гэж гомдол гаргасан.

		<p>Хяналтын шатны шүүхээс үзэхдээ: Анхан шатны шүүх нэхэмжлэгч компанийн нэхэмжлэлийн Эйрмаркет говь ХХК-ийн хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийг хүчингүй болгуулах шаардлагыг хангаж, дахин энэ нэрээр өөр хуулийн этгээд бүртгэхгүй байхыг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт даалгах шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Иргэний хуулийн холбогдох заалтыг буруу тайлбарлан хэрэглэж, хэргийг буруу шийдвэрлэсэн гэж үзсэн</p>
3	Шийдвэрлэсэн байдал	<p>1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 471 дүгээр шийдвэрийг хүчингүй болгож, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /2003 он/-ийн 16 дугаар зүйлийн 16.8, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /2015 он/-ийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч Аэрмаркет ХХК-ийн Эйрмаркет говь ХХК-ийн хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийг хүчингүй болгуулах, дахин энэ нэрээр өөр хуулийн этгээд бүртгэхгүй байхыг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт даалгуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, гуравдагч этгээд Эйрмаркет говь ХХК-ийн давж заалдах гомдлыг хангасугай.</p> <p>Хяналтын шатнаас үндэслэлээ тайлбарлахдаа:</p> <p>Тодруулбал, нэхэмжлэгч болон гуравдагч этгээдийн Аэрмаркет, Эйрмаркет говь гэсэн нэрс давхардаагүй, нэрийн бичвэрийн хувьд ялгаатай байна гэж үзсэн,</p> <p>Түүнчлэн улсын бүртгэлийн байгууллага Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /2003 он/-ийн 16 дугаар зүйлийн 16.8-д Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан эсэхийг холбогдох бүртгэх байгууллага цахим хэлбэрээр шалгаж баталгаажуулна гэж заасны дагуу Эйрмаркет говь ХХК-ийн нэрийг шалгахад давхардсан хуулийн этгээдийн нэр байгаагүй учир баталгаажуулсан нь хууль зөрчөөгүй байна гэж үзсэн,</p> <p>Мөн түүнчлэн Аэрмаркет ХХК-ийн нэхэмжлэлийн тайлбар болох ижил салбарт үйл ажиллагаа явуулж харилцагчдыг төөрөгдүүлж ашиг орлого олж байна гэдэг нь хэрэгт авагдсан үйл баримтаар нотлогдохгүй байна гэжээ.</p>
4	Дүн шинжилгээ	<p>Давж заалдах шатны шүүхээс үзэхдээ анхан шатны шүүхээс үзсэн нэр нь ижил төстэй гэдгийг хуулийн этгээдийн нэр нь үг үсгийн хувьд ижил төсөөтэй биш учраас буюу “Аэрмаркет ХХК” “Эйрмаркет Говь ХХК” гэх байдлаар өөр байгаа учраас нэхэмжлэлийн шаардлагыг хангах боломжгүй гэж үзсэн нь үг</p>



		үсэг болон дуудлагын хувьд ижил төсөөтэй байх гэдэг журмыг буруу хэрэглэсэн байна.
5	Эх сурвалж	<a href="http://shuukh.mn">Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)</a>

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

### 2.3.3 Хяналтын шатны шүүх:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн (2003) 2-р зүйлийн 2.1-д “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж нь Иргэнийн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасны дагуу хуулийн этгээд байгуулах, түүнийг улсын бүртгэлд бүртгэх, улсын бүртгэл хөтлөхтэй холбоо бүхий харилцаанд Иргэний хууль эрх зүйн эх сурвалж болох бөгөөд, Иргэний хуулийн 27-р зүйлийн 27.3-д зааснаар Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан байж болохгүйгээс гадна бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байхыг хориглох учраас, “Airmarket” гэх гадаад үгийг кирилл үсгээр хэрхэн (“Эйрмаркет”, “Аэрмаркет” гэж) илэрхийлснээс үл хамааран, тухайн нэрийг ижил (адил) гэж үзэх бөгөөд энэхүү нэрийн өмнө болон хойно өөр оноосон нэрийг нэмснээр ялгагдах боломжтой боловч “Говь” гэсэн бүс нутаг, байршил заасан үгийг оруулснаар нэг салбарт үйл ажиллагаа явуулах компаниудын хувьд бусдыг төөрөгдүүлэхээр ижил төсөөтэй хэмээн үзсэн.

#### Хүснэгт 2.3. Хяналтын шатны шүүхийн шийдвэр

No	Бүтэц	Агуулга
1	Танилцуулах хэсэг	Шүүх: Улсын дээд шүүх Шүүгч: Хөхийсүрэнгийн Батсүрэн Хэргийн индекс: 128/2016/0355/3 Дугаар: 403 Огноо: 2016-11-23 Маргааны төрөл: Хуулийн этгээдийн улсын бүртгэл,
2	Үйл явдлын агуулга	Аэрмаркет ХХК-ийн нэхэмжлэл бүхий “Эйрмаркет Говь ХХК” нэрийг улсын бүртгэлээс хасуулах, тус нэрээр дахин хуулийн этгээд бүртгэхгүй байх нэхэмжлэл бүхий хэргийг анхан шатны шүүх эхний шаардлагыг хангаж, хоёрдох шаардлагыг үл хэрэгсэж шийдвэрлэсэн,  Давж заалдах шатны шүүхээс, тус нэхэмжлэлийн хоёр шаардлагыг хоёулыг нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснийг Аэрмаркет ХХК-аас эс зөвшөөрч, хяналтын шатанд гомдол гаргасан болно.

3	Шийдвэрлэсэн байдал	<p>1. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 221/МА2016/0585 дугаар магадлалыг хүчингүй болгож, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 471 дүгээр шийдвэрийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтын "... “Аэрмаркет” ХХК-ийн “Эйрмаркет говь” ХХК-ийн хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлагыг хангасугай” гэснийг “Аэрмаркет” ХХК-ийн нэхэмжлэлийн зарим шаардлагыг хангаж, “Эйрмаркет говь” ХХК-ийн хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийг хүчингүй болгосугай” гэж өөрчлөн, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.</p> <p>Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн бөгөөд үндэслэлдээ,</p> <p>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн /2003 он/ 2 дугаар зүйлийн 2.1-д “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасны дагуу хуулийн этгээд байгуулах, түүнийг улсын бүртгэлд бүртгэх, улсын бүртгэл хөтлөхтэй холбоотой харилцаанд Иргэний хууль эрх зүйн эх сурвалж болох бөгөөд Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т зааснаар хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан байж болохгүйгээс гадна бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байхыг хориглосон /зөвшөөрөөгүй/ байна.</p> <p>Гадаад үг болох Airmarket гэдэг үгийг кирилл үсгээр хэрхэн галигласнаас үл хамааран нэг үг гэж тооцох бөгөөд, тус үгний өмнө эсвэл хойно өөр төрлийн оноосон нэрийг нэмснээр ялгагдах боловч Эйрмаркет Говь хэмээн газарзүйн байршил заасан үг оруулсан ялгагдах шинжтэй болохгүй байна гэж үзсэн.</p> <p>Мөн түүнчлэн Анхан шатны шүүхээс манай улсын нэгдэн орсон олон улсын конвенц болох Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцын 8 дугаар зүйлийг барьж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй хэмээн үзсэн.</p>
4	Дүн шинжилгээ	<p>Хяналтын шатны шүүхийн шийдвэр нь хуулийн этгээдийн нэр нь Иргэний хуулийн 27.3-д заасны дагуу өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан байж болохгүйгээс гадна ижил төсөөтэй байж болохгүй гэдгийг үндэслэлтэйгээр тайлбарлан шийдвэрлэсэн боловч, “Аэрмаркет” гэсэн нэр нь тус компанийн өмч биш гэдэг үндэслэлээр ижил салбарт үйл ажиллагаа явуулаагүй өөр хуулийн этгээд тус нэрийн ард эсвэл өмнө оноосон нэр оруулж ашиглаж болно гэж үзсэн нь өнөөгийн манай улсын хуулийн орчинд хуулийн этгээдийн</p>

		нэрийг эдийн засгийн ач холбогдол талаас нь өмч гэж үзэхгүй байгааг харуулж байна.
5	Эх сурвалж	<a href="http://shuukh.mn">Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)</a>

*Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар*

## **III БҮЛЭГ. БУСАД УЛСУУДАД АРИЛЖААНЫ НЭР ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ ХЭРХЭН ЗОХИЦУУЛСАН ТАЛААР**

### **3.1 БНСУ-ын арилжааны нэрийн зохицуулалт болон эрх зүйн хамгаалалт**

#### **3.1.1 БНСУ-ын эрх зүйн систем ба арилжааны хууль**

БНСУ нь эрх зүйн тогтолцооны хувьд Япон улсын нөлөөгөөр Иргэнлэг эрх зүйн бүлийн тогтолцоог уламжлан авсан бөгөөд, 1945 онд Японоос тусгаар улс болсноос хойш АНУ-ын эрх зүйн тогтолцооны нөлөөлөл ихээхэн туссан болно. Ялангуяа Арилжааны төрөлжсөн хуулийг батлах явцад АНУ-ын арилжааны хуулийн компанийн зохицуулалтыг өөрийн хуульд тэр чигээр нь тусган нутагшуулсан болно. Гэсэн хэдий ч суурь тогтолцооны хувьд Иргэнлэг эрх зүйн (Civil law system) тогтолцоотой учраас Нийтийн эрх зүй, Хувийн эрх зүй, Нийгмийн эрх зүй, Олон улсын эрх зүйн хэмээн дэд тогтолцоонд ангилдаг. Нийтийн эрх зүйд үндсэн хууль, захиргааны хууль, эрүүгийн хууль болон процессын хуулиудыг хамруулдаг бол Иргэний эрх зүйд Иргэний хууль болон Арилжааны хууль болон бусад холбогдох хуулиудыг хамааруулна. Харин Нийгмийн эрх зүйн гэдэг нь Капитализмын сөрөг талыг нөхөх буюу нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах зорилгоор тусгайлан авч үзэж буй хувийн болон нийтийн эрх зүйн холимог салбар эрх зүйн юм. Үүнд Хөдөлмөрийн хууль, Нийгмийн баталгааны хууль, Нийгмийн халамжийн хууль зэрэг хуулиудыг хамааруулна. Харин олон улсын эрх зүй гэдэгт Олон улсын гэрээ, конвенц, заншлыг хамааруулна.

Үүнээс Иргэний хууль нь хувийн эрх зүйн ерөнхий хууль бол Арилжааны хууль нь хувийн эрх зүйн тусгай хуульд хамаарна. БНСУ-ын хувьд төрөлжсөн Арилжааны хуулийг 1962 онд Их хурлаараа батлуулж 1963 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд, өнгөрсөн хугацаанд 30 удаа буюу хамгийн сүүлд 2020 онд нэмэлт өөрчлөлт оруулсан ч өдийг хүртэл хуулийг шинэчлэн найруулалгүй хадгалсаар ирсэн байна. Тус хууль нь Германы Арилжааны хуулийг эх загвараа болгосон бөгөөд харин Компанийн зохицуулалтууд нь АНУ-ын компанийн хуулийн загварыг тусгасан юм. БНСУ-ын Арилжааны хууль нь Ерөнхий бүлэг, Арилжааны үйл ажиллагаа, Компанийн эрх зүй, Даатгал, Далайн худалдаа, Агаарын тээвэр гэсэн зургаан том бүлгээс бүрдсэн 38 зүйл бүхий, 935 заалтаас бүрдсэн кодификац бүхий цогц арилжааны хууль юм.

БНСУ-ын хуулиудаас Арилжааны нэрийн хамгаалалтыг 1)Арилжааны хууль, 2)Барааны тэмдгийн хууль, 3)Шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэх болон бизнесийн нууцыг хамгаалах тухай хуульд тус тус зохицуулсан байна. Үүнээс тоймлон үзвээс Арилжааны хуульд Арилжаа эрхлэгч болон Арилжааны нэр гэдгийг тодорхойлоод,

ерөнхийлсөн байдлаар хамгаалалтыг зохицуулсан байна. Харин Барааны тэмдгийн хуульд бол барааны тэмдэг болон арилжааны нэрийн хоорондын зөрчлийг зохицуулсан байна. Эцэст нь Шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэх хуульд бол шударга бус өрсөлдөөний зорилгоор бусдын арилжааны нэрийг ашиглах үйлдлийг хориглох зохицуулалтыг зохицуулсан байна.

### **3.1.2 БНСУ-ын хууль тогтоомжид арилжааны нэрийг тодорхойлсон байдал**

БНСУ-ын хувьд арилжааны нэр болон барааны тэмдэг гэх ойлголтыг тус тусын хуульдаа тодорхойлсон байна. Тухайлбал арилжааны нэр гэдгийг арилжааны хуулиар, барааны тэмдэг гэх ойлголтыг барааны тэмдгийн хуульдаа тус тус тодорхойлжээ. Хуульд туссан тодорхойлолтоос өмнө солонгос хэл дээрх тайлбар тольд ямар байдлаар тодорхойлсныг авч үзье.

Солонгос хэл дээрх цахим нэвтэрхий толь болох википэдиад Барааны тэмдэг (상표 (商標)) гэдгийг хувь хүн, бизнесийн байгууллага, бусад хуулийн этгээдийн зүгээс ашиглах төрөл, илэрхийлэх утгыг илтгэх үг бөгөөд өөрийн бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг бусдынхаас ялгаж бүтээлч байдлаар хэрэглэгчдэд хүргэх арга юм. Барааны тэмдгийг бараа болон барааны баглаа боодолд наах, эсвэл үзүүлэх үйлчилгээнд ашиглах тоног төхөөрөмж, хэрэгсэлд наах бөгөөд үүнд үндэслэн хэрэгчид сонголтоо хийнэ. Нэг барааны тэмдгээр ижил чанарын бараа болон үйлчилгээг тасралтгүй хугацаанд үзүүлэх тохиолдолд, барааны тэмдэгт итгэх итгэл бий болж оюуны өмчийн хувьд үнэ цэн нь өсдөг гэж тодорхойлжээ. (상표 - 위키백과, 우리 모두의 백과사전, n.d.)

Харин Арилжааны нэр (상호 (商號)) гэдэг нь арилжаа эрхлэгч арилжааны үйл ажиллагаа эрхлэхдээ бусад арилжаа эрхлэгчээс ялгарч, өөрийгөө илтгэх зорилгоор ашиглах нэршил гэжээ. Арилжааны нэр нь нэршил учраас үсгээр илэрхийлэгдэж, уншигдах боломжтой байх ёстой учраас тэмдэг үсэг эсвэл дизайны дүрслэл нь арилжааны нэр болох боломжгүй юм. Арилжааны нэр нь арилжаа эрхлэгч өөрийгөө бусдаас ялгах зорилготой учраас, нэг ёсондоо итгэлтэй, найдвартай байдлыг илтгэх буюу эдийн засгийн чухал үнэ цэнийг үүсгэнэ. Тиймээс арилжааны нэрийг хамгаалах нь чухал юм гэжээ. (상호 - 위키백과, 우리 모두의 백과사전, n.d.)

Тэгвэл БНСУ-ын хуульд Барааны тэмдэг болон Арилжааны нэрийг хэрхэн тодорхойлсныг авч үзье. БНСУ-ын барааны тэмдгийн хуулийн 1-р зүйл, зорилго хэсэгт, энэ хууль нь барааны тэмдгийг хамгаалснаар, барааны тэмдэг ашиглагчийн ажил үүргийн хүрэн дэх итгэлтэй байдлыг хадгалж, аж үйлдвэрийн хөгжлийг дэмжиж,

барааны тэмдэг хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад оршино гэжээ. Мөн хуулийн 2-р зүйлийн 1-д, барааны тэмдэг гэдэг нь өөрийн барааг (газар зүйн заалтын барааны тэмдгээс бусад, үйлчилгээ болон үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах эд хэрэгслийг хамруулна) бусдын бараанаас ялгах зорилгоор ашиглах тэмдгийг (표장 (標章)) хэлнэ. Тэмдэг (표장 (標章)) гэдэг нь тэмдэг үсэг, үсэг, дүрс, дуу, үнэр, гурван хэмжээст дүрслэл, голограмм (hologram)-үйл хөдлөл болон өнгө зэргээс бүрдсэн, түүний бүрдлийн шинж болон илэрхийлэх аргаас хамааралгүйгээр барааны эх үүсвэрийг (출처 (出處)) таниулах зорилгоор ашиглах бүхий л илэрхийллийг хэлнэ гэжээ. (상표법 | 국가법령정보센터 | 법령 > 본문, n.d.)

Харин БНСУ-ын арилжааны хуулийн 1-р бүлгийн 2-р зүйлд арилжаа эрхлэгч гэдгийг тодорхойлсон байна. 2-р зүйлийн 4-р заалтад, арилжаа эрхлэгч буюу албан арилжаа эрхлэгч (상인-당연상인) гэж өөрийн нэрээр арилжааны үйл ажиллагаа явуулж буй этгээдийг хэлнэ. 5-р заалтад Арилжаа эрхлэгчтэй адилтган үзэх арилжаа эрхлэгч (동전-의제상인) гэж нэгдүгээрт, өөрөө шууд хэлбэрээр арилжаа эрхэлж буй эсэхээс үл хамааран, арилжааны газар буюу байгууламжид түшиглэн, арилжаа эрхлэгчийн арга барилаар бизнесийн үйл ажиллагаа явуулж буй этгээдийг арилжаа эрхлэгчид тооцох, хоёрдугаарт, компани нь арилжааны үйл ажиллагаа эрхлээгүй байсан ч өмнөх зүйлд хамаарна гэж заажээ. Тэгвэл тус зүйлийн 9-р заалтад, нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь арван саяас доош воны дүн бүхий бичил арилжаа эрхлэгчид тус хуулийн зохицуулалт хамаарахгүй гэж тодорхойлжээ. (상법 | 국가법령정보센터 | 법령 > 본문, n.d.)

БНСУ-ын Арилжааны хуульд арилжааны нэрийг тодорхойлсон шууд тодорхойлолт байхгүй хэдий ч “Арилжаа эрхлэгч бизнесийн үйл ажиллагаандаа ашиглаж буй нэршил” гэж тодорхойлж болох бөгөөд, арилжааны нэр гэдэг нь арилжаа эрхлэгч хэрэглэх нэр учраас арилжаа эрхлэгч бус хоршоо эрхлэгчийн хоршооны үйл ажиллагааны нэр нь арилжааны нэр биш төдийгүй, бичил арилжаа эрхлэгчийн нэр мөн хамаарахгүй тул тэдгээрийн ашиглаж буй нэр нь Арилжааны хуулийн хамгаалалтад багтахгүй гэж үздэг. Мөн түүнчлэн Арилжааны нэр гэдэг нь арилжааны үйл ажиллагаа буюу бизнесийн нэр болохоос Арилжаа эрхлэгчийг нэрлэж буюу нэр биш юм. Жишээлбэл Арилжааны хамтрагчийн зүгээс гэрээ байгуулахдаа тухайн бизнесийн үйл ажиллагааг сонгож гэрээ байгуулах нь түгээмэл болохоос Арилжааны үйл ажиллагааны эзэн нь хэн бэ гэдгийг харгалзаж гэрээ байгуулахгүй гэсэн үг юм. (장현승, 2008, 15-16р тал)

Дээрхээс үзэхэд Арилжааны нэр болон Барааны тэмдэг нь ялгаатай ойлголт гэдэг нь ойлгомжтой байна. Тэгвэл чухам ямар байдлаар ялгаатай болон төсөөтэй болохыг доор авч үзье. Арилжааны нэр болон Барааны тэмдэг нь бизнесийн үйл ажиллагааны нэр хүнд болон итгэл, найдвартай байдлыг илтгэх хэрэгсэл гэдэг утгаар нийтлэг талтай. Гэвч Арилжааны нэр нь арилжаа эрхлэгч өөрийн эрхэлж буй арилжааны үйл ажиллагааг өөрт хамааруулж буйг илтгэх “Эзэн биеийг илтгэх” хэрэгсэл бол, Барааны тэмдэг гэдэг нь бусад бараанаас ялгах зорилгоор ашиглаж буй “Барааг илтгэх” хэрэгсэл гэдэг утгаараа ялгаатай юм. (오재상, 2015, 24-р тал)

Арилжааны нэр нь Арилжаа эрхлэгчийг илтгэх нэр учраас дуудах боломжтой буюу үсгээр тэмдэглэгдсэн байх ёстой бол Барааны тэмдэг нь хэлбэр дүрс, үсэг, гурван хэмжээст дүрс болон тэдгээрийн иж бүрдэл байж болох төдийгүй бусдын бараа болон үйлчилгээнээс ялгах зорилгоор ашиглаж буй тэмдэг юм. Арилжааны нэр нь тухайн компанийн эзэмшлийг илтгэж байгаа бол барааны тэмдэг нь тухайн бараа нь ямарваа компанийн гарал үүсэлтэй гэдгийг илтгэнэ. Өөрөөр хэлбэл барааны тэмдэг нь компани болон компанийн бүтэгдэхүүний холбоо хамаарлыг илтгэж буй учраас компанийн эзэмшигч нь хэн гэдэг зарчмын хувьд чухал биш юм. Эсрэгээрээ Арилжааны нэр нь арилжаа эрхлэгчийн бизнесийн бүхий л үйл ажиллагаанд хамаарах хууль ёсны эзэн болох арилжаа эрхлэгчийг илтгэж буй учраас олон нийтийн зүгээс ямарваа компани болон компанийн эзэн биеийг ялгах зорилго агуулж байдаг. (오재상, 2015, 25-р тал)

Мөн түүнчлэн дээрх хоёр ойлголт нь бүртгэх субъект болон хуулийн хамгаалалтын хүрээний хувьд бас ялгаатай байна. Жишээлбэл Арилжааны нэрийг харьяаллын дагуух шүүхийн харьяа бүртгэлийн газар бүртгэдэг бол барааны тэмдгийг Патентын газарт бүртгүүлдэг байна. Арилжааны нэрийг бүртгүүлэхэд компанийн зүгээс компанийг үүсгэн байгуулах бүртгэл хийлгэхийн хамтаар арилжааны нэрийг бүртгүүлэх боломжтой байдаг бол арилжаа эрхлэгч хувь хүний хувьд заавал бүртгүүлэхгүй байсан ч тухайн арилжааны нэрийг ашиглах эрх нь үсч байгаа юм. Харин барааны тэмдгийн хувьд Патентын газарт барааны тэмдгийг бүртгүүлэх мэдүүлэг гаргаж, тус мэдүүлгийн дагуу барааны тэмдгийн шүүлт хийж үзээд татгалзах шалтгаан байхгүй тохиолдолд нийтэд зарлах бөгөөд олон нийтийн зүгээс эсэргүүцэл ирүүлээгүй тохиолдолд барааны тэмдгийг бүртгэгдсэнээр онцгой эрхтэйгээр ашиглах эрх үүснэ. (오재상, 2015, 25-р тал)

Харин хамгаалалтын цар хүрээний хувьд Арилжааны нэр нь бүртгэл хийлгэсэн засаг захиргааны нэгжийн хүрээнд (хот, аймаг, сум) ижил төрлийн үйл ажиллагаанд л хамгаалалт үйлчлэх бол Барааны тэмдгийн хувьд нэгт, доод тал нь арван жилийн

хугацаанд (хугацааг сунгуулсан тохиолдолд хязгааргүй), хоёрт, зөвхөн дотоодод үйлчлэх хэдий ч улсын хэмжээн үйлчлэх, гуравт, бүртгэгдсэн барааны тэмдэг нь заагдсан барааны нэр төрөл дээр онцгой эрхтэйгээр ашиглах эрх үүснэ. Өөрөөр хэлбэл бүртгүүлсэн барааны тэмдгийн хувьд монопол буюу онцгой эрхийг баталгаажуулдаг бол Арилжааны нэрийг бүртгүүлсэн хэдий ч эрхийн цар хүрээ нь хязгаарлагдмал буюу тухайн засаг захиргааны нэгжийн хүрээнд зөвхөн ашиглах эрхийг баталгаажуулж буй юм. (장현승, 2008, 19-р тал)

БНСУ-ын Арилжааны хуулийн 1-р бүлгийн 4-р зүйлд арилжааны нэрийг зохицуулах ерөнхий зарчмыг тусгасан байна. Тодруулбал, Арилжаа эрхлэгч нь өөрийн овог нэр болон бусад нэршлээр арилжааны нэрийг тогтож болно. Харин компани нь Арилжааны нэрдээ компанийн төрлөөс хамаарч бүх гишүүд нь хариуцлагатай компани (partnership, 합명회사), зарим гишүүд нь хариуцлагатай компани (limited partnership, 합자회사), хязгаарлагдмал хариуцлагатай компани (limited liability company, 유한책임회사), хувьцаат компани (corporation, 주식회사) болон хязгаарлагдмал компани (limited company, 유한회사) зэргийн товчлол үсгийг заавал ашиглана гэж заажээ. (상법 | 국가법령정보센터 | 법령 > 본문, n.d.)

Мөн түүнчлэн хэлбэрийн хувьд компани биш бол компани гэсэн товчлол үсгийг ашиглахыг хориглох бөгөөд, компанийн эрхэлж байсан арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авсан тохиолдолд ч мөн адил ашиглаж болохгүй гэж заасан байна. Харин тус бүлгийн 21-р заалтад арилжааны нэр нэгдмэл байх талаар заасан буюу ижил төрлийн арилжааны үйл ажиллагаанд ижил нэр хэрэглэх, компанийн салбар нэгж нь толгой компанийнхаа холбоо хамаарлыг илтгэсэн байдлаар нэрийг ашиглана гэж тус тус заажээ. (상법 | 국가법령정보센터 | 법령 > 본문, n.d.)

Хамгийн энгийнээр тайлбарлавал хүн нийгэмд амьдрах явцад өөрийгөө нэрлэх, дуудуулах зорилгоор нэр ашигладаг бол компани, аж ахуйн нэгж, арилжаа эрхлэгч арилжааны үйл ажиллагаа эрхлэхдээ арилжааны нэр ашигладаг гэдэг утгаараа ялгагдана. Тэгвэл арилжааны нэр нь бизнесийн үйл ажиллагааг илэрхийлж буй нэр гэдэг утгаараа барааны гарал үүслийг илэрхийлж буй барааны тэмдгээс ялгагдаж байгаа нь тодорхой байна. Харин арилжааны нэрийг сонгоход арилжаа эрхлэгч өөрийн эрх ашиг, таатай байдлаас гадна арилжааны нөгөө тал болсон олон нийтийн эрх ашгийг харгалзаж үзэх шаардлага үүсэх бөгөөд аль талын эрх ашгийг давууд үзэж байгаагаас шалтгаалаад хуульд арилжааны нэр сонгох зарчмыг гурван янзаар тусгадаг.



Тодруулбал, эхнийх нь, арилжааны нэр үнэн зөв байх зарчим буюу арилжаа эрхлэгч болон арилжааны үйл ажиллагааны төрлийг үнэн зөвөөр илтгэсэн нэрийг ашиглахыг шаарддаг хуулийн зарчим юм. Энэ нь арилжааны үйл ажиллагааг шилжүүлэх, өвлүүлэх үед хүлээн авч буй тал нэрийг үргэлжлүүлэн ашиглах боломжгүй байдгаас эдийн засгийн үнэ цэнийг хадгалах боломжгүй байдаг. Франц, Бельги, Испани улсаас гадна өмнөд америкийн олон улсууд тус зарчмыг баримталдаг. Хоёрдох нь, арилжааны нэрийг сонгоход үйл ажиллагаатай холбоотой байхыг шаардахгүйгээр чөлөөтэй сонгох зарчим буюу арилжааны нэрийн чөлөөт зарчим юм. Энэ нь арилжааны нэр эрхэлж буй бизнесийн үйл ажиллагаатай тохироогүйгээс арилжааны нөгөө талд бизнесийн үйл ажиллагааны эзэмшил болоод агуулгын талаар төөрөгдөх нөхцөл байдал үүсгэдэг. Гэсэн хэдий ч Америк, Англи зэрэг нийтлэг эрх зүйн бүлийн улсуудад тус зарчмыг баримталж байна. Гуравдах нь, холимог зарчим буюу арилжааны нэр нь эзэмшигч болон агуулга (үйл ажиллагааны төрөл зэрэг)тай нийцэхийг шаардах хэдий ч үйл ажиллагааг шилжүүлэх, өөрчлөх үед тухайн нэрийг үргэлжлүүлэн ашиглахыг зөвшөөрдөг зарчим юм. Германы хуульд тус зарчмыг тусгасан байдаг. (오재상, 2015, 33-р тал)

БНСУ-ын хувьд арилжааны нэр сонгоход холимог зарчим баримталж байна. Өөрөөр хэлбэл арилжаа эрхлэгч нь өөрийн нэр, ургийн овог зэрэг ямар ч төрлийн нэршлийг өөрийн хүслээр, чөлөөтэй сонгож ашиглах боломжтой гэсэн чөлөөт зарчмыг суурь болгож буй хэдий ч тодорхой тохиолдлуудад арилжааны нэр үнэ зөв байхыг шаардаж, хязгаарлаж байгаа нь холимог зарчмын илрэл юм. Тодруулбал, арилжаа эрхлэгчийн зүгээс нэрээ чөлөөтэй сонгож, үйл ажиллагааны төрлөө заавал илтгэх шаардлагагүй хэдий ч хувь хүн болон компанийг ялгах тэмдгийг заавал ашиглах, тусгай зохицуулалттайгаар үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд буюу банк, даатгал зэргийн байгууллагууд тухайн үйл ажиллагааны төрлийг заавал тусгах гэсэн хязгаарлалтыг тавьдаг байна. (오재상, 2015, 33-р тал)

### Хүснэгт 3.1. Арилжааны нэр ба барааны тэмдгийн тодорхойлолтын ялгаа

Ангилал	Арилжааны нэр	Барааны тэмдэг
Тодорхойлолт	Арилжаа эрхлэгч бизнесийн үйл ажиллагаа эрхлэхдээ ашиглаж буй нэр	Бусад төрлийн бараанаас ялгах зорилгоор ашиглаж буй тэмдэг
Чиг үүрэг	Бизнесийн үйл ажиллагаанд хууль ёсны харьяаллыг илтгэх, гарал үүслийг ялгах үүргийг давхар гүйцэтгэх	Гарал үүсэл болон чанарыг илтгэх, зар сурталчилгааны үүрэг

Бүрдэл	Зөвхөн үсгээр тэмдэглэх	Тэмдэг, үсэг, дүрс, өнгө, биет дүрс гэх мэт
--------	-------------------------	---

Эх сурвалж: 전현율, 2005, 19-р тал

### 3.1.3 БНСУ-ын хууль дахь арилжааны нэрийг хамгаалах зохицуулалтууд

Хуульд туссан арилжааны нэрийн эрх зүйн байдлыг гуравдагч этгээдийн талаар эдлэх онцгой эрх болох хувь хүний эрх (personal rights, Persönlichkeitsrecht) болон эд хөрөнгийн эрхэд (property rights, right of ownership) хувааж үздэг. Өөрөөр хэлбэл арилжааны нэр нь арилжаа эрхлэгчийн нэр учраас эдийн засгийн харилцаанд оролцоход өөрийг тодорхойлж буй нэрийн хуудас буюу хувь хүний нэрийн эрхтэй (Naming rights, Namensrecht) ижилтгэх хувийн эрхийн шинж чанартай үүргийг голчлон гүйцэтгэдэг. Үүний зэрэгцээгээр бусдад шилжүүлэх болон өвлүүлэх боломжийг бүрдүүлдэг эд хөрөнгийн эрхийн шинж чанарыг давхар агуулж байдаг буюу гаднах байдлын хувьд хувийн эрхийн шинжтэй хэдий ч агуулгын хувьд эд хөрөнгийн эрхийн шинж чанар нь давамгайл байдаг гэж үзэх нь нийтлэг байдаг. (장현승, 2008b)

Тэгвэл дээрх хувийн шинжтэй эрх болон эд хөрөнгийн шинжтэй эрхийг БНСУ-ын хуулиудад хэрхэн хамгаалахаар зохицуулсныг авч үзье. Дэлхийн улсуудад арилжааны нэрийг ашиглах эрхийг арилжааны нэрийг сонгон авч ашигласнаар үүсэх зарчим, арилжааны нэрийг бүртгүүлснээр үүсэх зарчмыг тус тус хуульдаа тусгадаг. Ашигласнаар үүсэх зарчим гэдэг нь тухайн нэрийг заавал бүртгүүлэх шаардлагагүйгээр авч ашигласнаар ашиглах эрх үсч, хуулиар хамгаалагдах зохицуулалт бол бүртгүүлснээр үүсэх зарчим гэдэг нь тухайн нэрийг заавал бүртгүүлсэн тохиолдолд ашиглах эрх хүлээн зөвшөөрөгдөж хуулийн хамгаалалтад орохыг хэлнэ. БНСУ-ын хуулийн зохицуулалтын хувьд арилжааны нэрийг авч ашигласнаар ашиглах эрх үүсэх буюу ашигласнаар үүсэх зарчмыг баримталж байна. (전현율, 2005)

#### Хүснэгт 3.2. Арилжааны нэр ба барааны тэмдгийн эрхийн ялгаа

Ангилал	Арилжааны нэр	Барааны тэмдэг
Ашиглах эрх үүсэх нөхцөл	Сонгож ашигласнаар эрх үүсэх	Бүртгүүлснээр эрх үүсэх
Ашиглах эрхийн онцгой эрх	Хувь хүний эрхийг хамгаалахын хажуугаар, эд хөрөнгийн эрхийг хамгаалах	Тэмдэгт агуулагдах итгэл болон хэрэглэгчийг татах чадварыг хамгаалах
Ашиглах эрхийг хамгаалах хугацаа	Тусгайлсан хугацаа байхгүй буюу нэрийг ашиглах бүхий л хугацаанд хүчинтэй	Барааны тэмдгийг бүртгүүлснээс хойш 10 жил, 10 жилээр

		үргэлжлүүлэн боломжтой	сунгах
Ашиглах эрхийг хамгаалах бүс нутаг	Бусдыг төөрөгдүүлэх, зүй бус зорилгоор ашиглаагүй тохиолдолд хаана ч ашиглах боломжтой учраас хил хязгаарыг тогтоох боломжгүй	Улсын аль ч бүс нутагт	

Эх сурвалж: 전현율, 2005, 20-р тал

Арилжааны нэрийн эрхийг (상호권) БНСУ-ын хуулийн зохицуулалтыг арилжааны нэрийг ашиглах эрх (상호사용권) болон арилжааны нэрийг эзэмших эрх (상호전용권) гэсэн хоёр ухагдахуунаар тайлбарлаж байна. Арилжааны нэрийг ашиглах эрх нь илүү өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх ойлголт буюу авч ашигласнаар үүсэх эрх бол арилжааны нэрийг эзэмших эрх нь тодорхой тохиолдолд буюу бүртгүүлснээр хүлээн зөвшөөрөгдөх явцуу хүрээнд үйлчлэх эрхийг хэлнэ. Арилжааны нэр ашиглах эрхийг идэвхтэй эрх (적극적인 상호권) гэж үзэх бол арилжааны нэр эзэмших эрхийг идэвхгүй эрх (소극적인 상호권) гэж үздэг. (장현승, 2008с)

Арилжааны нэр ашиглах эрх (идэвхтэй эрх) гэдэг нь арилжаа эрхлэгчийн зүгээс сонгож авсан арилжааны нэрийг саадгүйгээр ашиглах эрхийг хэлэх буюу бүртгэл хийлгэсэн эсэхээс үл хамааран ашиглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Тиймээс арилжааны нэрээ бүртгүүлэлгүйгээр ашиглаж байгаа этгээдийн нэрийг хожим өөр арилжаа эрхлэгч авч ашиглан түрүүлж бүртгүүлсэн тохиолдолд өмнө ашиглаж байсан этгээдийн эрхийг хүлээн зөвшөөрч үргэлжлүүлэн ашиглахыг зөвшөөрнө. Харин арилжааны нэр эзэмших эрх (идэвхгүй эрх) гэдэг нь арилжаа эрхлэгчийн зүгээс бусад арилжаа эрхлэгчид бусдыг төөрөгдүүлэхүйц ижил төстэй нэрийг зүй бус зорилгоор авч ашигласан тохиолдолд нэр ашиглахыг хориглох, учирсан хохирлыг нэхэмжлэх эрхийг хэлнэ. (김재두, 2020a) Арилжааны нэр эзэмших эрх үүсэх талаар авч ашигласнаар үүсдэг болон заавал бүртгүүлснээр үүсдэг гэсэн маргаан байдаг ч судлаачийн зүгээс бүртгүүлснээр үүсдэг гэсэн байр суурийг баримталж байна.

### Хүснэгт 3.3. Арилжааны нэр ба барааны тэмдгийн хамгаалалтын ялгаатай байдал

Ангилал	Арилжааны нэр	Барааны тэмдэг
Арилжааны нэр ашиглах эрх үүсэх	Ашигласнаар эрх үүсэх	Бүртгүүлснээр эрх үүсэх
Арилжааны нэр эзэмших эрх үүсэх	Арилжааны нэрийг чөлөөтэй сонгож ашиглаж, бүртгүүлснээр үүсэх	Бүртгүүлсэн барааны тэмдгийг тухайн бараанд давамгайл эрхтэйгээр ашиглах эрхтэй

Арилжааны нэр ашиглахыг хориглох эрх үүсэх	<p>1.Нэрд халдсан этгээд зүй бус зорилго агуулах, бусдыг төөрөгдүүлэх аюул үүссэн байх</p> <p>2.Нэг хот, нэг сумд бусдын бүртгүүлсэн нэрийг ашигласан этгээдийг зүй бус зорилготой гэж тооцох</p> <p>3.Нэрээ бүртгүүлсэн арилжаа эрхлэгч нэрд гаднаас халдсан үйлдлийг нотлох шаардлагагүй</p> <p>4.Бусдын бүртгүүлсэн нэрийг ижил бүс нутагт ижил салбарт ашиглах, бүртгүүлэх боломжгүй</p> <p>5.Ашиглахыг хориглох, торгууль ногдуулах (Арилжааны хууль), учирсан хохирлоо нэхэмжлэх (иргэний хууль)</p>	<p>1.Барааны тэмдэгтэй ижил болон төсөөтэй тэмдэг ашиглахыг хориглох</p> <p>2.Шууд бус халдлага буюу ирээдүйд учирч болох халдлагыг халдлагад тооцох</p> <p>3.Тэмдэгт халдагсдын санаатай, болгоомжгүй зэргийн бүх үйлдлийг халдлагад тооцох</p> <p>3.Иргэний хариуцлага хүлээлгэх (халдлагыг хориглох, сэргийлэх, хохирол төлүүлэх, алдсан итгэл сэргээх, зориуд санаатай эсэхийг тодорхойлох, учирсан хохирлыг тооцох)</p> <p>4.Эрүүгийн хариуцлага хүлээлгэх</p>
--	--	---

Эх сурвалж: 전현율, 2005, 20-р тал

БНСУ-ын хувьд арилжааны нэрийн бүртгэлийн тогтолцоог бүрдүүлсэн байх бөгөөд, бүртгэлийн тогтолцоо нь албан ёсоор зарлах чиг үүргээс гадна, арилжааны нэрийг хамгаалах, арилжааны нэрийг шилжүүлэхтэй холбоотойгоор чухал үүргийг гүйцэтгэдэг байна. Тухайлбал БНСУ-ын Арилжааны хуулийн 4-р зүйлийн 22-оос 24 хүртэл заалтад арилжааны нэрийг бүртгүүлэх талаар зохицуулалтыг тусгасан байхаас гадна, арилжааны бүртгэлийн хуулийн 2-р зүйлийн 29-өөс 45 хүртэлх заалтуудад илүү нарийвчилсан зохицуулалтуудыг тусгасан байна. (상업등기법, n.d.)

Арилжааны нэрийн бүртгэлийн хувьд Солонгосын хууль хоёр төрлийн зохицуулалт байх бөгөөд үүний нэгдэх нь арилжааны нэрийн бүртгэлийн тогтолцоо (상호등기제도) бол хоёрдох арилжааны нэрийн урьдчилсан бүртгэлийн тогтолцоо (상호가등기제도) байна. Арилжааны нэрийн бүртгэл гэдэг арилжаа эрхлэгч хувь хүн болон компанид хамаарах зохицуулалт бол арилжааны нэрийн урьдчилсан бүртгэл гэдэг нь зөвхөн компанид хамаарах зохицуулалт байна. Арилжааны нэрийн бүртгэлийн компаниудын хувьд компани байгуулахдаа арилжааны нэрээ заавал хамтад нь бүртгүүлэхээр зохицуулсан байдаг бол арилжаа эрхлэгч хувь хүний хувьд арилжааны нэрийг бүртгүүлэх эсэх нь сонголтоор хийгдэх боловч бүртгүүлэх бол тухайн засаг

захиргааны нэгжийн харьяалах шүүхийн харьяа арилжааны бүртгэлийн газарт бүртгүүлдэг байна. (상업등기법, n.d.)

БНСУ-ын арилжааны бүртгэлд арилжааны нэрийг бүртгэхээс гадна, арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагааны байршил, үйл ажиллагааны төрөл, арилжааны нэр ашиглагчийн овог нэр болон хувийн бүртгэлийн дугаарыг заавал бүртгүүлэхээр заажээ. Мөн түүнчлэн арилжааны нэрийг шинээр бүртгүүлэхээс гадна, шилжүүлэх, өвлүүлэх, өөрчлөх, дуусгавар болгох үед заавал бүртгүүлэхээр заасан байна. Арилжааны бүртгэлийг хийлгэснээр тухайн засаг захиргааны нэгж буюу хот (특별시, 광역시, 특별자치시, 시) болон мужийн (аймаг) нэгж болох сумд (군) тухайн нэрийг ижил төрлийн арилжааны үйл ажиллагаанд ашиглахаар бүртгүүлэхийг зөвшөөрөхгүй бөгөөд, бусад этгээдийн зүгээс ижил төрлийн үйл ажиллагаанд ижил нэрийг бүртгүүлэх аваас зүй бусаар ашиглахыг завдсан гэж үзэж бүртгэхгүй байхаар зохицуулсан байна. (김재두, 2020, 227-р тал)

Харин зөвхөн компанид үйлчлэх зохицуулалт болох урьдчилсан бүртгэл (가등기 제도) гэдэг нь компанийн үйл ажиллагаанд шийдвэр гаргахад эрх ашиг нь хөндөгдөх олон хүний оролцоо шаардагддаг, тэр хэмжээгээр их цаг хугацаа шаардагддаг асуудал учраас арилжааны нэрийн бүртгэлийг урьдчилан бүртгүүлэх тогтолцоог хэлнэ. Тодруулбал, арилжааны бүртгэлийн тухай хуулийн 38-р заалтад, компанийн үүсгэн байгуулагч эсвэл эрх бүхий ажилтан нь харьяалах арилжааны бүртгэлийн газарт урьдчилан бүртгэл хийлгэх хүсэлт гаргах бөгөөд, урьдчилсан бүртгэлд арилжааны нэр, арилжааны үйл ажиллагааны хаяг, зорилго, үүсгэн байгуулагчдын овог нэр болон бүртгэлийн дугаар, хаяг, үндсэн бүртгэл хийгдэх хүртэлх хугацаа зэргийг мэдүүлэн урьдчилсан бүртгэлийг хийлгэхээр заасан байна. (상업등기법, n.d.)

Дээрх арилжааны нэрийн урьдчилсан бүртгэлийг, арилжааны үйл ажиллагааны үндсэн хаяг өөрчлөгдөх, арилжааны нэрийг өөрчлөх үед хийгдэх бөгөөд, энэхүү тогтолцооны гол зорилго нь компанийн дотоод мэдээллийг олж авсан гуравдагч этгээдийн зүгээс компани байгуулах, компанийн зорилго өөрчлөгдөх, үндсэн үйл ажиллагааны хаягаа өөрчлөх зэргийг урьдчилан мэдэж аваад тухайн арилжааны нэрийг тухайн засаг захиргааны нэгжид бүртгүүлэх замаар компанийн үйл ажиллагаанд саад учруулах үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий хуулийн зохицуулалт юм. Урьдчилсан бүртгэл хийхийг зөвшөөрөх гурван тохиолдолд зөвшөөрөх бөгөөд эхнийх нь, эд хөрөнгөд суурилсан компани болох хувьцаат компани болон хязгаарлагдмал

компанийг байгуулахад их цаг хугацаа шаардагддаг гэсэн шалтгаанаар, хоёрдугаарт, бүх төрлийн компани нэр болон зорилго өөрчлөхөд компанийн дүрэмд өөрчлөлт орох учраас мөн их цаг хугацаа зарцуулагддаг гэдэг утгаар, гуравдугаарт, компанийн үйл ажиллагааг өөр засаг захиргааны нэгжид шилжүүлэх үед мөн адил дүрэмд өөрчлөлт оруулах шаардлага үүсдэг учраас тус тус зөвшөөрдөг байна. (김재두, 2020, 228-р тал)

Арилжааны нэрийг бүртгүүлснээр арилжааны нэрийг ашиглах эрх үүсэхээс гадна арилжааны нэрийн эзэмшил үүсдэг гэж үзэх бөгөөд, бүртгэл хийлгэсэн тохиолдолд дараах байдлаар арилжааны нэрийн хамгаалалтыг бататгадаг гэж үздэг. Нэгдүгээрт, бусад этгээдийн зүгээс тухайн арилжааны нэрийг ашиглахыг хориглоход шууд хамгаалалт болдог буюу бүртгүүлээгүй тохиолдолд нэрд халдсан эсэх болон зүй бус үйлдэл хийсэн гэдгийг нотлох шаардлага үүсдэг бол бүртгэл хийлгэсэн тохиолдолд тухайн үйлдлийг нотлох шаардлагагүй байдаг. Хоёрдугаарт, ижил нэрийг ижил төрлийн нэрээр дахин бүртгүүлэх үйлдлийг урьдчилан таслан зогсоох ач холбогдолтой. Бүртгэл хийгээгүй арилжааны нэрийн хувьд бусад этгээд тухайн нэрийг бүртгүүлсэн тохиолдолд урьдчилан мэдэж, сэргийлэх боломжгүй байдаг бол бүртгэл хийлгэснээр урьдчилан зогсоох боломжтой гэсэн үг юм. (김재두, 2020, 231-р тал)

Тэгвэл арилжааны нэрийг шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг БНСУ-ын арилжааны хуулийн 25-аас 27-р заалтуудад зохицуулсан байх бөгөөд, тус зохицуулалтуудыг дараах байдлаар сийрүүлж болохоор байна. Өмнө хэлсэнчлэн арилжааны нэр нь хувь хүний эрхээс гадна эд хөрөнгийн эрхийг агуулж байдаг учраас бусдад ашиглуулах шилжүүлэх боломжтой байдаг. Тус хуулийн 25-р заалтад арилжааны нэрийг арилжааны үйл ажиллагааны хамтаар эсвэл арилжааны үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд шилжүүлж болохоор заасан байна. Учир нь гэвэл арилжааны нэрийг үйл ажиллагаанаас тусад шилжүүлэх аваас арилжааны нөгөө тал болсон олон нийт тухайн нэр төөрөгдөх явдал үүсэх учраас заавал арилжааны үйл ажиллагааны хамтаар шилжүүлэхээр зохицуулсан байна.

Харин арилжааны үйл ажиллагааг зогсоосноос хойш нэр шилжүүлэгч болон нэр хүлээн авагчийн арилжааны үйл ажиллагаанд төөрөгдөх асуудал үүсэхгүй гэж үзэж буй учраас тус нэрийг дангаар нь шилжүүлэхийг зөвшөөрдөг байна. Дээрх байдлаар арилжааны нэрийг шилжүүлэхэд арилжааны нэрийн бүртгэлийг заавал хийхийг шаардах бөгөөд, бүртгэлийг хийгээгүй тохиолдолд гуравдагч этгээдийн талаарх шаардах эрх үүсэхгүй гэж үздэг байна. Тодруулбал, гуравдагч этгээд тухайн нэрийг ашиглаж, бүртгүүлсэн тохиолдолд тухайн этгээдийн талаар арилжааны нэр ашиглахыг хориглох

эрх үүсэхгүй гэсэн үг юм. Арилжааны нэрийг өвлүүлэх харилцааны талаар тусгайлсан зохицуулалт байхгүй хэдий ч арилжааны нэрд эд хөрөнгийн эрх агуулагддаг гэдэг утгаар чөлөөтэй өвлүүлэх боломжтой гэж үзэх хандлага нийтлэг байдаг юм. (김재두, 2020, 238-р тал)

Харин арилжааны нэрийг ашиглах эрх дуусгавар болох асуудал нь арилжаа эрхлэгчийн зүгээс чөлөөтэйгөөр нэр сонгосны адилаар чөлөөтэй өөрчлөх болон дуусгавар болгох боломжтой байдаг. Гэхдээ арилжааны нэр өөрчилсөн болон ашиглахаа зогсоосон талаар 2 долоо хоногийн дотор бүртгэлээ хийлгээгүй тохиолдолд гуравдагч этгээдийн зүгээс тухай нэрийн ашиглах эрхийг цуцлуулах хүсэлт гаргах боломжтой байдаг. Мөн түүнчлэн арилжааны нэрийг бүртгүүлснээс хойш хоёр жилийн хугацаанд ашиглаагүй тохиолдолд тухайн нэрийг ашиглахгүй гэж тооцон автоматаар ашиглах эрхийг цуцалдаг байна. (김재두, 2020, 238-р тал)

Арилжааны нэрийн хамгаалалтын талаарх БНСУ-ын хууль дахь бас нэг зохицуулалт нь шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэх, бизнесийн нууцыг хамгаалах тухай хууль дахь зохицуулалт юм. Тус хуулийн 1-р заалтад хуулийн зорилгыг тодорхойлохдоо, дотоодын зах зээлд олон танигдсан бусад этгээдийн зүгээс ашиглаж буй барааны тэмдэг, арилжааны нэрийг зүй бусаар ашиглах үйлдэл болон бусдын бизнесийн үйл ажиллагааны нууцад халдах явдлаас сэргийлж, арилжааны үйл ажиллагааны эрүүл тогтолцоог хадгалахад оршино гэж тодорхойлжээ. (부정경쟁방지및영업비밀보호에관한법률, n.d.)

Тодруулбал, дотоодын зах зээлд олон танигдсан бусад этгээдийн ашиглаж буй барааны тэмдэг болон арилжааны нэртэй ижил эсвэл төсөөтэй барааны тэмдэг болоод арилжааны нэрийг ашиглах бусдыг төөрөгдүүлэх үйлдлийг хориглож буй юм. Энэхүү хуулийн хамгаалалтад багтахын тулд заавал дотоодын зах зээлд танигдсан байхыг шаардах бөгөөд энэ нь заавал улс даяар бус тодорхой бүс нутгийн хэмжээнд танигдсан байх нь мөн нөхцөлийг хангаж буй юм. Мөн түүнчлэн барааны тэмдэг болон арилжааны нэрд халдсан үйлдэл хийгдсэн байхыг шаардахгүй халдах эрсдэл үүсэх нь мөн адил хуулийн хамгаалалтад орох нөхцөл болдог байна. (전현율, 2005, 36-37р тал)

Хүснэгт 3.4. Арилжааны нэр ба барааны тэмдгийг шилжүүлэх, ашиглах эрх дуусгавар болох, шударга өрсөлдөөний хууль дахь ялгаатай байдал

Ангилал	Арилжааны нэр	Барааны тэмдэг
Ашиглах эрхийг шилжүүлэх	1.Арилжааны үйл ажиллагаатай хамт эсвэл	1.Бүртгүүлсэн бараа тус бүрээс хэсэгчлэн

	<p>үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд л шилжүүлэх боломжтой</p> <p>2.Арилжааны нэрийг барьцаалах боломжгүй</p>	<p>шилжүүлэх боломжтой, үйл ажиллагаатай хамт шилжүүлэхийг шаардахгүй</p> <p>2.Арилжааны үйл ажиллагааг зогсоосноор барааны тэмдгийн эрх дуусгавар болохгүй</p>
Ашиглах эрх дуусгавар болох	<p>1.Нэрийг ашиглахаа зогсоосноор</p> <p>2.Бүртгүүлснээс хойш хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 жилийн хугацаанд ашиглахгүй тохиолдолд</p>	<p>1.Барааны тэмдгийн эрхээс татгалзах, хугацаа дуусах, тэмдгийг хүчингүйд тооцох эсвэл цуцалснаар</p> <p>2.Үйл ажиллагааг дуусгавар болгох нь барааны тэмдгийн эрхийг дуусгавар болгохгүй</p>
Шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэх зохицуулалт	<p>Дотоодод олонд танигдсан арилжааны нэр, барааны тэмдэг нь бүртгүүлсэн эсэхээс үл хамааран бизнесийн үйл ажиллагааны эзэмшлийн болон барааны гарал үүслийн талаар төөрөгдүүлэх үйлдлээс шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэх тухай хуулийн дагуу хамгаалагдана</p>	

Эх сурвалж: *전협을*, 2005, 20-р тал

БНСУ-ын шүүхийн шийдвэрийн хураангуй

Хүснэгт 3.5. БНСУ-ын шүүхийн шийдвэрийн хураангуй

No	Бүтэц	Агуулга
1	Танилцуулах хэсэг	<p>Шүүх:Сөүл хотын давж заалдах шатны шүүх</p> <p>Даргалагч шүүгч: Чой Сонгжүн,</p> <p>Бүрэлдэхүүн шүүгчид: Хам Сокчон, Ким Хёнсог</p> <p>Хэргийн индекс:서울고등법원 2010. 1. 20. 선고 2008 나 89356 판결</p> <p>Огноо:2010.01.20</p> <p>Маргааны төрөл:Арилжааны нэрийн бүртгэлийг цуцлуулах, ашиглахыг хориглох</p>
2	Үйл явдлын агуулга	<p>Дунгуй апартамент констракшн ХК-аас Дунгбү констракшн ХК-д холбогдуулж, Сөүлийн төвийн шүүхийн харьяа арилжааны бүртгэлийн газарт бүртгэлтэй байгаа (бүртгэлийн дугаар 000570) тус компанийн бүртгэлийг цуцалж Дунгбү гэх нэрийг дахин ашиглахгүй байхыг даалгах нэхэмжлэл бүхий хэрэг,</p> <p>Нэхэмжлэгч нь 1984.3.14-нд Сөүлийн төвийн шүүхийн арилжааны бүртгэлийн газарт бүртгэлийн дугаар 43044 бүхий</p>



		<p>арилжааны нэр “Дунгбү апартамент констракшн ХК” гэх нэрээр барилга, үл хөдлөхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн.</p> <p>Хариуцагч, Дунгбү констракшн ХК нь ижил бүртгэлийн газарт 1969.1.24-нд Мирюүн констракшн гэсэн нэрээр барилга, үл хөдлөх зэргийн 8 чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн бөгөөд, түүнээс хойш олон удаа үйл ажиллганы чиглэлээ өөрчилсөн хэдий ч одоогийн байдлаар барилга, үл хөдлөхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй. Түүнээс хойш 1989.2.28-ны өдрийн бүртгэлээр арилжааны нэрээ “Мирюүн констракшн ХК” байсныг одоогийнхтой адилаар “Дунгбү констракшн ХК” болгож өөрчилжээ.</p> <p>Нэхэмжлэгч шаардлагын үндэслэлдээ, Арилжааны хуулийн 22-р заалтад “Бусад этгээдийн бүртгүүлсэн арилжааны нэрийг засаг захиргааны ижил хот, сумд арилжааны ижил үйл ажиллагааны арилжааны нэрээр бүртгүүлж болохгүй” гэж заасны дагуу, түрүүлж бүртгүүлсэн арилжааны нэр болон манай компанийн “Дунгбү апартамент констракшн ХК”-ийн чухал хэсэг болох “Дунгбү” гэдэг нэр нь давхцаж буй тул тус нэрийг бүртгэлээс хасуулж, хойшид ашиглахгүй байхыг даалгах нэхэмжлэл гаргасан болно.</p>
3	Шийдвэрлэсэн байдал	<p>Шүүхээс нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.</p> <p>Үндэслэлдээ, Арилжааны хуулийн 22-р заалтад заасан агуулгыг ижил нэрийг, ижил хотод, ижил салбарын үйл ажиллагаанд бүртгэхгүй байх гэж тайлбарлана гээд,</p> <p>1-т тус хоёр компани нь ижил хотод, ижил салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нь тогтоогдож байх боловч,</p> <p>2-т тус хоёр компанийн нэр нь үгийн утга болоод бүтцийн хувьд ижил биш байна гэж үзсэн,</p> <p>Тодруулбал, нэгт, тус хоёр нэр нь бүтэц болоод дуудлагын хувьд өөр байх, хоёрт, нэхэмжлэгчийн нэр зургаан үеэс бүтэх бол хариуцагчийнх 4 үеэс бүтэж байх (энэ утгаар хоёр нэр нь богино гэдэгт акцент өгсөн), гуравт, нэхэмжлэгч нь барилгын чиглэлээр гол үйл ажиллагаа эрхэлдэг учраас констракшн гэдэг нэрийн бүрдэл хэсгээ байнга авч ашиглаж буй учраас дан ганц “Дунгбү” гэх нэр тус компанийн гол нэр гэж үзэхэд учир дутагдалтай гэж үзжээ. Тиймээс тус хоёр компанийн нэрийг ижил буюу ялгахад бэрх гэж үзэх боломжгүй гэжээ.</p> <p>Мөн түүнчлэн нэхэмжлэгчийн шаардаж байгаачлан өөрийн нэр дэх “Дунгбү” гэх хэсэг нь ижил гэдэг үндэслэлээр “Дунгбү констракшн ХК”-ийн арилжааны нэрийн бүртгэлийг цуцалбаас, Сөүл хотод ижил салбарт үйл ажиллагаа явуулж буй “Дунгбү шоппинг центр констракшн” “Дунгбү хороолол</p>

		<p>констракшн” гэх мэт нэрсийг бүгдийг цуцлах шаардлага үүсэх бөгөөд,</p> <p>Энэхүү үр дагавар нь түрүүлж бүртгүүлсэн арилжаа эрхлэгчийн эрх хэмжээ хэт ихсэх нөхцөл байдлыг бий болгохын хамтаар, Арилжааны хуулийн 18-р заалтад заасан арилжаа эрхлэгч нэрээ чөлөөтэй сонгох эрх ноцтой зөрчигдөх үр дүнг авчрах тул зүйд нийцэхгүй гэж үзнэ. Ялангуяа Сөүл хот шиг том хотод нэг компанид тодорхой нэршлийг давуу эрхээр ашиглах эрх олгох нь боломжгүй юм гэжээ.</p>
4	Дүн шинжилгээ	<p>Дээрх шүүхийн шийдвэр нь БНСУ-ын арилжааны хуулийн 22-р заалт дахь “Арилжаа эрхлэгч арилжааны нэрийг чөлөөтэй сонгож ашиглана” гэсэн заалт болон тус хуулийн 22-р заалт болох “Бусад этгээдийн бүртгүүлсэн арилжааны нэрийг засаг захиргааны ижил хот, сумд арилжааны ижил үйл ажиллагааны арилжааны нэрээр бүртгүүлж болохгүй” гэсэн заалтуудыг үндэслэлтэйгээр тайлбарлан шийдвэрлэсэн хэрэг байна.</p> <p>Энэ нь арилжааны бүртгэлийг түрүүлж хийлгэсэн этгээд давуу эрхтэйгээр ашиглах хэдий ч тодорхой нэрийг нэг этгээдэд давуу эрхтэйгээр эзэмшүүлэх нь боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрч байна.Түүнчлэн арилжаа эрхлэгч арилжааны нэрийг чөлөөтэй сонгох зарчмыг харгалзан үзэж тэнцвэртэйгээр шийдвэрлэсэн хэрэг гэж дүгнэж байна.</p>
5	Эх сурвалж	<a href="http://law.go.kr">상호 말소 등기 절차 이행   국가법령정보센터   판례 (law.go.kr)</a>

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

## 3.2. АНУ-ын арилжааны нэрийн зохицуулалт ба эрх зүйн хамгаалалт

### 3.2.1 АНУ-ын эрх зүйн систем ба барааны тэмдгийн хууль

Америкийн нэгдсэн улс нь тавин муж улсуудаас бүрдсэн холбооны улс гэдэг утгаараа манай улсын эрх зүйн тогтолцоотой харьцуулахад эрх зүйн эх сурвалж болон шүүхийн тогтолцооны хувьд ихээхэн ялгаатай юм. АНУ-ын хувьд бидний хэлж заншсанаар жишгийн эрх зүй буюу нийтлэг эрх зүйн тогтолцоотой улсын хувьд эрх зүйн эх сурвалжид шүүхийн прецедент ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх хэдий ч холбооны нэгдсэн улсын болон муж улсуудын хууль тогтоох байгууллагаас батлан гаргасан бичмэл хуулийн хэрэглээ багагүй хэсгийг эзэлнэ.

Эрдэмтэн доктор Б.Амарсанаагийн харьцуулсан эрх зүй судлал сурах бичигт өгүүлснээр АНУ-ын эрх зүйн эх сурвалжийг хуулийн хүчин чадлын хувьд дараах байдлаар ангилсан байна. (Б.Амарсанаа, 2014, 181-р тал)

- АНУ-ын үндсэн хууль
- Холбооны улсын хууль болон олон улсын гэрээ

- Холбооны улсын захиргааны байгууллагаас баталсан нийтээр дагаж мөрдөх зохицуулал болон Холбооны улсын шүүхийн процессын журам
- Холбооны улсын шүүхээс бий болгосон хэм хэмжээ (Federal common law)
- Муж улсын үндсэн хууль
- Муж улсын хууль
- Муж улсын захиргааны байгууллагаас баталсан нийтээр дагаж мөрдөх зохицуулалт болон муж улсын шүүхийн процессын журам
- Муж улсын Дээд шүүхийн шийдвэр
- Муж улсын давж заалдах шатны шүүхийн шийдвэр
- Жишгийн эрх зүй (Common law)

Дээрхээс үзэхэд Америкийн эрх зүйн тогтолцоо нь холбооны улсыг бүхэлд нь хамарсан холбооны хууль болон зөвхөн тодорхой мужийг хамарсан муж улсын хуулиудаас гадна шүүхийн прецедент буюу жишгийн эрх зүйгээс бүрддэг байна. Америкийн эрдэмтдийн бүтээлд эрх зүйн эх сурвалжийг үндсэн эх сурвалж болон хоёрдогч эх сурвалж гэж ангилсан байх бөгөөд үндсэн эх сурвалжид шүүхийн прецедент, холбооны болон муж улсуудын үндсэн хууль, холбооны болон муж улсуудын бусад хуулиуд, олон улсын гэрээ, холбооны улсын болон муж улсуудын захиргааны байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх зохицуулалт, шүүхийн процессын журам орох бол, хоёрдогч эх сурвалжид эрх зүйн тайлбар хураангуй (Restatement of law), загвар хуулиуд (Uniform laws), хууль зүйн ном зохиолууд (Treatises), эрх зүйн мэргэжлийн сэтгүүлүүдэд нийтлэгдсэн илтгэлүүд (Law reviews) багтдаг байна. (Б.Амарсанаа, 2014, 181-186-р тал)

Үүнээс эрх зүйн үндсэн эх сурвалж болох бичмэл хуулиудын хувьд тухайн хууль тогтоох байгууллагаас баталсан даруйд нийтэд зарлагдаж, хэвлэгдэн гардаг бол шүүхийн прецедентийн хувьд жил бүрийн шүүхийн шийдвэрээс тодорхой цөөн тооны шийдвэрийг эмхэтгэн гаргаж улс даяар тараагддаг бөгөөд эдгээрийг хуульчид болох шүүгч, прокурор, өмгөөлөгчид хэрэглэн хэрэг маргаан шийдвэрлэхдээ үндэслэл болгодог байна. Тэгэхээр АНУ-ын хувьд бүх шүүгчид эрх зүйн эх сурвалжийг бүтээдэггүй бөгөөд тодорхой түвшний цөөхөн сод эрдэмтэд л үндэслэл бүхий шийдвэрийг гаргаж түүнийг онолын түвшинд хөгжүүлэх замаар эрх зүйн эх сурвалжууд бүтээгддэг байна.

Дээр тайлбарласны адилаар эрх зүйн тогтолцоо болон эх сурвалжийн хувьд олон шатлал бүхий төвөгтэй тогтолцоотой АНУ-ын хуулийн зохицуулалтыг судлахад ихээхэн бэрхшээл тулгарч буйгаас судлаачийн зүгээс энэхүү судалгааны гол объект болон

арилжааны нэрийн зохицуулалтыг нэгдсэн холбооны улсын бичмэл хуульд суурилан судлахыг зорьж байна. Арилжааны нэрийн зохицуулалтын хувьд муж улс бүхэн тус тусын хуулиар зохицуулж байх бөгөөд харин нэгдсэн улсын хэмжээнд холбооны улсын барааны тэмдгийн хуулиар зохицуулагдаж байна.

АНУ-ын барааны тэмдгийн зохицуулалтын хувьд нэгдсэн улсын хууль болох Холбооны улсын барааны тэмдгийн хууль (U.S. Trademark Law, Federal statutes or Lanham Act) болон Муж улсуудын барааны тэмдгийн хууль үйлчлэхээс гадна шүүхийн жишгийн эмхэтгэлийг ашиглах байдлаар хоёрдмол буюу хосолсон эх сурвалжийг ашиглаж байна. Үүнээс Холбооны улсын хэмжээнд үйлчлэх барааны тэмдгийн хуулийг АНУ-ын ардчилсан намын гишүүн Фритц Ланхамын (Fritz G.Lanham) санаачилснаар 1946 онд баталсан хууль өнөө цагт нэгдсэн улсын хэмжээнд хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

### **3.2.2 АНУ-ын хуульд Арилжааны нэр болон барааны тэмдгийг тодорхойлсон байдал**

Хамгийн энгийнээр дэлхийд англи хэл дээрх хамгийн олон үгсийн сантай оксфорд англи хэлний толиноос арилжааны нэр болон барааны тэмдэгт гэсэн нэр томъёогоор хайлт хийхэд дараах байдлаар илэрч байна. Барааны тэмдэг гэдэг нь: эзэмшигчээс өөр этгээд ашиглах боломжгүй тухайн компани өөрийн бараандаа ашиглаж буй нэр, бэлэг тэмдэг эсвэл дизайн гэсэн ганц утгаар тодорхойлжээ. Жишээ татаж, “биг мак” гэдэг нь макдоналдс компанийн хамгийн их танигдсан барааны тэмдэгт болно гэжээ. Харин арилжааны нэр гэдгийг хоёр салаа утгаар тайлбарласан байна. Эхнийх нь, компанийн зүгээс өөрийн үйлдвэрлэж буй бараанд өгсөн нэр буюу брэндийн нэр гэжээ. Хоёрдох нь компанийн зүгээс бизнесийн зорилгоор авч, ашиглаж буй нэр гээд, жишээ болгож, тус компани АНУ-д үйл ажиллагаа явуулахдаа Марубени гэдэг нэр ашигладаг гэсэн байдлаар тайлбарлажээ. (Trade Name Noun - Definition, Pictures, Pronunciation and Usage Notes | Oxford Advanced Learner’s Dictionary at OxfordLearnersDictionaries.Com, n.d.)

АНУ-ын Нью-Йорк хотод төвтэй банк санхүү, бизнесийн салбараар дагнасан мэдээллийн вэбсайт болох инвестопедиа (investopedia) сайтад нэр томъёог дараах байдлаар тодорхойлжээ. Арилжааны нэр (trade name) болон барааны тэмдэгт (trademark) гэсэн нэр томъёо нь төсөөтэй ойлгогддог хэдий ч хуулийн томъёоллын агуулгаараа ялгаатай өөр ойлголтууд юм. Арилжааны нэр гэдэг нь хувь хүн эсвэл компани бизнесийн үйл ажиллагаагаа явуулж буй албан ёсны нэр юм. Харин барааны тэмдэг гэдэг нь аливаа

арилжааны нэртэй холбоотой байх, эсвэл тусдаа байж болох тодорхой нэг брэндэд хуулийн хамгаалалт олгодог ухагдахуун юм гэж тайлбарлажээ. (J.V. Maverick, 2022)

Тодруулбал арилжааны нэр гэдэг нь хувиараа бизнес эрхлэгч (sole proprietor) эсвэл компани бизнес эрхлэхдээ сонгож ашиглаж буй албан ёсны нэр бөгөөд Америкийн мужуудад ихэвчлэн өөр нэрээр бизнесээ эрхлэх буюу DBA (doing business as name) гэсэн нэршлээр өргөн хэрэглэгддэг. DBA гэдэг нь хувь хүн эсвэл компани өөрийн аж ахуйн нэгжийн бүртгэлийн нэрээс гадна өөр зохиомол нэрээр бизнесээ эрхлэхийг хүсвэл бүртгүүлж ашиглах нэр гэж тайлбарласан байх бөгөөд, энэ нь өмнөх арилжааны нэр гэдэг тайлбартай агуулгын хувьд ижил юм. (Chauncey Crail, 2022)

Америкийн “Хуулийн сэтгүүл” (Law Journal)-ийн 2015 оны дугаарт оюуны өмчийн хуульч Лани Барнесийн өгүүлснээр Арилжааны нэр болон барааны тэмдэгтийг дараах байдлаар тодорхойлжээ. Арилжааны нэр нь бизнесийн үйл ажиллагааг бусдаас ялгадаг бол барааны тэмдэг нь бизнесийн үйл ажиллагаагаар үзүүлж буй үйлчилгээ болон барааг бусдаас ялгахын тулд ашигладаг байна. Арилжааны нэр нь зөвхөн бизнесийн үйл ажиллагааг явуулж буй нэр төдий л зүйл юм. Энэхүү нэр нь гэрээ хэлэлцээр, татвар, албан бичиг, төлбөр тооцооны нэхэмжлэх, банкны данс, хувьцааны эрхийн бичиг зэрэг олон төрлийн санхүү болон захиргааны үйл ажиллагаанд компанийг илтгэх зорилгоор ашиглагддаг байна. (Lani Barnes, 2015, 86-р тал)

Харин барааны тэмдэг нь зах зээлд борлуулах эсвэл үзүүлж буй тодорхой нэг үйлчилгээг бусдынхаас ялгаж эх үүсвэрийг таниулах зорилгоор ашиглаж буй нэр, сийвэл болон хэрэглэгдэхүүн, эсвэл эдгээрийн иж бүрдлийг хэлнэ. Барааны тэмдэг нь бизнес эрхлэгчийн бараа, үйлчилгээг бусдынхаас ялгаад зогсохгүй хэрэглэгчдэд тухайн барааны тэмдгээр үзүүлж буй бараа, үйлчилгээний чанарын найдвартай байдлыг баталгаажуулж өгдөг. Хэрэв тухайн арилжааны нэрийн дор тодорхой бараа эсвэл үйлчилгээг үзүүлж байвал арилжааны нэр барааны тэмдэг болох боломжтой байдаг хэдий ч тус барааны тэмдгийг бүртгүүлснээр баталгааждаг гэжээ. (Lani Barnes, 2015, 87-р тал)

АНУ-ын хуульч бөгөөд Патент, барааны тэмдгийн газрын дарга асан Сидней Даймондын тодорхойлсноор Америкийн бичмэл хуулиуд болон судалгааны бүтээлүүдэд арилжааны нэр (trade name) гэдэг ухагдахуун гурван утгаар ойлгогдож байгаа гэх бөгөөд нэгт, арилжааны үйл ажиллагаа явуулах зорилгоор компани, нөхөрлөл, хувь хүн ашиглаж буй бизнесийн нэр, хоёрдугаарт, арилжааны үйл ажиллагаагаар үзүүлж буй бараа, үйлчилгээний эх үүсвэрийг илтгэх утга, гуравдугаарт барааны тэмдэгтэй ижил утга (synonym) илэрхийлж байна гэж үзжээ. Өөрөөр хэлбэл арилжааны нэр (trade name)

гэдэг ойлголт нь хоёрдогч утга бүхий барааны тэмдэг (secondary meaning trademark) гэдэг хоёр ойлголтыг хольж ойлгох, ижил утгаар ашиглаж байгаа гэдгийг тайлбарлажээ. (Sidney A. Diamond, 1979, 1524-р тал)

Тэгвэл АНУ-ын хуульд арилжааны нэр болон барааны тэмдгийг хэрхэн тодорхойлсныг авч үзье. Ану-ын холбооны хэмжээнд үйлчилж буй “Барааны тэмдгийн тухай хуульд” (U.S. Trademark Law or Lanham Act) төсөөтэй ойлголтууд болох арилжааны нэр, барааны тэмдэгт, үйлчилгээний тэмдгийг дараах байдлаар тодорхойлжээ.

Арилжааны нэр (Trade name, commercial name) буюу худалдааны нэр гэдэг нь хувь хүн эсвэл компани өөрийн эрхэлж буй бизнес эсвэл ажлыг (vocation) бусдаас ялгах зорилгоор ашиглаж буй ямарваа нэг нэрийг хэлнэ. (U.S. Trademark Law, 2013)

Харин барааны тэмдэг (trademark) гэдэг нь тухайн барааны эх үүсвэр нь мэдэгдэж буй эсэхээс үл хамааран, бусдын үйлдвэрлэсэн эсвэл борлуулж буй бараанаас өөрийн энгийн болон онцгой бараа бүтэгдэхүүнийг ялгах, гарал үүслийг нотлох зорилгоор тус хуульд заасан албан бүртгэлд (principle register) бүртгүүлэн, арилжаандаа ашиглах чин эрмэлзэлтэйгээр хувь хүн эсвэл компанийн ашиглаж буй аливаа үг, нэр, символ, эсвэл хэрэглэгдэхүүн болон тэдгээрийн иж бүрдлийг хэлнэ.

Тэгвэл үйлчилгээний тэмдэг (service mark) гэдэг нь тухайн үйлчилгээний эх үүсвэр нь мэдэгдэж буй эсэхээс үл хамааран, өөрийн үзүүлж буй үйлчилгээ болон онцгой үйлчилгээг бусдын үйлчилгээнээс ялгах, эх үүсвэрийг нотлох зорилгоор тус хуульд заасан албан бүртгэлд (principle register) бүртгүүлэн, арилжаандаа ашиглах чин эрмэлзэлтэйгээр хувь хүн эсвэл компани ашиглаж буй аливаа үг, нэр, символ, эсвэл хэрэглэгдэхүүн болон тэдгээрийн иж бүрдлийг хэлнэ. Ивээн тэтгэгчийн бараа бүтэгдэхүүнийг сурталчилж байгаа эсэхээс үл хамааран радио эсвэл телевизийн хөтөлбөрийн нэр (title), дүрийн нэр (character name) болон бусад ялгамжтай онцлог (distinctive feature)-ыг үйлчилгээний тэмдгээр бүртгүүлж болно гэж тус тус заажээ.

Дээрх тайлбаруудаас үзэхэд АНУ-ын хуульд арилжааны нэр гэдэг ойлголтыг барааны тэмдэг болон үйлчилгээний тэмдгээс томъёоллын хувьд ялгаатай байдлаар тодорхойлсон байна. Тодруулбал, арилжааны нэр нь арилжааны буюу бизнесийн үйл ажиллагааг бусдын эрхэлж буй бизнесийн үйл ажиллагаанаас ялгах зорилгоор ашиглаж буй нэр бол барааны тэмдэг нь өөрийн үйлдвэрлэсэн бараа болон үзүүлж буй үйлчилгээг бусдынхаас ялгах зорилгоор ашиглаж буй тэмдэг гэдэг нь тодорхой байна. Гэвч АНУ-ын хууль болон судалгааны бүтээлүүдэд арилжааны нэр гэх ойлголтыг барааны тэмдэг, тэр

дундаа үгэн тэмдэгтэй (word mark) хольж хутгах, ижил төсөөтэй ойлголт мэтээр тайлбарлах нь түгээмэл байдаг байна. Жишээлбэл, АНУ-ын хуульч Сидней Даймондын судалгааны бүтээлдээ хэлсэнчлэн арилжааны нэр (trade name) гэдэг ойлголтыг бизнесийн нэр, барааны гарал үүсэл илтгэх утга, барааны тэмдэгтэй ижил утгаар ойлгож байна гэж тайлбарлажээ.

### 3.2.3 АНУ-ын эрх зүйн Арилжааны нэрийг хамгаалах зохицуулалтууд

АНУ-ын Холбооны улсын хууль (United States Code) нь 50 тайтэл (title) бүхий 1-ээс 2501 хүртэлх зүйл бүхий багц хууль байх бөгөөд Монгол улсын хуулийн тогтолцоотой харьцуулбал тухайн бүлэг бүр нь төрөлжсөн хууль буюу иргэний хууль, эрүүгийн хууль, захиргааны хууль, хөдөлмөрийн хууль, барааны тэмдгийн хуулийн үүргийг гүйцэтгэнэ гэж ойлгож болох юм. Үүний 15-р тайтэл (title) нь арилжаа болон худалдаанд хамаарах бөгөөд, тухайн тайтлын 32-р бүлгийн 1051-р зүйлээс 1127-р зүйл нь барааны тэмдгийг зохицуулах хуулийн хэсэг болно.

Хүснэгт 3.6. АНУ-ын Холбооны хуулийн ерөнхий бүтэц

Title	Chapter	Subchapter	Section	Subsection	Paragraph
Тайтэл	Бүлэг	Дэд бүлэг	Хэсэг	Дэд хэсэг	Догол мөр

Эх сурвалж: *Korean Intellectual Property Office, 2006, 21-р тал*

АНУ-ын холбооны барааны тэмдгийн хууль нь жишгийн эрх зүйн шударга бус өрсөлдөөний зохицуулалтад суурилсан хууль бөгөөд, барааны тэмдгийн маргааны шийдвэрлэхэд бичмэл хууль болон жишгийн эрх зүй гэсэн хоёр эх сурвалжийг ашиглаж байна. Өөрөөр хэлбэл холбооны хууль болон муж улсуудын хуулиас гадна шүүхийн шийдвэрийн эмхэтгэлээс бүрдэх жишгийн эрх зүйн зэрэгцэн орших тогтолцоотой гэсэн үг юм. Хууль хэрэглээний хувьд муж улс доторх худалдаа, арилжааны харилцаанд мужийн хууль үйлчлэх бол муж хоорондын болон гадаад улсуудтай харилцах худалдаа, арилжаанд холбооны улсын хуулийг хэрэглэдэг байна. Сүүлийн үед технологи хөгжиж, худалдаа арилжаа цахимаар хийгдэх болсонтойгоор мужийн хуулиас илүү холбооны улсын хуулийг хэрэглэх хэрэгцээ шаардлага илүү ихээр нэмэгдэж байгаа болно. (Korean Intellectual Property Office, 2006)

Тэгвэл холбооны улсын хууль болон жишгийн эрх зүйн алийг хэрэг шийдвэрлэхэд ашиглах вэ гэдэг асуудлыг судалж үзвээс, холбооны барааны тэмдгийн хууль нь жишгийн эрх зүйд суурилж бүтээгдсэн хууль учраас хоорондоо зөрчилдөх асуудал харьцангуй бага байдаг бөгөөд хэрэг маргаан шийдэхэд бичмэл хуулийг ашиглах хэдий ч бичмэл хуулийн зүйл заалтын тодорхойгүй байдлыг тайлбарлахад жишгийн эрх

зүйг ашиглах байдлаар буюу зэрэгцээ байдлаар ашиглаж байна. Өөрөөр хэлбэл барааны тэмдгийн хамгаалалт нь холбооны барааны тэмдгийн хууль болон жишгийн эрх зүй хоёуланд туссан гэж ойлгохоор байна.

АНУ-ын жишгийн эрх зүйд арилжааны нэр болон барааны тэмдгийг адилтган үзэж, ижил зарчмаар зохицуулж, хамгаалагддаг бөгөөд арилжааны нэрд төөрөгдөл үүсэх магадлалтай (likelihood of confusion) нөхцөл байдлыг бусдын арилжааны нэрийн эрхэд халдсан үйлдэл гэж үздэг байна. (Korean Intellectual Property Office, 2006)

Харин АНУ-ын барааны тэмдгийн хуульд арилжааны нэр болоод барааны тэмдгийн ойлголтыг тус тусад нь тодорхойлсон байдаг. Тодруулбал, арилжааны нэр гэдэг нь өөрийн ажлын болон бизнесийг тодорхойлох зорилгоор ашиглаж буй нэр бол барааны тэмдэг нь барааг ялгах зорилгоор ашиглаж буй тэмдэг юм. Гэхдээ арилжааны нэрийг бүртгэх зохицуулалтыг тус хуульд зохицуулаагүй байдаг. Харин тус хуулийн 43-р заалтын (а) хэсэгт “бусдын нэрийг ашиглан төөрөгдөл үүсгэх үйлдэл хийвээс, төөрөгдөл үүсгэгч тал тус үйлдлээс үүдэн хохирч буй талын өмнө иргэний хариуцлага хүлээнэ” гэж заасан байх бөгөөд арилжааны нэрд халдсан үйлдлийн холбооны шүүхээр хамгаалуулж, шийдвэрлүүлэх боломжтой гэсэн зүйлийг тусгасан байна. Үүнээс үзэхэд АНУ-ын барааны тэмдгийн хууль нь арилжааны нэрийг хувь хүний эд хөрөнгийн эрхэд хамааруулж, тус эрхийн талаар шууд нэрлэж зохицуулсан байна. Мөн түүнчлэн барааны тэмдгийг бүртгүүлэх хүсэлт гаргасан барааны тэмдгийн шүүлт хийх явцад тухайн барааны тэмдэгтэй ижил төсөөтэй арилжааны нэрийг ашиглаж байх буюу төөрөгдөл үүсэх магадлалтай гэж үзвээс бүртгэхээс татгалздаг байна. Энэ утгаараа арилжааны нэр нь барааны тэмдгийн нэгэн адил тус хуулийн хамгаалалтад байгаа гэж ойлгоход хүрч байна.

Мөн түүнчлэн муж улсуудын компанийн хуулиудаас тэргүүлэх ач холбогдолтой, нөлөө бүхий хууль болох Дэлавэйр (Delaware) мужийн компанийн хуульд тус мужийн хэмжээнд ижил салбарт үйл ажиллагаа явуулах компаниудын нэр нь бусдаас ялгагдах шинжтэй буюу өөр байх ёстой гэж анх тусгасан байсан бол сүүлд 1929 онд нэмэлт өөрчлөлтөөр орсноор ижил төрлийн үйл ажиллагаа эрхлээгүй байсан ч ялгаатай байх ёстой хэмээн оруулжээ. Гэхдээ энэ нь зөвхөн бүртгэлд бүртгэгдсэн нэрийн хэмжээнд хязгаарлагдах бөгөөд бүртгэлд бүртгэгдсэн бүтэн нэрээс гадна товчилсон нэрийн хувьд ч ялгаатай байх ёстой гэсэн утгаар ойлгоно гэж заажээ. (전현율, 2005, 39-р тал)

Арилжааны нэр болон барааны тэмдгийн бүртгэлийн хувьд хоёр өөр байдлаар зохицуулагдаж байна. Арилжааны нэрийн хувьд муж улсууд дотооддоо бүртгүүлэх



тогтолцоотой буюу ихэвчлэн мужийн захиргаа (state government) эсвэл аймгийн захиргаа (county clerk's office) бүртгэлийг хийдэг. Арилжааны нэрийг бүртгэх практик чиг үүрэг нь компани болон хувь хүний захиргааны болон санхүүгийн бүртгэлийн зорилготой байдаг бөгөөд учир нь гэвэл ихэнх улсуудад арилжааны бүртгэлийн нэрийн шаардлага өөр өөр байдгаас давхардуулж олгох тохиолдол элбэг байдаг байна. Энэ туйлын хамгаалалт (unlimited protection) болж чаддаггүй байна. (J.V.Maverick, 2022)

Харин барааны тэмдгийн (trademark) хувьд арилжааны нэрээс тусдаа буюу нэгдсэн захиргааны түвшинд (federal level) бүртгэл хийлгэх бөгөөд барааны тэмдгийг бүртгүүлснээр тус тэмдгийг эзэмшигчийн хувьд тухайн барааны тэмдгийг давуу эрхтэйгээр (exclusive) ашиглах эрхийг баталгаажуулж байгаа явдал юм. Барааны тэмдгийн бүрдэлд бизнесийн нэр, лого, символ, уриа зэргийг хамруулах бөгөөд арилжааны нэр нь тухайн барааны тэмдгийн нэг хэсэг эсвэл бүхэлдээ ч байж болдог байна. (J.V.Maverick, 2022)

Арилжааны нэр болон барааны тэмдгийг хамгаалах хуулийн зарчмыг ашигласнаар эрх үүсэх зарчим болон бүртгүүлснээр эрх үүсэх зарчим гэж ангилдаг талаар өмнөх бүлэгт дурдсан билээ. Дэлгэрүүлбээс, бүртгүүлснээр эрх үүсэх зарчим гэдэг нь арилжааны нэр болон барааны тэмдгийг бүртгүүлсэн байдлыг суурь болгож эзэмшил үүсэх болон дуусгавар болохыг тогтоодог бол ашигласнаар эрх үүсэх зарчим гэдэг нь арилжааны нэр болон барааны тэмдгийг авч ашигласан байдлыг суурь болгож эзэмшил үүсэх, эрхээ хадгалах, дуусгавар болохыг тогтоодог хуулийн зарчим юм. Эхний зарчмыг Англи, Америк, Канад зэрэг нийтлэг эрх зүйн бүлийн улсууд баримталдаг бол хоёрдохыг Герман, Япон тэргүүтэй иргэнлэг эрх зүйн бүлийн улсууд баримталдаг зарчим юм. АНУ нь ашиглалтад суурилсан зарчим баримталдаг учраас тухайн улсын зарчмыг илүү тодорхой болгох үүднээс хоёр зарчмын ялгааг доор хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3.7. Бүртгэлд суурилсан зарчим болон ашиглалтад суурилсан зарчмын давуу болон сул талууд

Бүртгэлийн зарчим		Ашиглалтын зарчим	
Барааны тэмдгийн ашиглаж байгаа эсэхийг үл хамаарч бүртгэлийг хүлээн зөвшөөрч, бүртгүүлсэн тэмдгийн эзэмшлийг хүлээн зөвшөөрдөг тогтолцоо (ХБНГУ, Япон, БНСУ, БНХАУ зэрэг)		Бодитоор ашигласнаар эзэмшил үүссэн гэж үзэж эрхийг хүлээн зөвшөөрдөг тогтолцоо, бүртгэл нь нотлох баримтын үр нөлөөтэй (АНУ, Канад зэрэг)	
Давуу тал	Сул тал	Давуу тал	Сул тал

<p>1.Эзэмшлийн эрх тодорхой, таамаглах боломж өндөр, хууль тогтвортой байдаг</p> <p>2.Тогтолцооны хяналт хялбар, захиргааны зардал бага</p> <p>3.Ирээдүйд хэрэг болох тэмдгийг урьдчилан авах боломжтойгоос бизнес хөгжүүлэлтэд тохиромжтой</p>	<p>1.Ашиглах эсэхээс үл хамаарах эзэмшлийг хүлээн зөвшөөрдгөөс хуулийн нийцтэй байдал сул</p> <p>2.Ашиглахгүй тэмдэг хуримтлагдсанаас бусдын сонголтыг хязгаарлах</p> <p>3.Муу санаат үйлдлээр бусдын бизнест саад хийх үйлдэл гарч болзошгүй</p>	<p>1.Бизнесийн итгэл (goodwill) үүссэн болсон тэмдэг нэр зэргийг хамгаалах боломжтойгоос хуулийн зорилгод нийцэх</p> <p>2.Ашиглалтад суурилсан тэмдэг болон нэрийн баялгийн хуваарилалт зөв хийгдэх</p> <p>3.Тэмдэг болон нэрийг хадгалалт буурч, сонголт ихсэх</p>	<p>1.Тэмдэг болон нэрийг хөгжүүлэх, урьдчилж хөрөнгө оруулах нь эрсдэл өндөртэй</p> <p>2.Ашиглаж буйг нотлох шаардлагатайгаас захиргааны зардал өндөртэй</p> <p>3.Тэмдэг болон нэрийг ашиглах явцад үсч болох эрсдэл их, эзэмших эрх тогтвортой бус, маргаан үүсэх эрсдэл өндөр</p>
---	---	---	---

Эх сурвалж: 손영식, 2014, 43-р тал

Америкийн хувьд муж улсуудын хууль болон шүүхийн прецедент нь ашигласнаар эрх үүсэх зарчмыг хатуу баримталдаг бол Холбооны барааны тэмдгийн хууль нь зарим нэг тусгай зохицуулалтыг эс тооцвол үндсэндээ ашигласнаар эрх үүсэх зарчимд суурилдаг байна. Холбооны хуульд бүртгэлийн зохицуулалт байгаа хэдий ч энэхүү зохицуулалт нь барааны тэмдгийг ашиглаж буй потенциал эзэмшигчдэд зарлах үүргийг гүйцэтгэх тогтолцоо буюу эзэмшлийн эрх үүсгэх гэхээсээ илүү эхэлж бүртгүүлсэн бүртгэл нь хүчин төгөлдөр гэсэн нотолгооны үүргийг (prima facie evidence) гүйцэтгэдэг байна. Тэмдгийг бүртгүүлсэн этгээдээс урьтаж ашиглаж байсан этгээд нь бусдын саадгүйгээр тэмдгийг үргэлжлүүлэн ашиглах эрхтэй бөгөөд, бүртгүүлсэн этгээдийн зүгээс мөн тэмдгээ ашиглахгүй байх аваас бүртгэлийг хүчингүй болгох зохицуулалт үйлчилдэг байна. (손영식, 2014, 46-р тал)

Өөрөөр хэлбэл АНУ-ын хувьд арилжааны нэр болон барааны тэмдгийг бүртгэл хийсэн эсэхээс үл хамааран хамгаалах зарчим буюу ашигласнаар эзэмшил үүсэх зарчим баримталдаг гэдэг утгаараа арилжааны нэр болон барааны тэмдэг нь хуулийн хамгаалалтад багтана. АНУ-ын холбооны барааны тэмдгийн хуульд барааны тэмдгийн хамгаалалтын талаар үндсэн ойлголт нь хоёр байдлаар туссан байна. Эхнийх төөрөгдөл үүсэх зарчим (confusion) бол хоёрдох нь уусгаж бүдгэрүүлэх зарчим (dilution) байна. (Korean Intellectual Property Office, 2006, 35-38р тал)

Төөрөгдөл үүсгэх зарчим гэдэг нь бусдыг төөрөгдүүлэх, хууран мэхлэх нөхцөл байдал үүсэх аваас тухайн барааны тэмдгийг ашиглахыг хориглох зохицуулалт юм. Тодруулбал, барааны тэмдгийг хамгаалах гол шалтгаан нь болбоос олон нийт худалдан

авалт хийх явцад барааны гарал үүслийн талаар төөрөгдөхөөс сэргийлэх явдал бөгөөд, хэрэв олон нийт барааны гарал үүсэлд төөрөгдөх магадлалтай гэж үзвээс тухай барааны тэмдэгтэй ижил болон төсөөтэй тэмдгийг ашиглахыг хориглохоор зохицуулдаг байна. Төөрөгдөх гэдэгт бараа бүтээгдэхүүнд төөрөгдөхөөс гадна барааны тэмдэг эзэмшигч буюу харилцан хамааралд төөрөгдөх хүртэл өргөн хүрээнд авч үздэг байна. Мөн түүнчлэн худалдан авахаас өмнөх болон худалдан авснаас хойш төөрөгдсөнийг ч бас хамруулдаг байна.

Харин ижил төсөөтэй гэдэгт гурван нөхцөл байдлыг хамруулж үзэх бөгөөд, нэгдүгээрт, төөрөгдөх магадлал үүссэн байдал (possibility of confusion), хоёрдугаарт, бодитоор төөрөгдсөн байдал (actual confusion), гуравдугаарт төөрөгдөх нөхцөл үүсэж магадгүй нөхцөл байдал (likelihood of confusion)-д хувааж авч үздэг байна. Эхний тохиолдолд барааны тэмдгийг эзэмшигчид хэтэрхий давуу байдлыг үүсгэдэг бол, хоёрдох тохиолдолд тухайн нөхцөл байдлыг нотлох шаардлага үүсдэгээс барааны тэмдэг эзэмшигчид хохиролтой байдлыг үүсгэдэг бол, сүүлийн тохиолдолд барааны тэмдэг эзэмшигч болон шинээр барааны тэмдэг ашиглагч хоёр талын аль алины нөхцөл байдлыг харгалзаж үзсэн холимог хэлбэр гэж хэлж болно.

Хоёрдох зарчим болох уусгах зарчим гэдэг нь барааны тэмдгийн хамгаалалтыг илүү нэмэгдүүлэх зорилго бүхий зарчим юм. Тодруулбал, барааны тэмдэг эзэмшигчийн олж авсан олон нийтийн талаарх илтгэл (goodwill) болоод барааны тэмдэг хэрэглэгчдэд дамжуулж буй мэдээллийн үнэ цэнийг хамгаалахад оршиж буй юм. Өөрөөр хэлбэл барааны тэмдэгт төөрөгдөх нөхцөл байдал үүсээгүй ч гэсэн тухайн барааны тэмдгийн үнэ цэнийг багасгах нөхцөл байдал үсч байх аваас тухайн барааны тэмдгийг ашиглах явдлыг хориглох ёстой гэж үзнэ. Энэхүү зарчимд үндэслэн шийдсэн хэргийн кэйс бол гэрэл зургийн аппарат болон хальс үйлдвэрлэдэг “KODAK” компанийн нэхэмжлэл бүхий болон унадаг дугуй үйлдвэрлэдэг компани үйлдвэрлэдэг “KODAK” компанийн эсрэг зарга үүсгэсэн явдал юм. Шүүхээс үзэхдээ хэрэглэгчдийн зүгээс зургийн аппарат болон унадаг дугуй гэсэн бараанд төөрөгдөх нөхцөл байдал үүсэхгүй ч гэсэн тухайн барааны тэмдгийг ашиглахыг хориглох шийдвэр гаргасан байна. Шүүхээс тайлбарлахдаа, хоёр тал нь өрсөлдөгчид биш төдийгүй хоёр талын үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүнд төөрөгдөх явдал үүсэхгүй ч олонд танигдсан нэр хүнд бүхий барааны тэмдгийн ялгагдах шинжийг бүдгэрүүлж, уусгаж буй үйлдэл учраас хориглох шийдвэр гаргасан гэжээ.

Мөн түүнчлэн АНУ-ын барааны тэмдгийн хуульд үсгэн тэмдэг, тоон тэмдэг, уриа хэлбэрийн тэмдэг, газар зүйн заалтын тэмдэг, гадаад үгэн тэмдэг, өнгөн тэмдэг, дуу

чимээн тэмдэг, үнэртэх тэмдэг зэргийг хүртэл барааны тэмдгээр бүртгүүлэх боломжтой байдаг. Мөн түүнчлэн сүүлийн үед томоохон компаниудын зүгээс маркетинг болон менежментийн зорилгоор арилжааны нэрээ барааны тэмдгээр ашиглах, бүртгүүлэх байдлаар тус хоёр ойлголтыг хослуулан ашиглах нь түгээмэл болж байна. Энэ байдлаар барааны тэмдэг болон арилжааны нэрийг хослуулах байдлаар ашиглах, чиг үүргийг нэгтгэх нь бизнесийн үйл ажиллагааг илтгэх нэрэн тэмдэг (word mark or name mark, 상호상표) ашиглах явдлыг улам бүр өргөтгөж байна. Өөрөөр хэлбэл Фэйсбүүк гэдэг нэрийг энгийнээр бичиг ашиглах нь арилжааны нэр болох бол тусгай өнгө буюу хөх өнгө нэмж, хэлбэрийг өөрчилж ашигласнаар барааны тэмдэг болгон ашиглах байдлаар нэрэн тэмдгийг өргөн ашиглаж байна.

Тэгвэл арилжааны нэрийг чухам ямар тохиолдолд барааны тэмдгээр бүртгүүлж ашиглах боломжтой талаар АНУ-ын хуульд дараах байдлаар тусгасан байна. АНУ-ын шүүхээс барааны тэмдгээр бүртгүүлэх өргөдөл гаргасан тэмдгийн ялагдах онцлогтой байдлыг дөрвөн төрөлд хувааж авч үздэг байна. Нэгдүгээрт, энгийн нэршил (generic terms) бүхий тэмдэг, хоёрдугаарт, илэрхийлэх утга бүхий (descriptive terms) тэмдэг, гуравдугаарт, битүүгээр санал болгох тэмдэг (suggestive terms), тохиолдлын болон төсөөллийн (arbitrary/fanciful) тэмдэг гэж ялгадаг байна. (Korean Intellectual Property Office, 2006, 35-38р тал)

Энгийн нэршлийн (generic terms) тэмдэг гэдэг нь эд зүйлийг бидний өдөр тутамдаа ашигладаг утгаар илэрхийлсэн нэршлийг хэлнэ. Энэхүү нэршлийг хүн төрөлхтөн өдөр тутамдаа саадгүй ашиглах шаардлагатай учраас хэн нэгэн барааны тэмдэг эзэмшигчид монопол эрхийг өгснөөр олон нийтийн эрх ашиг хөндөгдөнө гэж үзэж барааны тэмдгийн хамгаалалтад ордоггүй байна. Жишээлбэл, компьютерын худалдаанд “Компьютер” гэдэг тэмдгийг ашиглах.

Харин илэрхийлэх утга бүхий (suggestive terms) тэмдэг гэдэг нь тодорхой төрлийн шинж чанар, бүрдэл хэсэг, зорилго бүхий барааг илэрхийлэх байдлаар дүрсэлсэн барааны тэмдгийг хэлнэ. Энэ төрлийн тэмдэг нь олон нийтэд бусад бараанаас ялгагдах тэмдгээр танигдахаас илүү толь бичгийн утгаар ойлгогддог учраас ялгагдах онцлог шинжгүй гэж үзэж барааны тэмдгээр бүртгэх боломжгүй байдаг. Илэрхийлэх утга бүхий тэмдэг зөвхөн удаан хугацаанд тус тэмдгийг ашигласны үндсэн дээр хоёрдогч утгыг (secondary meaning) олж авах буюу тухайн нэршил нь тухайн барааны гарал үүслийг илтгэх утгатай болсноор барааны тэмдгээр бүртгэх боломжтой болдог байна. Жишээлбэл, талхны цехэд, “Амттай талх” гэсэн тэмдгийг ашиглах.

Битүүгээр санал болгох нэршил (suggestive terms) гэдэг нь ямарваа үгийг толь бичгийн утгаар ашиглах хэдий ч тухайн үг хэллэг нь тухайн барааг шууд илтгэхгүй, шууд бус байдлаар битүүхнээр санаа өгч илэрхийлэхийг хэлнэ. Тус нэршил нь бараа бүтэгдэхүүний онцлог шинжийн талаар мессеж өгөх хэдий ч хэрэглэгчийн зүгээс тухайн тэмдгийг хараад шууд ямар гэдгийг таних боломжгүй буюу өөрөө ухаж, бодож байж ойлгох боломжтой гэдгээрээ илэрхийлэх утга бүхий тэмдгээс ялгаатай байдаг. Жишээлбэл, цавуунд “Найдвартай” гэсэн тэмдгийг ашиглах.

Эцэст нь тохиолдлын тэмдэг (arbitrary mark) гэдэг нь тэмдэг ашиглагчийн зүгээс олон нийтийн зүгээс толь бичгийн утгаар ашиглаж буй нэршлийг тухайн утгатай ямар ч холбоогүй бараа бүтээгдэхүүнд ашиглахыг хэлнэ. Жишээлбэл, тамхинд “Camel” буюу тэмээ гэсэн тэмдгийг ашиглах тохиолдол юм. Харин төсөөллийн тэмдэг (fanciful mark) гэдэг нь толь бичигт байхгүй үгийг шинээр зохиож хэрэглэхийг буюу зохиомол үг (coined word) ашиглахыг хэлнэ. Жишээлбэл, “KODAK” “EXXON” “ROLEX” зэрэг болно. Эдгээрээс битүүгээр санал болгох тэмдэг болон төсөөллийн буюу зохиомол тэмдэг нь шууд барааны тэмдгээр бүртгүүлэх боломжтой буюу хүчтэй тэмдэгт тооцогддог бол энгийн нэршил болон илэрхийлэх утга бүхий тэмдэг нь ашиглалтын явцад хоёрдогч утгыг өөрөө олж авснаар барааны тэмдгээр бүртгүүлэх боломжтой болдог байна.

АНУ-ын Патент, барааны тэмдгийн газрын дарга асан Сидней Даймондын судалгааны бүтээлд өгүүлснээр арилжааны нэрийг барааны тэмдгээр бүртгүүлэхийн тулд тухайн нэр нь бусдаас ялгагдах онцлогтой (distinctive) байх ёстой бөгөөд зарим арилжааны нэр нь шууд барааны тэмдгээр бүртгүүлэх шалгуурыг хангадаг байна. Жишээлбэл, ямар нэгэн утга илэрхийлдэггүй зохиомол буюу үүсмэл үг (coined word)[kodak, exxon], хийсвэр үг буюу энгийн үг хэллэг хэдий ч ашиглах гэж буй тухайн бараа, үйлчилгээтэй ямар ч холбоогүй үг[arrow shirts, camel cigarettes], битүүгээр санал болгосон тэмдэг (suggestive terms) буюу бодит эсвэл зохиомол үг эсэхээс үл хамааран үзүүлж буй бараа, үйлчилгээг битүүхэн илтгэж буй үг[kleenex, Jell-O, Xerox] зэрэг болно. Дээрх арилжааны нэрсийг ялгагдах шинж бүхий барааны тэмдэг буюу техникал барааны тэмдэг (distinctive trademark or technical trademark) гэж нэрлэжээ. (Sidney A.Diamond, 1979, 1524-р тал)

Харин энгийн үг (generic terms) эсвэл илэрхийлэх утга бүхий үг (descriptive terms), газарзүйн байршил заасан үг (geographical place names), ургийн овог (family surnames) зэрэг нь барааны тэмдгээр бүртгүүлэх шаардлагыг хангадаггүй буюу тухайн компанийн бараа, үйлчилгээг бусдынхаас ялгах онцлог шинжгүй (nondistinctive) гэж үздэг байна.

Гэсэн хэдий ч тухайн нэр нь ялгагдах онцлог шинж (distinctive)-ийг өөрөө үүсгэн бий болгох буюу хоёрдогч утгыг (secondary meaning) олж авсан тохиолдолд л барааны тэмдгээр бүртгэгдэх боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл тухайн бараа, үйлчилгээг үзүүлэгчийн зүгээс тухайн нэрээр бараа үйлчилгээг үзүүлж олонд танигдсанаар олон нийт тухайн арилжааны нэрийн анхдагч утгыг мартаж хоёрдогч утгаар ойлгох болсон буюу бараа, үйлчилгээний эх үүсвэр гэж ойлгох болсон тохиолдолд барааны тэмдгээр бүртгүүлэх шалгуурыг хангадаг гэжээ. (Sidney A.Diamond, 1979, 1524-р тал)

АНУ-ын Оюуны өмчийн шүүгч асан Маргарет Барретийн судалгааны бүтээлд өгүүлснээр, техникал барааны тэмдэг гэдэг нь мөн чанартаа ялгагдах шинж чанартай (inherently distinctive) “зохиомол, дурын, онцгой, ялгагдах, үл илэрхийлэх” шинж бүхий үг хэллэг, бэлэг тэмдэг зэргийг арилжаа эрхлэгч өөрийн бараанд ашигласныг хэлнэ. Харин арилжааны нэр (trade name) болон хоёрдогч утга бүхий барааны тэмдэг (secondary meaning mark) гэдэг нь өөрийн бизнес, бараа, бүтэгдэхүүнийг илэрхийлэх зорилгоор хүний нэр, арилжаанд ашиглагдах түгээмэл нэршил, компанийн нэр болон бизнесийн нэр зэргээс бүтсэнийг ойлгоно гэжээ. Эдгээр түгээмэл, илэрхийлэх утга бүхий нэршил нь барааны тэмдгийн хамгаалалтад орохын тулд арилжаа эрхлэгч энэхүү нэрээ удаан хугацаанд өөрийн бараа, үйлчилгээнд хэрэглэснээр олон нийт энэ нэршлийг тухайн компанийн бизнесийн үйл ажиллагааны итгэлтэй (business goodwill) холбож ойлгох болдог гэжээ. Энэ тохиолдолд шүүхээс тухайн нэрийг барааны тэмдгийн адилаар хамгаалдаг гэжээ. (Margreth Barret, 2008, 904-р тал)

Арилжааны нэр нь илэрхийлэх утга бүхий хүний нэр, ургийн овог, бусад түгээмэл нэршлээс бүрддэг учраас энгийн магадлалаар олон тооны өрсөлдөгчид тухайн үг хэллэгийг өөрсдийн маркетингийн үйл ажиллагаанд ашиглахыг хүсэх ба энэ тохиолдолд тухайн нэрийг ашиглаж буй бизнесийн үйл ажиллагаанд онцгой эрх (exclusive right) олгох нь бусдын эрхийг хязгаарлах магадлалтай. Үүнийг шүүхээс тайлбарлахдаа, англи хэлний үгсийн сан, цагаан толгой, араб тоо зэрэг нь хүмүүний амьд биед нарны гэрэл, ус, агаар зэрэг нь ямар чухал болохыг, өөрийн мэдэрч, ойлгож буй бодол, бодит үнэн зэргийг илэрхийлэхэд зориулагдсан болно. Тиймээс хэн ч эдгээрийг хүмүүнээс салгах боломжгүй, бүгдээрээ тэгш эрх, ашиг сонирхлоор ашиглах хүн төрөлхтний нийтийн өмч юм. Энэхүү усны ундаргаас хэн бүхэн хүртэх боломжтой учраас, хэн нэгэн хүнд онцгой эрх (exclusive right) олгох боломжгүй юм гэжээ. (Margreth Barret, 2008, 906-р тал)

Гэсэн хэдий ч илэрхийлэх утга бүхий арилжааны нэрийг удаан хугацаанд ашигласнаар хоёрдогч утга бүхий барааны тэмдгийн үүргийг гүйцэтгэх болсон үед

тухайн нэрийг өрсөлдөгчийн зүгээс зориудаар хэрэглэгчдийг төөрөгдүүлж, арилжааны нэрийг анхлан эзэмшигчээс өөртөө урвуулах зорилгоор ашиглах тохиолдолд шүүхээс хөндлөнгөөс оролцож хориглох бөгөөд, энэ тохиолдол нь тухайн барааны тэмдгийг эзэмшигчийн өмчийн эрхэд халдаж буй явдал бус өрсөлдөгчийн зүгээс шударга бус хууран мэхлэх үйлдэл хийж буйгаас үүдэлтэй юм. Шүүхээс тайлбарлахдаа хүн бүр нарны гэрлийг хүртэх эрхтэй ч үүнийг хөршийнхөө байшинг шатаахад ашиглах ёсгүй, хүн бүр цаас, бэх, үзэг ашиглах эрхтэй ч үүнийг хуурамч бичиг үйлдэх, мөнгө хувилах, хөршийнхөө хөрөнгийг завшихад ашиглаж болохгүй гэж тайлбарлажээ. (Margreth Barret, 2008, 907-р тал)

Дээр тайлбарласанчлан, АНУ-ын эрх зүйн тогтолцооны хувьд арилжааны нэр болоод барааны тэмдгийг авч ашигласнаар эзэмших эрх үүсэх бөгөөд, хуулийн хамгаалалтын хувьд шүүхийн прецедент болон муж улсуудын хуулийн хувьд арилжааны нэр нь барааны тэмдгийн нэгэн адил хамгаалалтад байна. Харин холбооны барааны тэмдгийн хуульд мөн адил зохицуулагдах хэдий ч онцлог тал нь арилжааны нэрийг бүртгэх зохицуулалт байхгүй боловч барааны тэмдгийг бүртгэх зохицуулалт туссан байдаг. АНУ нь тогтолцооны хувьд ашиглалтад суурилсан зарчим баримталж буй учраас бүртгэл хийлгэсэн эсэхээс үл хамааран барааны тэмдэг болоод арилжааны нэр нь нэгэн адил холбооны хуулийн хамгаалалтад байх бөгөөд барааны тэмдгийг бүртгүүлснээр үүсэх үр дагавар нотолгооны үүргийг гүйцэтгэх явдал юм. Харин арилжааны нэрийг барааны тэмдгээр бүртгүүлж ашиглахад ямар нэгэн саадгүй боловч тухайн нэршил нь бусдаас ялгагдах онцлог шинжтэй байх буюу зохиомол үг эсвэл битүүлгээр санал болгосон үг байх тохиолдолд барааны тэмдгээр бүртгэх боломжтой байдаг. Харин энгийн нэршлийн хүний нэр, ургийн овог бусад илэрхийлэх утга бүхий арилжааны нэрийг бүртгүүлэхийн тулд удаан хугацааны туршид тухайн нэрийг ашигласны дараа тухайн нэрийн хоёрдогч утгыг өөрөө бий болгосон тохиолдолд барааны тэмдгээр бүртгүүлэх боломжтой болдог байна.

### Хүснэгт 3.8. АНУ-ын шүүхийн маргааны хураангуй

No	Бүтэц	Агуулга
1	Танилцуулах хэсэг	Шүүх:АНУ-ын Нью-йорк хотын баруун дистрикт шүүх Шүүгч:LARIMER, District Judge Хэргийн индекс:128/2016/0355/3 Дугаар:Eastman Kodak Co. v. Rakow, 739 F. Supp. 116 (W.D.N.Y. 1989)

		<p>Огноо:1989.08.02</p> <p>Маргааны төрөл:Арилжааны нэрийг бүдгэрүүлэх (dilution) буюу нэр хүндийг унагаасан хэргийн маргаан</p>
2	Үйл явдлын агуулга	<p>Ийстмэн Кодак (Eastman Kodak Company) компанийн зүгээс мэргэжлийн стэндап комедиан Д.Б.Раков (D.B.Rakow)-ын эсрэг компанийн нэрийн олон танигдсан байдлыг бүдгэрүүлж, нэр хүндийг унагаасан хэмээн үзэж нэхэмжлэл гаргасан,</p> <p>Тодруулбал Ийстмэн Кодак компани өнгөрсөн зуу гаруй тухайн арилжааны нэрийг ашиглахын зэрэгцээ КОДАК гэдэг нэрээр олон тооны барааны тэмдгийг бүртгүүлсэн ашиглаж байгаа бол, стэндап комедиан Д.Б.Раков (D.B.Rakow) нь найман жилийн өмнөөс тус компанийн нэрийг өөрийн тайзны нэрд ашиглаж байгаа нь зүй бус буюу компанийн нэр хүндийг унагаж байна,</p> <p>Ялангуяа тус комедиан нь хэт их задгай үг хэллэг ашигладаг төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гутаан доромжилсон хошигнол зэрэг нь өнгөрсөн хугацаанд компанийн зүгээс нийгэмд хандаж хийж бүтээсэн сайн үйлсийн үр дүнг үгүй хийж байгаа тул тус нэрийг ашиглахыг хориглохыг шүүхээс хүссэн,</p>
3	Шийдвэрлэсэн байдал	<p>Шүүхээс Ийстмэн Кодак компани нь өнгөрсөн зуун жилд тус нэрийг ашиглахдаа анх камерын барааны тэмдгээр ашиглаж байсан сүүлд төрлийг нэм одоогоор нэлээн хэдэн төрлөөр ашиглаж байгааг дурдаад өнгөрсөн таван жилийн хугацаанд зар сурталчилгаандаа 1тэрбум ам доллараас дээш хөрөнгө зарцуулсан байна гэжээ,</p> <p>Одоогийн байдлаар АНУ-д 50,000 байршилд бараагаа худалдаж байгаа төдийгүй 1986 оны байдлаар дэлхий даяар борлуулалтын хэмжээ 6 тэрбум, 1987 оны байдлаар 7 тэрбум давсан гэдгийг онцолжээ,</p> <p>Жишгийн эрх зүйд компанийн нэрийг бүдгэрүүлэх (dilution) гэдгийг, барааны тэмдгийн нэр хүндийг уусгах (blurring), болон эерэг нөлөөг бууруулах (tarnishing) хоёр байдлаар авч үздэг бол энэхүү тохиолдол барааны тэмдгийн эерэг нөлөөг бууруулах нөлөөтэй тохиолдол гэж үзэн, хариуцагчийг тухайн нэрийг ашиглахыг хориглох шийдвэр гаргажээ.</p>
4	Дүн шинжилгээ	<p>Дээрх шүүхийн шийдвэр нь барааны тэмдэг болон арилжааны нэрийг жишгийн эрх зүйгээр шийдвэрлэсэн тод жишээ төдийгүй хэрэг шийдвэрлэх гол зарчим болох арилжааны нэрийг бүдгэрүүлэх (dilution) үйлдэл хийгдсэн гэж үзсэн жишээ байна.</p>
5	Эх сурвалж	<p><a href="#">Eastman Kodak Co. v. Rakow, 739 F. Supp. 116 (W.D.N.Y. 1989) :: Justia</a></p>

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар



## Бүлгийн дүгнэлт

БНСУ нь эрх зүйн бүлийн хувьд манай улстай нэг буюу иргэнлэг эрх зүйн бүлд хамаарах төдийгүй ХБНГУ-ын хуулиас ихээхэн рецепци хийсэн учраас хуулийн зохицуулалт нь манай улстай ихээхэн төстэй зохицуулалттай байна. Харин нэг онцлог тал нь төрөлжсөн арилжааны хуультай бөгөөд тус хуульдаа арилжааны нэрийн ойлголт болон арилжааны нэрийн хамгаалалтын зохицуулалтыг тусгажээ. Арилжааны нэр сонгоход чөлөөт зарчмыг сууриа болгож буй хэдий ч тодорхой төрлийн үйл ажиллагаанд үнэн зөв байх зарчмыг баримталж буй учраас холимог зарчимтай гэж үзэж байна. Харин арилжааны нэрийн хамгаалалтын хувьд Америкийн Нэгдсэн улсын эрх зүйн системийн онцлог зохицуулалтуудын заримыг тусган авсан байна. Жишээлбэл, бүртгэлд суурилсан зарчмыг баримталж буй хэдий ч бүртгүүлээгүй арилжааны нэрийг шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэх хуулиар буюу дотоодын зах зээлд олонд танигдсан арилжааны нэр байх аваас бүртгэл хийлгэсэн эсэхээс үл хамааран хамгаалах зохицуулалттай байна. Мөн бүртгүүлээгүй арилжааны нэрийг авч ашиглаж буй жижиг аж ахуйн нэгжүүдийг хамгаалах зорилгоор тухайн нэрийг өөр этгээд барааны тэмдгээр бүртгүүлсэн тохиолдолд өмнө ашиглаж байсан эзэмшигч нь үргэлжлүүлэн ашиглахыг зөвшөөрдөг байна.

БНСУ-ын шүүхээс арилжааны нэртэй холбоотой маргаан шийдвэрлэсэн байдлаас судалж үзвээс арилжааны нэрийн бүртгэлд ижил төсөөтэй нэрс бүртгэгдэж маргаан үүсдэг нь тодорхой байна. Тус улсын арилжааны бүртгэл нь засаг захиргааны нэгж буюу хотын шүүхийн харьяа бүртгэлийн газар дагнан хийдэг тул бүртгэлийн үйлчлэх бүс нутаг тус хотын хэмжээнд хязгаарлагдана. Өөрөөр хэлбэр тус хотод ижил нэрийг, ижил салбарт бүртгэхгүй гэсэн үг юм. Учир нь БНСУ-ын Сөүл зэрэг хотууд нь манай улстай харьцуулахад олон хүн амтай, арилжаа эрхлэгчийн тоо ихтэйгээс нэг компанид нэг нэршлийг давуу эрхтэйгээр олгодоггүй байна. Өөрөөр хэлбэл арилжаа эрхлэгчдийн нэр сонгох чөлөөтэй байдал болон түрүүлж бүртгүүлсэн арилжаа эрхлэгчийн аль алины эрх ашгийг тэнцвэртэйгээр хадгалж шийдвэрлэхийг эрмэлздэг байна:

Харин нийтлэг эрх зүйн бүлд хамаарах гол төлөөлөл болсон АНУ-ын хувьд муж улсуудын түвшинд болон холбооны улсын хэмжээнд өөр өөр хуулиар зохицуулагдаж буй учраас нэгдсэн улсын холбооны хуулийг гол болгон судалж үзвээс, арилжааны нэр сонгох зарчмын хувьд чөлөөтэй сонгож, шилжүүлэх боломжтой байдаг байна. Харин арилжааны нэр болон барааны тэмдгийн хамгаалалтын хувьд ашиглалтад суурилсан зарчим буюу тухайн нэрийг ашигласнаар хуулийн хамгаалалтад багтах тогтолцоотой

байна. АНУ-ын эрх зүйн тогтолцооны бас нэг онцлог шинж нь бичмэл хуулиас гадна шүүхийн прецедентийн эмхэтгэлийг үндсэн эх сурвалж болгож ашигладагтай холбоотойгоор, жишгийн эрх зүйд арилжааны нэр болон барааны тэмдгийг ойлголтын хувьд адилтган үзэх явдал нийтлэг байна. Тухайлбал 1946 онд шинээр батлагдсан АНУ-ын барааны тэмдгийн хууль нь жишгийн эрх зүйд үндэслэн баталсан хууль гэдэг утгаараа арилжааны нэрийг барааны тэмдэгтэй дүйцэхүйц хэмжээнд хамгаалах тухай заалтыг тусгасан байдаг. Мөн түүнчлэн тус хуульд барааны тэмдгийн бүртгэлийн зохицуулалтыг тодорхой тусгасан хэдий ч арилжааны нэрийн бүртгэлийн талаар зохицуулаагүй байна. Өөрөөр хэлбэл барааны тэмдгийг холбооны хэмжээнд бүртгэдэг бол арилжааны нэрийг муж улсуудын түвшинд хийж байна. Шүүхийн практикт барааны тэмдэг болон арилжааны нэр нь бүртгүүлсэн эсэхээс үл хамааран хуулиар хамгаалагдаж буй бөгөөд нэр болон барааны тэмдгийн бүртгэл нь хожим маргаан үүссэн тохиолдолд нотлох баримтын үүрэг гүйцэтгэх төдий хэмээн тайлбарлаж байна.

АНУ-ын шүүхээс арилжааны нэр, барааны тэмдгийн маргаан шийдвэрлэхдээ бичмэл хууль ашиглахаас илүүтэй шүүхийн жишгийг эх сурвалжаа болгодог нь онцлог юм. АНУ-ын жишгийн эрх зүйд арилжааны нэрийн маргаан шийдэхэд гол харгалзаж үздэг зарчим бол арилжааны нэрд халдах байдлыг төөрөгдөл үүсэх (confusion) болон нэр хүндийг бүдгэрүүлэх (dilution) нөхцөл байдал үүссэн эсэхийг харгалзаж шийдвэрлэж байна. Эхнийх нь нэр хүндтэй эсэхээс үл хамааран бүхий л арилжааны нэр, барааны тэмдэгт үүсч болох нөхцөл байдал бол хоёрдох нь нэр хүнд бүхий, олонд танигдсан арилжааны нэр, барааны тэмдгийн нэр хүндийг уусгах буюу бүдгэрүүлэх, унагах нөхцөл байдлыг харгалзаж үзэж хэргийг шийдвэрлэдэг байна.

## ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаандаа арилжааны нэр болон түүний эрх зүйн хамгаалалтыг Монгол улсын өнөөгийн эрх зүйн орчинд хэрхэн зохицуулж буйг судлахын зэрэгцээгээр Дэлхийн бусад улсуудад хэрхэн зохицуулсан байдлыг харьцуулснаар судалж гаргахыг эрмэлзлээ. Харьцуулах улсын хувьд нийтлэг эрх зүйн бүлд хамаарах эдийн засгийн хүчирхэг гүрэн АНУ болон бидний хамгийн ойр гуравдагч хөрш бөгөөд эдийн засгийн нягт хамтын ажиллагаа бүхий иргэнлэг эрх зүйн бүлд хамаарах БНСУ-ын хуулийн зохицуулалтыг судлах зорилт тавьж гүйцэтгэлээ. Энэ нь Монгол улсын арилжааны эрх зүйн хөгжилд багахан ч болов нэмэр болох болов уу гэж санана.

Манай улсын хувьд арилжааны нэрийн холимог зарчим баримталж байх бөгөөд нэрийн хамгаалалтын хувьд бүртгэлд суурилсан зарчим бүхий хууль үйлчилж байна. Өөрөөр хэлбэл арилжааны нэрийг сонгоход чөлөөт зарчмыг суурь болгож байгаа хэдий ч тодорхой төрлийн үйл ажиллагаанд заавал үйл ажиллагааны төрлийг тусгах, мөн хуулийн этгээдийн хэлбэрийг заавал тусгах байдлаар зохицуулж байна. Харин арилжааны нэр ашиглах эрх үүсэх, шилжүүлэх, дуусгавар болгоход бүртгэлд суурилсан зарчмыг баримталж байна.

Мөн манай улсын хувьд хуулийн этгээдийн нэрийн хамгаалалт нь бусад улсуудын нийтлэг жишиг зохицуулалтын адилаар зохицуулагдаж яваа хэдий ч судлаачийн зүгээс үзэхэд арилжааны нэрийн хамгаалалт нь арилжаа эрхлэгчдийн эрх ашиг болон олон нийт, бусад арилжаа эрхлэгчдийн эрх ашгийг тэнцвэртэйгээр хамгаалах зорилго агуулах учраас дараах таван асуудлыг тогтолцоонд шинэчлэлт, өөрчлөлт хийхэд харгалзаж үзэх боломжтой гэж харж байна.

Нэгдүгээрт, арилжааны дагнасан бүртгэлийн тогтолцоог харьяа засаг захиргааны нэгжийн шүүхийн харьяа байгуулж ажиллуулах нь арилжааны нэрийн бүртгэл төдийгүй бусад арилжааны бүртгэлийн талаарх маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх боломжтой юм. Энэхүү тогтолцоог ХБНГУ болон БНСУ бүрдүүлсэн байх бөгөөд өнөөгийн байдлаар манай улсад хуулийн этгээдийн хувийн хэргийн бүртгэл гэсэн хэлбэрээр Улсын бүртгэлийн газарт хийгдэж буй ч энэ зөвхөн компани, нөхөрлөлөөр хязгаарлагдах тул бусад хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийг хамруулсан арилжааны бүртгэлийн тогтолцоог зайлшгүй бий болгох шаардлага үсч байна.

Хоёрдугаарт, БНСУ-ын болон АНУ-ын тогтолцооны давуу талуудыг харгалзан үзэж арилжааны нэр ашиглах эрх үүсэх асуудалд бүртгэлд суурилах боловч, ашиглалтыг харгалзан үздэг тогтолцоог нэвтрүүлэх нь ашигтай болов уу. Учир нь гэвэл 2024 оны

нэгдүгээр улирлын байдлаар статистикийн ерөнхий газрын мэдээллийн сангаас шүүж үзвээс нийт 240,771 Аж ахуйн нэгж бүртгэлтэй байх хэдий ч үүнээс үйл ажиллагаа явуулж буй Аж ахуйн нэгж нь ердөө 97,755 байх юм. Үлдсэн хэсэг болох 143,016 аж ахуйн нэгж нь үйл ажиллагаа эхлээгүй, түр зогссон, бүрэн зогссон, олдохгүй байгаа зэрэг шалтгаантай байна. Үүнээс үзэхэд шинээр үйл ажиллагаа эрхлэх гэж буй арилжаа эрхлэгчдийн хувь арилжааны нэр сонгох сонголтын цар хүрээ тэр хэмжээгээр багасаж, нэрийн ашиглалтын үр ашиггүй байдал үүсгэж байна. Тиймээс бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны нэрийг тодорхой хугацаанд хадгалаад даруй эргэлтэд оруулдаг систем бий болгох нь зүйтэй болов уу.

Гуравдугаарт, арилжааны нэрийн хамгаалалтыг хэт нэг талын эрх ашгийг харгалзаагүй буюу арилжаа эрхлэгч, олон нийт, өрсөлдөгч арилжаа эрхлэгчийн эрх ашгийг тэнцвэртэйгээр хангах хуулийн зохицуулалтыг бий болгох нь чухал юм. Өөрөөр хэлбэл арилжааны нэрийг бүртгүүлж ашиглаж буй этгээдэд тодорхой нэрийг монопол эрхтэйгээр ашиглах эрхийг өгөх нь зохимжгүй юм. БНСУ-ын шүүхийн шийдвэрт тайлбарласанчлан ямарваа нэг оноосон нэрийг (жишээлбэл Дунгбү) нэг компанид давуу эрхтэйгээр ашиглуулж, бусад арилжаа эрхлэгч ашиглахыг хориглох нь тэдний эрх ашгийг хязгаарлаж буй явдал учир тухайн нэрийн өмнө эсвэл хойно өөр оноосон нэр орсон тохиолдолд олгох нь зүйтэй юм. Манай улсын хувьд тус зарчмаар хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулж байгаа юм.

Дөрөвдүгээрт, БНСУ-ын тогтолцооны адил бичил арилжаа эрхлэгчийг хамгаалах зохицуулалтуудыг оруулж өгөх шаардлагатай юм. Тус улсын арилжааны хуульд бичил арилжаа эрхлэгчид тус хуулийн аливаа зохицуулалтууд хамаарахгүй гэсэн байх бөгөөд арилжааны нэрийн хувьд ч бичил арилжаа эрхлэгчид аливаа нэрийг чөлөөтэй сонгож ашиглах эрхтэй гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл томоохон аж ахуйн нэгжийн зүгээс аливаа нэрийг арилжааны нэр болон барааны тэмдгээр бүртгүүлснээс хойш бусад бичил арилжаа эрхлэгчийг тус нэрийг ашиглахыг хориглох аваас хуулийн тус заалт нь үйлчлэхгүй гэсэн үг юм. Энэ нь жижиг болон бичил арилжаа эрхлэгчдийн хувьд хуулийн мэдлэг дутуу, арилжааны нэр болон барааны тэмдгийн тухай ойлголтгүйгээс арилжааны нэрийг авч ашиглаад удсан хэдий ч бүртгүүлэлгүй явж байгаад нэг л өдөр өөр нэгэн этгээд тус нэрийг ашиглахыг хориглохыг шаардах нөхцөл байдал үүсч, наад зах нь дэлгүүрийн хаяг солих болон хоолны газрын меню өөрчлөх зэргээр ихээхэн хохирол учирдаг байдлыг харгалзан үзсэн зохицуулалт юм.

Тавдугаарт, арилжааны нэрийн бүртгэл, баталгаажуулалтын давхцалыг бусад улсуудын хувьд зах зээл том, хүн ам олон учраас тухайн засаг захиргааны нэгжийн хүрээнд хязгаарлаж байна. Манай улсын хувьд эдийн засгийн том биш, гол төв нийслэл Улаанбаатар хотод нийт аж ахуйн нэгжүүдийн дийлэнх хувь нь үйл ажиллагаа явуулдаг учраас нийслэл хот болон орон нутаг гэсэн хэлбэрээр хамгаалалтын хамрах цар хүрээг тогтоож болох юм. Ингэснээр нийслэлд бүртгэлтэй арилжааны нэрийг нийслэлд дахин олгохгүй хэдий ч орон нутагт жишээлбэл Завхан аймагт олгож болохоор зохицуулалтыг хийвэл арилжаа эрхлэгчдийн нэр сонгох сонголт нь харьцангуй нэмэгдэх юм. Нөгөөтээгүүр үйл ажиллагаа явуулах бүс нутгийг маш тодорхой хүрээнд хязгаарлах нь зүйтэй болов уу.

Дээрх зохицуулалтуудыг судлаачийн зүгээс бүртгэлд суурилсан хамгаалалтын зарчмын сул талыг нөхөх зорилгоор ашиглалтад суурилсан зарчмын зарим нэг давуу талуудыг харгалзаж үзэхийн хамтаар, арилжаа эрхлэгчдийн арилжааны нэр сонгох сонголтыг илүү чөлөөтэй болгох зорилго агуулан бичсэн болно.

## НОМ ЗҮЙ

### Монгол хэл дээрх

1. Амарсанаа, Б. (2014). Харьцуулсан эрх зүй судлал. МУИС пресс. Улаанбаатар.
2. Амарсанаа, Б. Батбаяр, С. (2022). Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой маргаан шийдвэрлэж буй шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдал. Нээлттэй Нийгэм Форум. Шүүхийн шийдвэрийн судалгаа Цуврал Б.
3. Амрасанаа, Б. Г. Д. Н. Н. Р. П. нар (2022). Арилжааны эрх зүй. Анхны хэвлэл. Соёмбо принтинг. Улаанбаатар.
4. Буянхишиг, Б. (2021). Иргэний эрх зүйн удиртгал. Соёмбо принтинг. Улаанбаатар.
5. Агар-эрдэнэ, Г. (2013). Өмчлөх эрхийн сэтгэлгээний түүхэн асуудал. Хүний Эрх сэтгүүл. Дугаар 2.
6. Давааням, Г. (2022). Арилжааны эрх зүйн байр суурь, онцлог. Арилжааны Эрх Зүй. Соёмб принтинг. Улаанбаатар.
7. Дүгэржав, Д. (1998). Бизнесийн эрх зүй. Соёмбо принтинг. Улаанбаатар.
8. Баярмаа, Н. (2000). Аж ахуйн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын нэр томъёоны асуудал. <https://legaldata.mn/b/313>
9. Норовсамбуу, Н. (2022). Арилжааны нэр. Арилжааны Эрх Зүй. Соёмб принтинг. Улаанбаатар.
10. Нарангэрэл, С. (2001). Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. МУИС, ШУА. Адмон. Улаанбаатар
11. Мөнхжаргал, Т. (2000). Бизнесийн эрх зүй. Адмон принтинг. Улаанбаатар.
12. Ханнс Зайделийн Сан. (2019). Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан. Эрх Зүйн Боловсрол Академи. <https://legaldata.mn/b/519>
13. Хууль зүйн үндэсний хүрээлэн. (2018). Хууль зүйн шинжлэх ухааны судалгааны арга зүй (Гарын авлага). Хууль зүйн үндэсний хүрээлэн.
14. Нямсүрэн, Ч. (2021). Эрх зүйн ерөнхий онол. Мөнхийн үсэг. Улаанбаатар. Гуравдах хэвлэл.
15. Батпүрэв, А. Эдийн засгийн ухаан ба Философи. <https://batpurev.com/>
16. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц. 1883. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1194>
17. Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр. 1994. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1205>
18. Оюуны өмчийн тухай хууль. 2020. <https://legalinfo.mn/mn/detail/15356>

### Англи хэл дээрх

1. U.S. Trademark Law, § 45 (15 U.S.C. § 1127) (2013).
2. William M. Landes and Richard A. Posner. (1989). An Economic Analysis of Copyright Law, <https://www.jstor.org/stable/3085624>
3. Aoki, K. (1993). Authors, Inventors and Trademark Owners: Private Intellectual Property and the Public Domain - Part II. Columbia-VLA Journal of Law & the Arts, 18.

- <https://heinonline.org/HOL/Page?handle=hein.journals/cjla18&id=197&div=&collection=>
4. Carter, S. L. (1990). The Trouble with Trademark. The Yale Law Journal, 99 (4), 759. <https://doi.org/10.2307/796637>
  5. Doellinger, C. A New Theory of Trademarks. <https://papers.ssrn.com/abstract=981414>
  6. Maverick, J. B. (2022). Trade Name vs. Trademark: What's the Difference? [www.investopedia.com](http://www.investopedia.com).
  7. Naser, M. A. (2007). Rethinking the Foundations of Trademarks. Buffalo Intellectual Property Law Journal, 5 (1).
  8. World Intellectual Property Institution. (2020). What is intellectual property? WIPO Publication No. 450E/20
  9. World Intellectual Property Institution. (2016). Understanding Industrial Property. WIPO Publication No. 895E
  10. World Intellectual Property Institution. A History of Trademarks: from the Ancient World to the 19th Century. [https://www.wipo.int/podcasts/en/madrid/transcripts/international\\_trade\\_mark\\_system\\_talk\\_01.html](https://www.wipo.int/podcasts/en/madrid/transcripts/international_trade_mark_system_talk_01.html)

#### **Солонгос хэл дээр**

1. 김재두. (2020). 상호의 보호에 관한 법적 소고. 경영법률, 30 권 3 호.
2. 손영식. (2014). 우리나라 상표보호제도의 개선방안에 관한 연구. 한남대학교.
3. 오재상. (2015). 상호와 상표에 관한 연구. 충남대학교.
4. 장현승. (2008). 상호상표의 법률적 문제. 충남대학교,
5. 전현율. (2005). 상호권 보호에 관한 연구. 단국대학교.
6. 한국 특허청. (2006). 미국 상표법·제도에 관한 분석 및 시사점. 유미특허법인.
7. 부정경쟁방지및영업비밀보호에 관한법률. <https://www.law.go.kr/>.
8. 상법. <https://www.law.go.kr/>.
9. 상업등기법. <https://www.law.go.kr/>.